



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛӨЛ

Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах нь

Гарын авлага

Улаанбаатар хот
2014 он



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛӨЛ

Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах нь

Гарын авлага

Зохиогчид:

Б.БАТХИШИГ

Хууль зүйн магистр, хуульч, өмгөөлөгч

Д.АМАРЖАРГАЛ

Хүний эрхийн магистр

Хянан тохиолдуулсан: Ц.ЦОГТ

МУИС–ын Хууль зүйн сургуулийн багш, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч

Н.ТУЯА

МУИС–ийн Хууль зүйн сургууль, Практик сургалтын тэнхимийн эрхлэгч

Б. ХИШИГСАЙХАН

ННФ–ын Засаглалын хөтөлбөрийн менежер, Хүний эрхийн магистр

Ж.НАРАНТУЯА

“Юрис Консалтус” ХХК–ийн партнер, хуульч

©2014, Нээлттэй Нийгэм Форум

Энэхүү номыг хэсэгчлэн болон бүтнээр нь хувилж олшруулах, дахин хэвлэхийг хүсвэл дараах хаягаар хандан зохих зөвшөөрөл авна уу.

Хаяг:

Жамъян гүний гудамж – 5/1

Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар – 14240

Монгол Улс

Утас: 976–11–313207

Факс: 976–11–324857

Вэб: www.forum.mn

И–мэйл: osf@forum.mn

АГУУЛГА

ТОВЧЛОЛ	7
----------------------	----------

БҮЛЭГ 1.

СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛӨЛ	8
----------------------------------	----------

1.1 СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛЛИЙН ОЙЛГОЛТ, ҮР НӨЛӨӨ.....	8
--	---

1.1.1 Стратегийн өмгөөллийн тухай ойлголт.....	8
--	---

1.1.2 Стратегийн өмгөөлөл гэж юу вэ?.....	11
---	----

1.1.3 Стратегийн өмгөөллийн ач холбогдол, үр нөлөө	13
--	----

1.2 СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛӨЛ ЦОГЦ ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОХ НЬ.....	15
---	----

1.2.1 Өмгөөлөл, шүүхийг стратегийн өмгөөлөлд ашиглах нь	15
---	----

2.2.2 Нөлөөллийн үйл ажиллагааг стратегийн өмгөөлөлд ашиглах нь	19
--	----

1.3 СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛӨЛ БА ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА.....	21
---	----

1.3.1 Монгол Улс дахь стратегийн өмгөөлөл	21
---	----

1.3.2 АНУ дахь стратегийн өмгөөлөл.....	26
---	----

1.3.3 Төв болон Зүүн Европ дахь стратегийн өмгөөлөл	27
---	----

1.3.4 Австрали Улс дахь стратегийн өмгөөлөл	29
---	----

БҮЛЭГ 2.

СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛӨЛ ХИЙХ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨМЖ	32
---	-----------

2.1 СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛЛИЙН ХЭРЭГ СОНГОХ НЬ.....	32
--	----

2.1.1 Стратегийн өмгөөлөл хийх шийдвэр гаргах нь.....	32
---	----

2.1.2 Стратегийн өмгөөллийн хэрэг сонгох шалгуур.....	34
---	----

2.2 СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛӨЛ ХИЙХ ПРАКТИК АЛХАМ, АНХААРАХ АСУУДАЛ	39
---	----

2.2.1	Стратегийн өмгөөлөл хийхэд анхаарах хүчин зүйлс	39
2.2.2	Стратегийн өмгөөлөл хийхэд тулгарч болох бэрхшээл	51
2.3	СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛЛИЙГ ҮНДЭСНИЙ БОЛОН НҮБ–ЫН ТҮВШИНД ХИЙХ НЬ	57
2.3.1	Стратегийн өмгөөллийг үндэсний түвшинд хийх нь	57
2.3.2	Стратегийн өмгөөлөлд НҮБ–ын арга, журмыг ашиглах нь	59

БҮЛЭГ 3.

СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛЛИЙН ХЭРЭГ СУДЛАЛ

3.1	БУСАД УЛС ОРНЫ СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛЛИЙН ХЭРЭГ	65
3.1.1	Штукатуров: Шүүхэд хандах эрх	65
3.1.2	Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, түүний нэмэлт протокол: Эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрх	71
3.1.3	Америкийн Нью–Йорк муж дахь боловсролын эрхийн хэрэг	77
3.2	МОНГОЛ УЛСЫН СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛЛИЙН ХЭРЭГ	80
3.2.1	Хууль сахиулах байгууллагын ажилтны буруутай үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг шүүхээр барагдуулах	80
3.2.2	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, алдар хүндийг хүндэтгэх	83
3.2.3	Байгаль орчны хохирлыг гэм буруутэй этгээдээс гаргуулах	89
3.2.4	Оршин суух газраа чөлөөтэй сонгох, ялгаварлан гадуурхалтаас ангид байх	94
3.2.5	Эрүүл, аюулгүй орчинд амьдрах	97

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

103

ӨМНӨХ ҮГ

Нээлттэй Нийгэм Форум нь стратегийн өмгөөллийг цааш нь гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд тус нэмэр болох зорилгоор энэ сэдвээр хоёрдахь гарын авлагыг санхүүжүүлж, боловсруулан гаргаж байна. 2006 онд нийтийн хүртээл болгосон “Стратегийн өмгөөлөл” гарын авлага нь энэ сэдвээрх монгол хэлээр гарсан анхны эх сурвалж болсон юм. Энэ удаа уншигч, хэрэглэгчдийн хүсэлт, стратегийн өмгөөллийн хөгжил, ахиц дэвшилтэй холбогдуулан уг гарын авлагыг дахин боловсрууллаа. Гарын авлага нь стратегийн өмгөөллийн тухай ойлголт, арга зүйн зөвлөмж болон хэрэг судлал гэсэн бүлгүүдтэй ба хэрэг судлал бүлэгт Монгол Улсад амжилттай хэрэгжсэн стратегийн өмгөөллийн хэргийг түлхүү орууллаа. Энэ чиглэлээр цааш нь гүнзгийрүүлэн судлах хүсэлтэй хүмүүст тус нэмэр болох үүднээс гадаад, дотоодын гол эх сурвалж, тэргүүлэх хэргүүдийг мөн оруулав.

Монгол Улсад нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах хэрэгцээ улам бүр өсөн нэмэгдэж байна. Хэдийгээр стратегийн өмгөөлөл хийгдэж эхлээд 10 гаруй жил өнгөрч байгаа ч стратегийн өмгөөлөл хийх эрх зүйн орчин дутмаг, боловсон хүчин хангалттай бэлтгэгдээгүй, энэ чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл ховор зэрэг тулгамдаж буй асуудал оршсоор байна. Гэсэн хэдий ч нийтлэг ашиг сонирхол, нийгмийн эмзэг бүлгийн эрх, эрх чөлөөг шүүхэд нэхэмжлэн хамгаалах чиглэлээр төрийн бус байгууллага, өмгөөлөгчид идэвх санаачлагатай ажиллаж ирснийг тэмдэглэх нь зүйтэй. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах, тус гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин бүрдүүлэх, иргэний нийгмийн байгууллагууд байгаль орчны хохирлыг нэхэмжлэх эрх үүсэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох,

Монгол Улсын иргэд Үндсэн хуулиар баталгаажсан оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхээ бүрэн эдлэхэд стратегийн өмгөөлөл чухал үүрэг гүйцэтгэснийг онцлон тэмдэглэхэд таатай байна.

Энэхүү гарын авлагыг боловсруулахад мэдлэг туршлага, цаг заваа харамгүй зориулсан Д.Амаржаргал, Б.Батхишиг нарт гүн талархал илэрхийлье. Мөн гарын авлагын бүтэц, агуулгыг тодорхойлох, сайжруулах хэлэлцүүлгүүдэд идэвхтэй оролцож, санал бодлоо хуваалцсан өмгөөлөгчид, практик ажилтнууд болон хянан тохиолдуулсан хүмүүст талархсанаа илэрхийлье.

Стратегийн өмгөөлөл нь нийтийн эрх ашгийг эрхэмлэсэн төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх хөшүүрэг болж, хууль зөрчсөн албан тушаалтанд хариуцлага тооцох боломж олгодог билээ. Энэхүү гарын авлага нь нийтийн эрх ашгийг шүүхээр нэхэмжлэн хамгаалах үйлсэд тус нэмэр болно гэдэгт найдаж байна.

П.Эргэнэжаргал

Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх Захирал

ТОВЧИЛСОН ҮГ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АХХ	Америкийн хуульчдын холбоо
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ХМХ	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл
ХЭҮК	Хүний эрхийн Үндэсний Комисс

БҮЛЭГ 1.

СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛӨЛ

1.1 СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛЛИЙН ОЙЛГОЛТ, ҮР НӨЛӨӨ

1.1.1 Стратегийн өмгөөллийн тухай ойлголт

Стратегийн өмгөөллийн тухай танилцуулахаас өмнө стратеги болон өмгөөлөл гэсэн үгийн тайлбарыг хийе.

"Стратеги" хэмээх үг нь "strategos" хэмээх грек үгнээс гаралтай, "генералын урлаг буюу удирдагч" гэсэн утгатай үг бөгөөд анх цэрэг дайны, тагнуулын үйл ажиллагаанд хэрэглэж байсан бол эдүгээ шинжлэх ухааны гол судлагдахуун болтлоо хөгжсөн байна. Түүнчлэн "strategy" хэмээх англи хэлнээ бичигдсэн үг нь байлдааны "Бодлого, аюулгүй байдал, баталгаа, хамгаалал, итгэл, санасандаа хүрэхийн тулд хэрэглэх арга, ов мэх, хандлага, арга барил" гэсэн утгыг, "strategic" гэх үг нь "чухал, шуурхай" гэсэн утгыг илэрхийлдэг.¹

"Өмгөөлөл" ("advocacy", "defense") гэдэг ойлголт нь латины "adere"—үйлчлэх үйл явц, "ad defendendum" няцаалт, хамгаалалт гэсэн үгнээс гаралтай бөгөөд гнесологи, эрх зүйн утгын хувьд хүний жам ёсны салшгүй эрхийг хасах, хязгаарлах явдлыг үгүйсгэх, хүний эрхэм чанар, халдашгүй байдлыг хамгаалах, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлынтөлөөүйлчлэх, нотолгооны цагаатгах үйл явцыг хангахад чиглэгдсэн хууль зүйн туслалцаа, үйлчилгээ, хамгаалалтын цогц систем юм.² Энэ ойлголт нь нэг

¹ Википедиа цахим толь, (2013 оны 12 сар) <<http://en.wikipedia.org/wiki/Strategy>>

² Хүний эрх хөгжил төв, Америкийн хуульчдын холбоо болон Н.Туяа, "Хэрэг судлал: Хүн худалдаалах гэмт хэрэг ба өмгөөлөл" (Хуульчдад зориулсан гарын авлага), УБ, 2012 он, 4 дэх тал

талаас тухайн этгээд өөрөө өөрийгөө хамгаалах буюу өмгөөлөх, нөгөө талаас тухайн этгээдийн хүсэлт, зөвшөөрлөөр эрх бүхий өмгөөлөгч хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх замаар өмгөөлөх үйл ажиллагаа явуулах гэсэн агуулгын аль алийг илэрхийлэх боловч шууд утгаараа сүүлийн нөхцөл нь голлох хэлбэр болно.³

Өмгөөлөл нь яах аргагүй хууль зүйн туслалцаа авах эрх мөн бөгөөд энэ эрхийг хангахын тулд өмгөөлөгчөө чөлөөтэй сонгох, зарим онцгой тохиолдолд түүнийг үнэ төлбөргүй авах боломжийг хуульчлан баталгаажуулсан байх нь чухал юм. Монгол Улсын хувьд дээрх хоёр ойлголт тус тусдаа өөр өөрийн салбарын хүрээнд судлагдаж ирсэн. Стратеги хэмээх ойлголтыг 1960—аад оноос эхлэн судалж, хэрэглэж эхэлсэн бөгөөд олон эрдэмтэн, судлаачид түүний утга агуулгыг өөр өөрийн үзэл баримтлалаар тодорхойлон боловсруулж зохих бүтээлдээ тусгасан байна. Харин өмгөөллийг Өмгөөллийн байгууллагын үүсэл хөгжилтэй хамтад нь авч үздэг. Өөрөөр хэлбэл, 1927 онд Шүүн таслах газруудад аливаа хэргийг байцаан шийтгэх тухай хууль батлагдсантай холбоотой юм. Энэ хуулийн 66 дугаар зүйлд тэр үед төлөөнөө заалдагч нэртэй байсан өмгөөлөгч нь өмгөөлүүлэх хүнийхээ хэрэгтэй урьдчилан танилцаж, тусгайлан уулзаж байх эрхээр хангагдана гэж заажээ.

Сүүлийн жилүүдэд стратеги, өмгөөлөл хэмээх энэ хоёр үгийг хамтад нь хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих үйл ажиллагаанд цогц байдлаар хэрэглэх нь түгээмэл болжээ. Энэ утгаараа стратегийн өмгөөллийг жишиг хэргээр дамжуулан хууль тогтоомжийг боловсронгуй болгох, тогтолцоог шинэчлэх, нийгэмд тогтсон сөрөг хандлага, практикийг халах зорилгоор хувь хүн, мэргэшсэн байгууллага, хүний эрхийн зүтгэлтэн болон хуульчдаас нийгмийн сайн сайхны төлөө хийж буй өмгөөлөл, нөлөөллийн цогц үйл ажиллагаа гэж ойлгож болно. Энэ талаарх ойлголт, тодорхойлолтыг гарын авлагын “Стратегийн өмгөөлөл гэж юу вэ?” хэсгээс дэлгэрэнгүй үзнэ үү.

Стратегийн өмгөөллийг мөн “нөлөөллийн өмгөөлөл”, “шалгуур хэргийн өмгөөлөл”⁴, “нийтийн эрх ашгийн өмгөөлөл” гэх зэргээр нэрлэх явдал байдаг бөгөөд аль нь ч байсан нийгмийн амьдралын сайн сайхны төлөө нэгэн зорилгод л хэрэглэгддэг.

³ Хүний эрх хөгжил төв болон бусад, зүүлт 2, 14–15 дахь тал.

⁴ Test case гэдгийг шалгуур хэрэг гэж орчуулан хэрэглэв.

Стратегийн өмгөөллийн томъёолол улс орон бүрт харилцан адилгүй. Тухайлбал, Энэтхэг, Америкийн Нэгдсэн Улс (АНУ), Австрали Улсад “нийтийн эрх ашгийг хамгаалах” тухай ойлголт илүү дэлгэрсэн. Стратегийн өмгөөллийг хүний эрхийг хамгаалах, хууль зүй, нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэлтийг хийх зорилгоор эхлүүлдэг. Мөн нийгмийн эмзэг, орлого багатай хүмүүсийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг шүүхэд төлөөлөх, хууль зүйн туслалцаа үзүүлэх зэрэгтэй холбон тайлбарлах тохиолдол ч байна. Энэ үүднээс зарим үед стратегийн өмгөөллийг “Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах” гэж нэрлэх нь бий.⁵ Монгол Улсад сүүлийн жилүүдэд нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах ойлголт илүү эрч хүчтэйгээр дэлгэрч байна. Энэ тухай гарын авлагын “Стратегийн өмгөөллийн үүсэл хөгжил” хэсгээс дэлгэрэнгүй үзнэ үү.

Стратегийн өмгөөллийг ихэнхдээ “нөлөөллийн өмгөөлөл” хэмээн ойлгож, тодорхойлдог. Тодруулбал, тухайн хэрэгтэй холбоотой нөлөөллийн үйл ажиллагаа нь нийгэмд өргөн цар хүрээтэй өөрчлөлтийг авч ирэх ач холбогдолтой. Нөлөөллийн өмгөөллийг хоёр үндсэн чиглэлээр хийдэг. Нэгдүгээрт, шүүхэд ялалт байгуулах зорилго бүхий нөлөөлөл; Хоёрдугаарт, хэргээр дамжуулан нийгэмд өөрчлөлт авчрахын тулд хийх нөлөөлөл юм. Энэ тухай гарын авлагын “Стратегийн өмгөөлөл цогц үйл ажиллагаа болох нь” хэсгээс дэлгэрэнгүй үзнэ үү.

Нөгөөтэйгүүр, стратегийн өмгөөлөл нь хууль зүйн үйлчилгээ, туслалцаа мөн. Стратегийн өмгөөлөл бол ердийн хууль зүйн үйлчилгээ үзүүлдэг ухагдахуунаас ялгаатай ойлголт гэдгийг анхаарах шаардлагатай. Стратегийн өмгөөлөлтэй харьцуулахад ердийн өмгөөлөл нь тодорхой нэг эрх ашиг нь хөндөгдсөн этгээдийн эрхийг сэргээх зорилго бүхий байдаг бөгөөд тэр зорилго нь биелэгдсэнээр ердийн өмгөөлөл амжилттай болдог. Харин стратегийн өмгөөлөл нь хэдийгээр тодорхой этгээдийн буюу шалгуур хэргийн тусламжтайгаар өмгөөллийн ажиллагаа явагдаж буй боловч зорилго нь зөвхөн тэр хүний, эсхүл хэргийн шийдэл биш олон тооны ижил нөхцөлтэй этгээдийн асуудлыг цаг хугацаа, хөрөнгө хүч, хохиролгүйгээр шийдвэрлүүлэх жишиг тогтоодгоороо онцлог юм.

⁵ Эдвин Рекош, Кайра А.Бучко болон Вессела Терзева, “Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах нь” (Хуульчид, идэвхтнүүдэд зориулсан гарын авлага), Нью-Йорк, 2001 он, 82 дахь тал.

Дээрх өмгөөллийн хэлбэрүүд нийтийн сайн сайхны төлөөх үйлчилгээ бөгөөд нийгмийн аль ч салбарт стратегийн өмгөөлөл хийж болно. Өөрөөр хэлбэл, олон нийтээс шаардаж буй эрх зүйн шинэтгэл хийх хэрэгцээ нь стратегийн өмгөөлөл хийх үндэслэл, шалтгаан болдог. Энэ утгаараа хүний эрхийг хамгаалах, нийгэмд шударга ёсыг тогтоох хүчин чармайлтыг нийтийн эрх ашгийн төлөө ажилладаг байгууллага, хувь хүмүүс, хуульчид тэргүүн эгнээнд тавьдаг.

1.1.2 Стратегийн өмгөөлөл гэж юу вэ?

Өмгөөлөл нь хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих арга механизмуудын нэгэн үр дүнтэй төрөл мөн бөгөөд иргэд, хуулийн этгээд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн тохиолдолд өмгөөлөгчид хандан зөрчигдсэн эрхээ хамгаалуулахаар хууль зүйн туслалцаа авдаг. Та бидний мэдэх ердийн өмгөөлөл нь тодорхой нэг хувь хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуулийн хүрээнд хамгаалан өмгөөллийн гэрээнд дурдсан алхмуудыг хийснээр дуусгавар болдог бол стратегийн өмгөөлөл нь хоёр хувь этгээдийн хоорондын зөрчил маргаан бус харин хувь хүний эрхийн зөрчлөөр дамжуулан нийтлэг эрх ашгийг хамгаалан ажиллаж, тэрхүү өмгөөллийн явцад тулгарсан асуудал, бэрхшээл, фактад үндэслэн хууль, шүүхийн тогтолцоо болон шүүхийн бус арга хэрэгслийг ашиглан нийгэмд байгаа зөрчил, дутагдлыг илрүүлж, тэдгээрийг өөрчлөх, сайжруулах санал, санаачилгыг гаргадаг. Ингэснээрээ стратегийн өмгөөлөл нь хүний эрх, олон нийтийн эрх ашгийг хамгаалахад ердийн өмгөөллөөс илүү үр дүнтэй. Тийм ч учраас стратегийн өмгөөллийг гадаадын олон оронд хүний эрхийг хамгаалах, нийгэм, эрх зүйн хэм хэмжээг өөрчлөх, сайжруулах үр дүнтэй хэрэглүүр болгон ашиглаж байна.

Стратегийн өмгөөлөл нь олон талын үйл ажиллагааг багтаасан нарийн төлөвлөгдсөн үйл явц юм. Тодруулбал, стратегийн өмгөөлөл нь нарийн шалгуураар сонгон авсан жишиг хэргээр дамжуулан төрийн бодлого, хууль, нийгэмд тогтсон сөрөг хандлагыг өөрчлөх, хуулийн хэрэгжилтийг хангах, төрийн байгууллага, албан тушаалтнуудын хүний эрх, нийтийн эрх ашгийн төлөөх хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор хийгддэг өмгөөлөл, нөлөөллийн үйл ажиллагааны цогц юм. Петер Рийдинг стратегийн өмгөөлөл, нөлөөллийн үйл ажиллагааны

хүрээнд стратегиа төлөвлөх, нөлөөлөл нь өргөн хүрээнд тархсан байх, нөөцийг үр дүнтэй ашиглах гэсэн гурван шинжийг тодорхойлжээ.

1. Стратеги төлөвлөгөөг тодорхойлох гэдэгт мэдээлэл, факт цуглуулах, судалгаа хийх, хэрэг сонгох ажлууд орно.
2. Нөлөөлөл нь өргөн хүрээнд тархсан байх гэдэгт нийгэмд өөрчлөлт, шинэчлэлтийг бий болгох, тухайлбал, хүний эрхийн биелэлтийг хангах зэргийг ойлгоно.
3. Нөөцийг үр дүнтэй ашиглах гэдэгт хязгаарлагдмал нөөцтэй ч тодорхой үр дүнд хүрэхийг хэлнэ.

Тодруулбал, стратегийн өмгөөллийн үйл ажиллагааны стратеги нь шүүхээр хамгаалах, хууль тогтоомж, эрх зүйн бусад актыг шинэчлэх болон бодлогын гэсэн хүрээнд хэрэгждэг байна.⁶ Үүнд:

- Шүүхээр хамгаалах стратеги: Нийтийн буюу зорилтот бүлгийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалан шүүхэд төлөөлөх, үйлчилж буй хуулийн хүрээнд өмгөөллөөр дамжуулан зөрчигдсөн эрхийг сэргээх, түүний хэрэгжилтийг дэмжих үйл ажиллагаа юм.
- Хууль тогтоомж, эрх зүйн бусад актыг шинэчлэх стратеги: Шүүхээр амжилттай шийдвэрлүүлсэн жишиг хэргүүдийг ашиглан хуулийн хэм хэмжээ, хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг өөрчлөх, боловсронгуй болгоход нөлөөлнө.
- Бодлогын шинжтэй стратеги: Шинэтгэл нь зөвхөн хуулийн байгууллагын тогтолцоо, эрх зүйн хүрээгээр хязгаарлагдахгүй, улмаар нийгмийн бусад хүрээг хамран төрийн болон нийгмийн бүлгүүдийн харилцан хамаарлыг өөрчлөх, бодлогын шинжтэй үр дүнд хүрэхэд мөн чиглэдэг.

⁶ Нээлтэй Нийгэм Форум, "Стратегийн өмгөөлөл: Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах нь" (Өмгөөлөгчдөд зориулсан гарын авлага), УБ, 2006 он, 7 дахь тал.

1.1.3 Стратегийн өмгөөллийн ач холбогдол, үр нөлөө

Стратегийн өмгөөлөл нь хууль тогтоох үйл явц, олон нийтийн санаа бодол, улмаар аливаа шинэчлэл, өөрчлөлтөд хөтөлж чаддаг. Стратегийн өмгөөллийн эцсийн зорилго нь нийтийн эрх ашигт нийцүүлэн нийгэм, тогтолцоог шинэчлэх болон эрх зүйн орчныг өөрчлөх явдал юм. Амжилттай хэрэгжсэн стратегийн өмгөөллийн эцэст дараах үр дүнд хүрч болно.

Эрх зүйн шинэчлэл хийх: Стратегийн өмгөөллийн зайлшгүй нэг зорилго бол үйлчилж буй хуулийн хэрэгжилтийг сайжруулах, шаардлагатай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах явдал юм. Энэ нь хуулийг хэрэглэх, тайлбарлах, хэрэгжилтийг хангах, эсхүл сайжруулах буюу шинэ хууль боловсруулах зэрэг зорилтуудтай.

- *Хуулийн хэрэгжилтийг хангах:* Стратегийн өмгөөллийн ихэнх хэргүүд нь огт хэрэгждэггүй, эсхүл буруу хэрэгждэг хуулийн заалтыг зөв, нэг мөр хэрэгжүүлдэг болгох асуудлыг шүүх, нийгмийн өмнө гаргаж тавьдаг.
- *Хуулийг хэрэглэх, тайлбарлах:* Дээр дурдсанчлан стратегийн өмгөөллийн ихэнх хэрэг нь хэрэгжилт султай хуулийн хүрээнд явагддаг бөгөөд өмгөөллийн явцад хуулийг хэрхэн хэрэглэх талаар тайлбарлах, тэдгээрийг нэг мөр, зөв ойлгон хэрэглэдэг болох хэрэгцээ, шаардлага байгааг илрүүлдэг.
- *Хуулийг боловсронгуй болгох:* Ихэнх тохиолдолд стратегийн өмгөөллийн хэргээр дамжуулан бодлого, хуулийн хийдлийг ил болгодог. Өөрөөр хэлбэл, төр, эсхүл хэргийн хариуцагч талын бодлогод өөрчлөлт оруулах, ингэснээр тэдгээр зөрчилтэй хууль, дүрэм, журам болон баримт бичгийг боловсронгуй болгох ач холбогдолтой.

Нийгэмд өөрчлөлт, шинэчлэл авчрах, олон нийтийн хандлагыг өөрчлөх: Стратегийн өмгөөлөл нь хүмүүсийн үзэл бодол, хандлагад нөлөөлөх зорилготой. Хууль, шүүхийн байгууллага, хууль тогтоогчдын анхаарлыг тодорхой нэг асуудалд хандуулах замаар түүнтэй холбогдох бүхий л арга хэмжээг авахуулах зорилгоор стратегийн өмгөөллийг хэрэглэдэг. Үүний үр дүнд хуулийн хэрэгжилт сайжрах, шинэ хууль, дүрэм, журам бий болох; өөрөөр хэлбэл, тодорхой тогтолцоог шинэчлэх, эсхүл аливаа өөрчлөлтөд уриалан дуудах шалтгаан болдог.

- *Нийгмийн институцийг шинэчлэх:* Стратегийн өмгөөллийн шийдвэр нь тогтолцоонд өөрчлөлтийг авчирдаг. Төрийн байгууллага, албан тушаалтныг хариуцлагатай болгох, тэдний бодлого, үйл ажиллагааг өөрчлөх, шинэ хөтөлбөр батлан гаргаж хэрэгжүүлэх зэрэг өөрчлөлтийг бий болгодог.
- *Нийгэм, улс төрийн өөрчлөлтөг уриалан гуудах:* Стратегийн өмгөөлөл нь нийгэмд тогтсон сөрөг хандлага, практикийг халах, түүнд нөлөөлөх зорилготой байдаг. Тиймээс стратегийн өмгөөлөл хийж буй өмгөөлөгчид нь хууль, шүүхийн практикт болон нийгэмд бүхэлд нь нөлөөлөхийн тулд шүүх эрх мэдлийн байгууллага болон олон нийтийн анхаарлыг тухайлсан нэг асуудалд хандуулахад чиглэсэн ажиллагааг явуулдаг.

Стратегийн өмгөөлөл нь тогтолцоо, хандлагыг өөрчлөх, хуулийг боловсронгуй болгоход нөлөөлдөг. Тиймээс шүүхийн танхимд ялаагүй ч шүүхийн бус арга хэрэгслийг ашиглан хууль, нийгэмд өөрчлөлт, шинэчлэлтийг авчирч чадвал стратегийн өмгөөлөл нь тавьсан зорилгодоо хүрсэн гэсэн үг юм.

1.2 СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛӨЛ ЦОГЦ ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОХ НЬ

Стратегийн өмгөөллийн үйл ажиллагаа нь хүний эрх болон нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, хуулийн хэрэгжилтийг хангах, жишиг тогтоох, хууль тогтоомж, эрх зүйн бусад актыг боловсронгуй болгох, иргэдийн боловсролыг дээшлүүлэх, шийдвэр, зөвлөмж, дүгнэлтийн гүйцэтгэлийг хангах зэрэг цогц үйл ажиллагааг агуулдаг. Мөн өмгөөллийн үйл ажиллагааны явцад саад бэрхшээл болох зүйл тааралдах хэдий ч зөв чиглэлд хийсэн үйл ажиллагаа нь эрх зүйн шинэчлэл, олон нийтийн хандлагыг өөрчлөхөд нөлөөлдөг талаар энэ хэсэгт танилцуулна.

1.2.1 Өмгөөлөл, шүүхийг стратегийн өмгөөлөлд ашиглах нь

Хүний эрх, хууль ёсыг хүндэтгэх соёлыг төлөвшүүлэхэд стратегийн өмгөөлөл нь ихээхэн ач холбогдолтой. Үүнтэй уялдан шүүхийн бие даасан, хараат бус байдал, эрх зүйн орчин, тогтолцоо, иргэдийн шүүхэд итгэх итгэл зэрэг нь стратегийн өмгөөллийг амжилттай явагдах эсэхийг тодорхойлдог гол хүчин зүйлс юм.

Өмгөөлөл

Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэн явуулж буй эрх бүхий хуульч нь юуны өмнө НҮБ-ын Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал (ХЭТТ), Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт (ИБУТЭТОУП) болон хүний эрхийг хамгаалахтай холбоотой бусад пакт, гэрээ, конвенци, "Хууль зүйн мэргэжлийн бие даасан байдлын талаарх олон улсын хуульчдын холбооны стандарт"⁷, "Хуульчдын гүйцэтгэх үндсэн үүргийн зарчмууд", "Өмгөөлөгчийн үүргийн талаарх НҮБ-ын үндсэн зарчмууд" зэрэг өмгөөллийн үйл ажиллагаанд шууд хамаарах олон улсын эрх зүйн хэм хэмжээг сайтар судалж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгох шаардлагатай. Өөрөөр хэлбэл, өмгөөллийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага нь улам өндөрсөж байна гэсэн үг юм. Үүнтэй адил стратегийн өмгөөллийн хувьд хууль зүйн чиглэлээр хийж байгаа ажлыг дагалдаж өөр бусад шинэлэг

⁷ Хууль зүйн мэргэжлийн бие даасан байдлын талаарх олон улсын хуульчдын холбооны стандарт, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль зөрчигчтэй харилцах талаарх 8-р хурал, НҮБ-ын дэргэдэх Хууль эрх зүйн газар, 1990 оны 8-р сарын 27-ноос 9-р сарын 7-ны өдрүүд. (2014 оны 2-р сар) <<http://legal.un.org/ola/Default.aspx>>

бүтээлч үйл ажиллагааг хослуулан явуулах хэрэгцээ, шаардлага тулгарч байна. Тухайлбал, үйл ажиллагаандаа хэвлэл мэдээлэл, шинэлэг техник технологи хэрэглэж олон нийт, хууль тогтоогч болон шийдвэр гаргагчдад зөв шийдвэр гаргахад нь шууд бусаар нөлөөлөл үзүүлж болно. Тэгэхээр стратегийн өмгөөллийн үйл ажиллагаанд бид шүүхийн тогтолцоог ашиглахаас гадна мөн шүүхийн бус арга хэрэгслийг ашиглаж болно. Өөрөөр хэлбэл, шүүхийн танхимд өрнөж буй өмгөөллийн ажил бол стратегийн өмгөөллийн нэг хэсэг нь л юм. Хуульчид, байгууллага, хувь хүмүүс нь нэг юм уу, хэсэг бүлэг хүнд тохиолдсон асуудлаар дамжуулан хууль, бодлогыг боловсронгуй болгох, тогтолцоог шинэчлэх гэх мэт макро зорилтыг гарган ирж, түүнийг шийдвэрлүүлэхийн төлөө үйл ажиллагаа явуулахыг нийтийн эрх ашгийг хамгаалах стратегийн өмгөөлөл гэж хэлж болно.

Жишээ: 2010 онд А гэх эмэгтэй 1500 төгрөгийн хохирол учруулан хулгай хийснийхээ төлөө 10 жил 5 сарын хорих ял авсан. Буруу үйлдэл хийснийх нь төлөө хуулийн хариуцлага хүлээлгэх нь зүйн хэрэг боловч А-д оногдуулсан хэргийн санкци нь шударга бус мэт олон нийтэд санагдсан. Учир нь А ядуу, өлсөхийн эрхэнд хулгай хийсэн гэх бөгөөд А-ийн хэргээр дамжуулан нийгэмд шударга ёсны үнэлэмжийг харьцуулах боломжийг бүртгүүлж өгсөн. Стратегийн өмгөөллийн үйл ажиллагаанд хуульч нь хэвлэл мэдээллийн хэрэгслийг хүчтэй ашигласан бөгөөд А нь тэрхүү шударга бус ялаас мултрахын зэрэгцээ Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад хувь нэмрээ оруулсан юм.

Хэрэг болгон стратегийн өмгөөллийн хэрэг болдоггүй. Нийгэмд тохиолдож буй бухимдал, шударга бус явдал нэг бүрийг шүүхэд хандан зөрчлийг арилгуулах боломжгүй. Учир нь өмгөөлөл үнэ өртөг ихтэй, удаан үргэлжилдэг үйл явц юм. Энэ үүднээс шүүхэд нэхэмжлэл гаргах ажиллагааг зарим тохиолдолд шинэчлэл, өөрчлөлт хийх сонирхолгүй засгийн газрын эсрэг, эсхүл шинэчлэл хийх хүсэл эрмэлзлэлтэй иргэдийн төлөө нөөцлөх нь чухал байдаг.

Сайн төлөвлөгдөөгүй, буруу явагдсан өмгөөллийн сөрөг үр дагавар нь заримдаа хүний эрхэд халтай хууль, хууль зүйн практикийг баталгаажуулж, ингэснээр уг асуудлыг улам гүнзгийрүүлэн, ирээдүйд амжилттайгаар шийдвэрлэх боломжийг хаах аюултай. Энэ утгаараа зарим тохиолдолд шүүхэд хандах нь хамгийн тохиромжтой тактик биш байх талтай.

Нийтийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр ажилладаг өмгөөлөгчид бодит өөрчлөлтийг авчрах зорилгодоо хүрэхийн тулд өмгөөллөөс өөр хувилбар ихэнхдээ байдаггүй гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Ийнхүү сайн сайхны төлөө тодорхой өөрчлөлтөд хүрэхийн төлөөх стратегийн цогц үйл ажиллагааны зайлшгүй нэг хэсэг бол өмгөөлөл юм. Энэ тухай гарын авлагын “Стратегийн өмгөөлөл хийх арга зүйн зөвлөмж” хэсгээс дэлгэрүүлэн үзнэ үү.

Үүнээс гадна шүүхэд ялалт байгуулах нь цорын ганц чухал зорилт биш юм. Зөв чиглэлд хийсэн стратегийн өмгөөлөл нь хэдийгээр шүүхээс гаргасан шийдвэр нь санасан зорилгыг бүрэн хангаагүй ч эцсийн дүндээ эерэг өөрчлөлтөд хувь нэмрээ оруулдаг. Иймд олон нийтийг хамруулсан зохион байгуулалттай нөлөөллийн үйл ажиллагаа явуулах, тэдний мэдлэг, боловсролыг дээшлүүлэх зэрэг үйл ажиллагаа ч чухал ач холбогдолтой.

Шүүх

Шүүхийн тогтолцоог стратегийн өмгөөлөлд ашиглана гэдэг нь шалгуур хэргээр дамжуулан хүний эрхийн зөрчлийг арилгах, шүүхэд сайн жишиг тогтоох, хэрэгждэггүй хуулийг хэрэгжүүлдэг болгох, хууль зүйн практик ажиллагааг сайжруулах, шүүхийн шийдвэрийн гүйцэтгэлийг хангахыг ойлгоно. Стратегийн шинжтэй шалгуур хэрэг нь шүүхийн тогтолцоотой огтлолцож буй явдал нь шударга шүүхээр шүүлгэх, шударга шийдвэр гаргуулах зорилгыг агуулдаг байна. Өөрөөр хэлбэл, шүүх нь шударга ёсыг нийгэм, хууль, бодлогод суулгаж өгдөг чухал арга хэрэгсэл юм. Энэ нь доорх байдлаар илэрхийлэгдэнэ. Үүнд:

- Хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, хүндэтгэсэн, хамгаалсан дэвшилтэт шийдвэр
- Олон улсын хүний эрхийн хэм хэмжээтэй нийцээгүй үндэсний хууль тогтоомжийг өөрчлөх, сайжруулах гол баримт
- Хуулийг оновчтой тайлбарлах
- Хүний эрхийн зөрчил байгаа болохыг тогтоох
- Хүний эрхэд суурилсан хуулийн соёлыг бэхжүүлэх.

Стратегийн өмгөөлөлд шүүхийн тогтолцоог ашиглах явцдаа нөлөөллийн үйл ажиллагааг хослуулан хэрэглэснээр дараах үр дүнд хүрэх боломжтой. Үүнд:

- *Шүүхийн хэрэгт олон нийтийн анхаарлыг татах:* Энэ нь шүүх дээр ялалт байгуулах, тухайн хэргээр дамжуулан нийгэмд өөрчлөлт авчрахын тулд хийгддэг зорилго бүхий шалгуур хэрэг байна. Зорилго нь тухайн нэг асуудлын цаана маш олон хүний эрх, хууль ёсны ашиг сонирхол байгаа болохыг ойлгуулах замаар олон нийтэд хэргийн үр дүнг сонирхон ажиглах хүслийг төрүүлж, үүний дүнд шүүх, цагдаа, прокурорын ажилтнуудын хариуцлагыг нэмэгдүүлэх явдал юм.
- *Шүүхийн шийдвэрт гүн шинжилгээ хийх боломжийг олгох:* Хэрэг хянан шийдвэрлэх үе шат тус бүрт эерэг, сөрөг олон янзын шийдвэр гарч байдаг тул үүнээс хамааруулан шүүхийн хэргийн нөлөөллийн төлөвлөгөөг тухай бүр өөрчилж байх шаардлагатай. Тухайлбал, шүүхээс гарсан эерэг шийдвэрийг олон нийтэд хүргэх нь тухайн асуудал үнэхээр шударга ёсны төлөө юм гэдэгт олон нийтийн итгэх итгэлийг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой байдаг. Харин сөрөг шийдвэрийг мэдээлэх нь тухайн хэргийг хянан шийдвэрлэх дараагийн шатны албан тушаалтанд хэргийн мөн чанарыг ойлгуулах, тухайн асуудалд хариуцлагатай хандах сэдлийг төрүүлэх ач холбогдолтой.

Стратегийн өмгөөллийн үр дүнд олж мэдсэн үйл баримт, статистик тоо судалгааг өмгөөлөгч тухай бүрт нь баримтжуулан цуглуулж, шүүхэд хэрэг үүсгэх ажиллагаандаа ашиглах нь зүйтэй. Энэ нь цаашид хууль тогтоомжийг боловсронгуй болгох, өөрчлөхөд хувь нэмрээ оруулах боломжтой. Стратегийн өмгөөллийн хэргүүд нь ихэвчлэн урьд өмнө шүүхээр шийдвэрлэгдэж байгаагүй, шүүгч, прокурор, цагдаагийн ажилтнуудад төдийгүй хэргийг сонирхон ажиглаж байгаа олон нийтийн хувьд ч хэвшин тогтсоноос нь огт өөр, шинэ хандлага, арга барилыг шаардах шинэлэг асуудлууд байдаг. Нийгэмд нэгэнт үнэн зөв хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн хандлагыг шинэчлэх, өөрчлөх нь мэдээж амаргүй.

Ийнхүү стратегийн өмгөөлөлд шүүхийн тогтолцоог ашигласнаар хууль, бодлогыг өөрчлөх, сайжруулах хэрэгцээ, шаардлага байгаа болохыг бодитой, баримт нотолгоотой тогтоодог тул шүүхийн аргыг стратегийн өмгөөллийн өмгөөлөгчид түгээмэл хэрэглэдэг байна. Энэ тухай гарын авлагын “Стратегийн өмгөөлөл хийх арга зүйн зөвлөмж” хэсгээс дэлгэрүүлэн үзнэ үү.

2.2.2 Нөлөөллийн үйл ажиллагааг стратегийн өмгөөлөлд ашиглах нь

Стратегийн өмгөөллийн үр дүнд шүүхийн танхимд ялалт байгуулснаар зорилгодоо бүрэн дүүрэн хүрлээ гэж үзэх нь учир дутагдалтай байж болно. Тиймээс энэхүү ялалтыг улам баталгаажуулах, магадгүй ялагдлаа давуу тал болгон хувиргах зэрэгт сайтар төлөвлөсөн нөлөөллийн үйл ажиллагаа чухал хувь нэмэр оруулах боломжтой. Нөлөөлөл гэдгийг аливаа нэг зүйлийг батлах, өөрчлөх, мэдлэг мэдээллийг дээшлүүлэх зорилгоор хийгдэж байгаа зүй ёсны үйлдэл, үйл ажиллагаа хэмээн энгийнээр ойлгож болох юм.

Нөлөөлөл хийх олон арга байдаг бөгөөд тухайн асуудлын онцлогоос хамааран тэдгээрээс аль тохиромжтойг нь сонгон хослуулан хэрэглэх шаардлагатай. Нөлөөллийн үйл ажиллагаа нь стратегийн өмгөөллийн хэргээр дамжуулан тухайн асуудлыг хууль хэрэгжүүлэгч, хууль тогтоогч болоод олон нийтэд хүргэх зорилгоор хийгддэг. Үүнийг албан болон албан бус хэлбэрээр хийж болно.

Албан ёсны нөлөөлөл хийх: Улс орон бүр өөрийн хууль тогтоомжид албан ёсны аргуудыг хуульчилсан байдаг бөгөөд энэ нь албан ёсоор нөлөөлөл хийх боломжийг бий болгодог. Үүнд:

- Хэрэгжиж байгаа болон шинээр боловсруулж буй төрийн бодлого, хууль, хуулийн төсөлд саналаа өгөх;
- Өөрсдөө хуулийн төсөл бэлтгэж, хууль санаачлагчаар дамжуулан парламентад уламжлах;
- Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт орж ажиллах;
- Хуулийн төсөлтэй холбогдуулан зохион байгуулж буй уулзалт, хэлэлцүүлэгт оролцож саналаа хэлэх;
- Албан бичиг илгээх, албан бичгийг захидал, факс, и–мэйл зэргээр явуулж болох бөгөөд саналын шинжтэй өргөдөл, гомдол гаргах эрхийг мөн хуульчилсан байдаг.⁸

⁸ Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 12 дахь заалт, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, УИХ–аас 1995 онд баталсан.

Албан бичгийг холбогдох албан тушаалтнуудад илгээх, мэдэгдэх нь нөлөөллийн үйл ажиллагааны нэг хэлбэр мөн. Энэ нь стратегийн өмгөөллийн явцад хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хэрэгжихгүй байгаа хуулийн хэрэгжилтийг хангах, түүний шалтгаан нөхцөлийг холбогдох хүмүүст мэдэгдэх нэг хэлбэр юм.

Албан бус нөлөөллийн арга: Тодорхой асуудлаар олон нийтийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх, асуудлыг шийдвэр гаргагчдын сонорт хүргэх чиглэлээр зохион байгуулах янз бүрийн үйл ажиллагаа байж болно. Үүний нэг дэлгэрсэн хэлбэр бол хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон техник, технологийн дэвшлийг ашиглах явдал юм.

- Хэвлэл мэдээллийн хэрэгсэл (ХМХ) нь мэдээллийг олон хүнд, нэгэн зэрэг хүргэх боломжийг олгодгоороо давуу талтай. Хэвлэл мэдээлэлд ярилцлага өгөх, хэвлэлийн бага хурал зохион байгуулах, нийтлэл бичиж хэвлүүлэх, орон нутгийн хамт олны зохион байгуулж байгаа аливаа арга хэмжээнд сэтгүүлчдийг урьж сурвалжлага хийлгэх зэргээр ХМХ–ийг нөлөөллийн ажилдаа ашиглаж болно. ХМХ–ээр мэдээлэл хийхдээ стратегийн өмгөөллийн явцад тулгарч буй бэрхшээлтэй асуудал буюу эрх зүйн орчны боловсронгуй бус байдал, албан тушаалтнуудын хууль зөрчсөн үйлдэл зэргийн талаар дурдаж болох хэдий ч төр, байгууллага, хувь хүний нууц, бусдын нэр төр, алдар хүндэд халдахгүй байхад анхаарах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, ХМХ–ээр нөлөөллийн ажлыг явуулахдаа аливаад нотлох баримттай, ул суурьтай, хуулийн дагуу хандах хэрэгтэй. Энэ нь стратегийн өмгөөллийн чиглэлээр ажиллаж буй өмгөөлөгч баримталж ажиллах ёс зүйн дүрэмтэй гэдгээ санаж явах ёстой гэсэн үг юм.
- Дараагийн нөлөөллийн аргууд нь мэдээллийн технологийг ашиглах, ижил төстэй зорилго нэгтэй асуудлаар ажилладаг байгууллага, хувь хүмүүс, хуульчид хамтран сүлжээ, эвсэл байгуулах, эсхүл хурал, уулзалт, хэлэлцүүлэг, сургалт зохион байгуулах, сүүлийн үеийн мэдээлэл түгээх, солилцох түгээмэл арга болох нийгмийн сүлжээний facebook, twitter гэх мэт хэрэгсэл, түүнчлэн сонгуулийн стратеги ашиглах зэрэг тухайн хэргийн нөхцөл байдлаас хамааран сонгож хэрэглэх аргууд юм.

Ийнхүү олон төрлийн үйл ажиллагааг багтаасан стратегийн өмгөөлөл бол тогтолцоог өөрчлөх хамгийн хүчтэй арга хэрэгслийн нэг юм. Дээрх албан болон албан бус нөлөөлөл нь хууль тогтоогчдод нөлөөлөх, төрийн байгууллагуудтай тулж ажиллах, олон нийтийн санаа бодол, дэмжлэгийг авах, хэвлэл мэдээлэлд хандах зэрэг аргуудтай ба энэ нь иргэд, байгууллага, хувь хүмүүсийг зохион байгуулалтад оруулан, улмаар нийгмийн өөрчлөлтөд чиглэсэн сайтар бодож боловсруулсан стратеги болно.

1.3 СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛӨЛ БА ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Улс орнууд хүний эрх, нийтийн эрх ашгийг стратегийн өмгөөллийг ашиглан хамгаалах болсон нь он удаан жилийн түүхтэй. Энэ хэсэгт Монгол Улс, АНУ, Австрали болон Төв, Зүүн Европын улс орнуудын стратегийн өмгөөллийн үүсэл, хөгжлийн талаар авч үзэх болно.

1.3.1 Монгол Улс дахь стратегийн өмгөөлөл

Монгол Улсад Хүний эрхийн Үндэсний Комисс (ХЭҮК), төрийн бус байгууллагуудын санаачлан ажилласан хэргээр дамжуулан стратегийн өмгөөллийн үүсэл хөгжил эхэлсэн гэж үзэж болно. Эдүгээ стратегийн өмгөөлөл үүсэж хөгжөөд арав гаруй жил болж байна. Стратегийн өмгөөлөл нь шинэ төрлийн гэмт хэрэг болох хүний наймаа бүртгэгдэж эхэлсэн 2000 оны үеэс эхэлж, эдийн засгийн хөгжлийн гол тулгуур болох уул уурхайн салбар эрчимтэй хөгжсөн 2004 оноос эрчимжсэн байна. Өөрөөр хэлбэл, стратегийн өмгөөлөл хийх эрх зүйн орчин бүрэлдээгүй нөхцөлд үүсэж хөгжиж эхэлсэн юм. Монгол Улсад стратегийн өмгөөлөл нь АНУ, Австрали Улс дахь нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах чиглэлийг удирдлага болгон ажилладаг хэдий ч мөн эх газрын эрх зүйн тогтолцоо болох Төв болон Зүүн Европын хөгжлийн урсгалыг агуулсан холимог байдлаар хөгжиж байна.

Тэрхүү хөгжлийн суурийг бүрэлдүүлэхэд Монгол Улс дахь олон улсын санхүүжүүлэгч байгууллагуудын дэмжлэг чухал үүрэг гүйцэтгэснийг зориуд дурдах нь зүйтэй. Тухайлбал, Монгол Улс дахь⁹ болон Будапештын¹⁰ Нээлттэй Нийгэм Хүрээлэн,

⁹ Нээлттэй Нийгэм Форум<www.forum.mn>.

¹⁰ Нээлттэй Нийгэм Хүрээлэн<www.opensocietyfoundations.org>.

Америкийн хуульчдын холбоо¹¹, Швейцарийн Хөгжлийн Агентлагийн санхүүгийн болон техникийн тусалцаа нь стратегийн өмгөөллийн ажиллагаанд тухайн чиглэлийн байгууллагуудыг нэгтгэх, хооронд нь мэдээлэл солилцуулах, мөн хуулийн ажилтнууд, шүүхэд төлөөлөх эрхтэй хуульчдыг сургах, оролцуулах зэргээр стратегийн өмгөөллийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан. Жишээлбэл, Нээлттэй Нийгэм Форум төрийн бус байгууллагын дэмжлэгтэйгээр Хүний эрх хөгжил төв¹² нь стратегийн өмгөөллийн төслийг 2005, 2009, 2012 онд хэрэгжүүлсэн ба төсөл бүр стратегийн өмгөөлөл хийх чадавхийг бэхжүүлэх, холбогдох хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулахад чиглэж байсан. Түүнчлэн Америкийн хуульчдын холбооны санхүүжилтээр хэрэгжсэн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн эрх ашгийг хамгаалах стратегийн өмгөөллийн үр дүнд хүн худалдаалах гэмт хэргийг шийдвэрлэх явцад хохирогчийн эрх ашгийг хамгаалах процедурыг олон улсын жишигт нийцүүлж чадсан юм.¹³

Сүүлийн жилүүдэд байгаль орчин, гэр бүлийн хүчирхийлэл, хүнсний аюулгүй байдал, хөдөлмөрийн мөлжлөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зөрчигдөх явдал түгээмэл гарах болсон нь энэ чиглэлээр стратегийн өмгөөлөл хийх хэрэгцээ, шаардлага байгааг харуулж байна. Өнөөдөр Монгол Улсад стратегийн өмгөөллийн хэргүүд нь хүн худалдаалах гэмт хэрэг, хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбогдон нэрлэгдэж байна. Харин нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах чиглэлийн хэргүүд нь олборлох салбарын хөгжилтэй уялдан байгаль орчны эсрэг хэргүүд давамгайлж байна.

Стратегийн өмгөөллийн гэж нэрлэгдээд байгаа дээрх хэргүүд ихэвчлэн хувь хүний эрх ашгийг хөндсөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой байдаг бөгөөд эдгээр хэргээр дамжуулан хууль болон тогтолцооны алдаа, сул талыг илрүүлэх, улмаар засаж сайжруулах хэрэгцээг дэлгэн харуулах, эхлүүлэх үндсийг тавьсан юм. Үүнд, хүн худалдаалах гэмт хэрэг,

¹¹ Америкийн хуульчдын холбоо <www.americanbar.org>.

¹² Хүний эрх хөгжил төв <www.chrd.org.mn>.

¹³ Хүний эрх хөгжил төв нь 2009–2012 онуудад Америкийн хуульчдын холбооны санхүүжилтээр “Стратегийн өмгөөлөл ба хүн худалдаалах гэмт хэрэг” төслийн хүрээнд нийт 45 өмгөөлөгчийг хохирогч хамгааллын чиглэлээр мэргэшүүлж, шаталсан сургалтад хамруулсан. Үүний үр дүнд хүн худалдаалах нийт 46 гэмт хэргийн 63 хохирогчид хуулийн зөвлөгөө, тусалцаа үзүүлсэн юм. Хүний эрх хөгжил төв <www.chrd.org.mn>.

гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэргүүдийг хамруулж болно. Учир нь эдгээр гэмт хэргийг таслан зогсоох, хохирогчдод зохих үйлчилгээ үзүүлэх, хамгаалалтад авах асуудал хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн хүрээнд орхигдсон байсан тул нэг хүний зөрчигдсөн эрхийг сэргээх замаар жишиг тогтоох тактикийг ашигласан байна. Үүний үр дүнд 2004 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, 2012 онд Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулиуд батлагдаж, мөн хамгаалах байрын үйлчилгээний стандартыг бий болгож чадсан юм.

Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах гэж нэрлэгдээд байгаа хэргүүд нь уул уурхайн үйлдвэрлэлээс байгаль орчинд ихээхэн хор хохирол учруулж байгаатай холбоотой хэргүүд билээ. Уул уурхайн салбарын хөгжил эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө үзүүлж байгаа хэдий ч байгаль орчинд үлэмж хэмжээний хохирол учруулж байгааг хүлээн зөвшөөрөх боломжгүй юм. Тиймээс ч энэ байдал нь орон нутгийн иргэдийг байгаль орчныхоо төлөө тэмцэл өрнүүлэхэд хүргэсэн.

Монгол Улсын хэмжээнд хүний эрхийн ноцтой зөрчлийг илрүүлэх, зөрчигдсөн эрхийг нэхэмжлэн хамгаалах тодорхой үүрэг хүлээсэн субъектүүд бол ХЭҮК, Засаг дарга, прокурор юм.¹⁴ Прокурорын байгууллагын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Гэр бүлийн тухай хуулиудад тус тус зааснаар прокурор, орон нутгийн Засаг дарга бүрэн эрхийнхээ хүрээнд “төрийн ашиг сонирхол” зөрчигдсөн гэж үзвэл нийтийн эрх ашгийг нэхэмжлэх эрхийг нь хуульчилсан. “Төрийн ашиг сонирхол” гэдэгт байгаль орчин, төрийн өмчийг зүй зохистойгоор ашиглах (нийтийн эрх ашигт хамруулдаг байна), насанд хүрээгүй хүүхдийн эрхийг хамгаалах зэрэг асуудлыг багтаан авч үзжээ. Харамсалтай нь ашиг сонирхлын зөрчил болон зарим нэг хуулийн хийдэл, эрх бүхий субъектүүдийн идэвхгүй байдлын улмаас дээрх хуулийн заалтуудын хэрэгжилт сул байна.

Монгол Улс дахь стратегийн өмгөөллийн эхний хэрэг дээр Хүний эрх хөгжил төв 2001 онд ажилласан бөгөөд энэ хэргээр дамжуулан хүний наймааны хэрэг аль хэдийнэ манай улсад орж ирснийг илтгэн харуулж чадсан юм. Уг хэрэг нь монгол охид, эмэгтэйчүүд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч

¹⁴ Прокурорын байгууллагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, Гэр бүлийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсэг, Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг.

болж байгааг нотолж, мөн гэмт этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн анхны стратегийн өмгөөллийн хэрэг байлаа.¹⁵ Тухайн үед үйлчилж байсан Эрүүгийн хуульд¹⁶ энэ төрлийн гэмт хэрэгт ногдуулах эрүүгийн хариуцлага байхгүй байсан хэдий ч анх удаа¹⁷ хүн худалдаалах гэмт хэргийг шийтгэж чадсан жишиг хэрэг болсон юм. Энэ жишиг хэргээр дамжуулан уг гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэх хуулийн заалт зайлшгүй хэрэгтэй гэдгийг нотолж, улмаар 2002 онд шинэчлэн баталсан Эрүүгийн хуульд холбогдох зүйл ангийг оруулахад чухал түлхэц болсон. 2002 оноос хойш хүний наймаатай тэмцэхэд эрх зүйн орчныг илүү боловсронгуй болгох зорилгоор хэд хэдэн хэргийг сонгон авч, стратегийн өмгөөлөл хийсний дүнд холбогдох олон улсын гэрээ, хэлэлцээрт нэгдэн орж, хууль тогтоомжийг сайжруулж, тусгайлсан хуулийг баталсан болно.

Жишээ: 2000 оны 5 дугаар сард М гэгч орос, монголын эрлийз эр Шуурхай зар сонинд “Өндөр нуруутай, царайлаг охидыг Румын, Югославт бүжигчнээр ажиллуулна. Сарын цалин 3000 ам доллар” гэсэн зарыг тавьжээ. Зарын дагуу 18–21 насны таван залуу бүсгүй очиж бүртгүүлэн, М–д нэр, хаяг, утас гэх мэт мэдээллүүдийг үлдээжээ. Ингээд тэдний нисэх өдрийг товлох үед хоёр нь материалаа буцаан авсан байна. Нисэх хүртэл бүх бэлтгэл ажлыг М хоёр сард багтаан амжуулаад 2000 оны 8 дугаар сард үлдсэн гурван эмэгтэйн хамт Бээжин рүү нисчээ.

Сүхбаатар дүүргийн прокурор М–ыг эмэгтэйчүүдийг гадаад руу биеийг нь үнэлүүлэх зорилгоор гаргасан, эмэгтэйчүүдийг зарсан ба худалдаж авсан, хүчээр биеийг нь үнэлүүлсэн, хуурамч бичиг баримт үйлдсэн гэсэн зүйлээр ялласан. Тэрээр эмэгтэйчүүдийг Бээжинд визээ гарахыг хүлээж байсан, мөн тэднийг цааш нь Югослав руу зарах гэж байсан тухайгаа мэдүүлсэн хэдий ч, Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна хэрэг хийсэн учраас түүнийг хүн наймаалсан хэрэгт буруутгаж чадахгүй гэж хэлж байжээ. Гэвч хохирогчдод хуулийн зөвлөгөө өгөн өмгөөлж байсан Хүний эрх хөгжил төвийн хуульч энэ гэмт хэрэг нь Монголын газар нутагт эхэлж, гэмт этгээд Монголын газар нутагт баривчлагдсан учир Монголын хуулиар шийтгэгдэх ёстой гэж үзсэн бөгөөд үүнийг шүүх зөвшөөрөн, энэ хэргийг шүүсэн юм.¹⁸

¹⁵ М–д 6 жил хорих шийтгэл оногдуулсан. Тэрээр 1996 онд батлагдсан Эрүүгийн хуулийн 1111.2–т зааснаар биеийг нь үнэлүүлэх зорилгоор хүмүүсийг гадаадад илгээсэн гэдэг зүйлээр 5 жил, 114.1 зүйлээр эрхэндээ байгаа хүнийг хүчирхийлсэн хэргээр 6 жилийн ял шийтгүүлсэн. Мөн хуулийн 224.1–д зааснаар хуурамч бичиг баримт үйлдсэн гэм буруу нь тогтоогдсон боловч энэ зүйлийн нэг жилийн ялыг хүндэд нь багтааж нийт 6 жил хорих ял оногдуулсан. М 2002 оны 12 сард давж заалдсан боловч ялыг хэвээр нь үлдээсэн.

¹⁶ Эрүүгийн хууль, УИХ–аас 1996 онд баталсан.

¹⁷ 2001 онд Монгол Улсад хуулийн шинэчлэл явагдаж байсан хэдий ч хуучны социалист тогтолцооны үеийн Эрүүгийн хуулийг хэрэглэж байсан үе юм. Тухайн үеийн Эрүүгийн хуульд хүн худалдаалах гэмт хэргийг шийтгэх зүйл анги байхгүй байсан.

¹⁸ Хүний эрх хөгжил төв, “Хүн худалдаалах гэмт хэрэг: Асуудал ба арга зам”, УБ, 2003 он, 23 дахь тал.

Стратегийн өмгөөлөл үүссэн эхний жилүүдэд ХЭҮК ч хэд хэдэн хэрэг дээр ажилласан юм.

Жишээ 1: Хөдөө орон нутгаас Улаанбаатар хотод шилжин суурьшигчдаас Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2000 оны 46 дугаар тогтоолоор баталсан хураамжийг авч байсныг хүчингүй болгох зорилгоор шүүхэд нэхэмжлэл гаргасан хэрэг юм. ХЭҮК Улаанбаатар хотын хүн амын механик өсөлтийг бууруулах зорилготой уг тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 18-д заасан “улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох эрх” болон “Татварыг Улсын Их Хурлаар бий болгоно” гэсэн татварын хуулийн заалтуудыг тус тус зөрчсөн гэж үзсэн.¹⁹ Энэхүү хэргийн нэхэмжлэгч нь ХЭҮК, хариуцагч нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байсан бөгөөд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолыг хүчингүй болгосон шийдвэрийг шүүхээс гаргасан байна. ХЭҮК-ын стратегийн өмгөөллийн энэ хэрэг нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолыг хүний эрх зөрчсөн, хууль бус захиргааны акт болохыг тогтоолгож, хүчингүй болгуулсан юм.

Жишээ 2: Төв аймгийн цагдаа, прокурорын байгууллагын ажилтнуудын хариуцлагагүй үйл ажиллагааны улмаас 11 сар цагдан хоригдож байхдаа сүрьеэ өвчин тусч, эрүүл мэнд нь доройтон нас барсан сэжигтэн Г.Ганбатын хэрэг юм. ХЭҮК энэ хэргийг хүний амьд явах, эмнэлгийн тусламж авах эрхийг ноцтой зөрчсөн хэмээн дүгнэсэн.²⁰ Энэ хэргийн дагуу Эрх зүйн шинэтгэлийг дэмжих хуульчдын төвөөс 2002 онд Төв аймгийн цагдаагийн болон прокурорын газруудаас хохирлыг нэхэмжилсэн байна. Энэ хэрэг нь Төв аймгийн шүүх, Нийслэлийн шүүх, Улсын дээд шүүх (УДШ) зэрэг хэд хэдэн шатны шүүхээр хэлэлцэгдсэн боловч хэргийг хэрэгсэхгүй болгосон. Шүүх нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгохдоо Г.Ганбат хэрэг үйлдсэн нь нотлогдож байгаа бөгөөд хууль бусаар цагдан хориогүй тул нэхэмжлэлийн шаардлагыг хангах шаардлагагүй хэмээн үзжээ. Энэ хэрэг амжилтгүй шийдэгдсэн хэдий ч 2002 онд батлагдсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага байна гэдэг дохиог хуульч, хууль тогтоогчдоод өгсөн юм.

Монгол Улсын хувьд практик ажиллагаан дээр суурилан стратегийн өмгөөллийн түүхийг эхлүүлсэн бөгөөд 2010 оноос эрх зүйн таатай орчин бүртэж эхэлсэн билээ.²¹ Монгол Улсад стратегийн өмгөөлөл арав гаруйхан жилийн түүхтэй ч хүний эрхэд суурилсан эрх зүйн орчин бүртүүлэх, шударга шүүхийн

¹⁹ Нээлттэй Нийгэм Форум, зүүлт 6, 41 дэх тал.

²⁰ Нээлттэй Нийгэм Форум, зүүлт 6, 47 дахь тал.

²¹ Байгаль орчныг хамгаалах тухай хууль, УИХ-аас 1995 онд баталсан, 2010 оны 7 дугаар сард оруулсан нэмэлт, өөрчлөлт

тогтолцоог бий болгоход өөрийн гэсэн хувь нэмрээ оруулж чадсан билээ.

1.3.2 АНУ дахь стратегийн өмгөөлөл

АНУ дахь нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах үйл ажиллагааны үүсэл хөгжлийн суурийг тавьсан хэрэг бол Боловсролын зөвлөлийн эсрэг Брауны хэрэг²² гэдэгтэй олон эрдэмтэн болон хүний эрхийн төлөөх идэвхтнүүд санал нэг байдаг. Нийтийн эрх ашгийг хуулиар хамгаалах гэсэн нэр томьёо нь 1960–аад оноос АНУ–д өрнөсөн олон нийтийн хөдөлгөөнтэй холбоотойгоор өргөн дэлгэрсэн.

Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах үйлс нь олон зүтгэлтнүүдийн үзэл санаа, үйл хэргээс эхтэй. Тухайлбал, Луйс Брандэс нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах чиглэлээр амжилтад хүрч, улмаар АНУ–ын Дээд шүүхийн гишүүнээр томилогдон ажиллаж байжээ. Тэрээр 1950–иад онд өмгөөллийн үйл ажиллагаа ид явуулж байх үедээ “өнөөгийн хуульчид томоохон корпорациудын дагуул болон хувирч, нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах хуульчийн мэргэжлийн ёс зүйгээ умартсан байна” хэмээн шүүмжилж байв.

Энэ шүүмжлэлийн дүнд 1960–1970 онуудад Америкийн хуулийн их, дээд сургуулиудын төгсөх ангийн оюутнууд тухайн үеийн нийгэмд тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэхийг чармайх болсон ба тэд өөрсдийгөө “people's lawyers” буюу олон нийтийн хуульч хэмээн нэрлэж, корпорацийн үйлчлэгч, дагуул байхаас татгалзахыг хичээх болжээ. Тэд ядуусын эрх ашгийг хамгаалаад зогсохгүй, мөн нийгмийн дунд болон дээд хэсгийнхний ч эрх ашгийг илэрхийлдэг байсан байна. АНУ–д стратегийн өмгөөллийн тухай ойлголтыг олон нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэн явуулдаг байгууллага, хуульчид бий болгосон юм. АНУ–д нийтийн эрх ашгийг хамгаалан ажилладаг байгууллагууд нь “нийгмийн эмзэг бүлгийг хамгаалах” чиглэлээр төлөвшин бүртжээ.

²² Brown v. Board of Education, 347 U.S. 483 (1954) буюу Боловсролын зөвлөлийн эсрэг Брауны хэрэг. Уг хэрэг нь 1954 оноос эхлэн АНУ–ын шүүхийн практикт арьс өнгөөр ялгаварлан гадуурхсан хэргүүдэд жишиг хэрэг болсоор байна.

Өнөөдөр АНУ–д нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаална гэдэг ойлголт интституцийн түвшинд хүртэл хөгжсөн. Тус улсад төрийн бус байгууллага нь хэрэглэгчдийн эрх, байгаль орчин, хүний эрхтэй холбоотой асуудлыг хуулийн хүрээнд өмгөөлөн ажилладаг бөгөөд тэднийг нийтийн эрх ашгийг хамгаалагч байгууллагууд хэмээн нэрлэж байна. Үүнээс гадна хуулийн их, дээд сургуулиуд эрх зүйн клиник сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж, хүний эрх, ялгаварлан гадуурхалт, байгаль орчин, Үндсэн хуулиар баталгаажсан эрх зэрэг асуудлаар оюутнуудад дадлага хийх, мэргэших боломжийг олгож байна.

Жишээ: 1954 оноос өмнө АНУ–ын ихэнх мужуудын дунд сургуулиуд арьсны өнгөөр ялгаварласан бүтэцтэй байсан ба хар арьст хүүхэд зөвхөн тэдэнд зориулсан сургуульд явдаг байв. Энэ хэрэг нь хувь хүнд шударга ёс тогтоохоос илүү боловсролын системд өөрчлөлт хийх зорилготой, нэрд гарсан стратегийн өмгөөллийн жишээ юм. Энэхүү Брауны хэрэг амжилттай шийдвэрлэгдсэний дүнд нийтийн эрх ашгийн төлөөх үйл ажиллагаа эрхлэн явуулдаг байгууллагууд, хуульчид тэрхүү арга замыг ашиглан арьс өнгөөр ялгаварлан гадуурхах явдлыг дунд сургууль, хөдөлмөр эрхлэлт, орон байртай байх эрх, сонгох сонгогдох эрхийн хүрээнд халах чиглэлээр илүү нарийвчлан хэрэглэсэн байна. Түүнчлэн цөөнхийн эрхийн биелэлтийг хангуулахад “Брауны шийдвэр” нь хүний эрхийн хамгаалагчдад урам зориг өгч байсан. Энэхүү Брауны хэрэг хар арьст хүмүүсийг нийгмийн бүхий л хүрээнд ялгаварлан гадуурхах явдлыг устгахад хувь нэмрээ оруулсан гэж үздэг.

1.3.3 Төв болон Зүүн Европ дахь стратегийн өмгөөлөл

1990–ээд оны эхээр социалист дэглэм нуран унаж, бүс нутагт эрх зүйн тогтолцоог бүртгүүлэхэд бүсийн нөлөөлөл ихээхэн үүрэг гүйцэтгэсэн. Бүс нутгийн эрх зүйн нөлөөллийн эх сурвалж нь Европын Холбоо, Европын Хүний эрхийн конвенц²³ болон Европын Хүний эрхийн шүүх юм.

1990 оны дунд үе гэхэд тус бүс нутагт АНУ–ын туршлага буюу шүүхийн тогтолцоог ашиглаж хүний эрхийн зөрчлийг арилгах, нийгэмд өөрчлөлт хийх арга зам илүү ач холбогдолтой гэж үзсэн байна. Өөрөөр хэлбэл, шүүхийн тогтолцоог стратегийн өмгөөллийн хэрэгт ашиглан богино хугацаанд тодорхой үр дүнд хүрэх арга зам байсан юм. Энэ утгаараа бүс нутгийн иргэний нийгмийн байгууллага, хуульчид эхлээд өөрийн үндэсний бүх шатны шүүхээр явж дотоод дахь арга хэмжээгээ гүйцээсний

²³ Европын Хүний эрхийн конвенц, Европын Зөвлөлөөс 1950 онд баталсан.

дараа бүс нутгийн статустай Европын Зөвлөлд ханддаг болсон байна.

Бүс нутгийн хүний эрхийн зүтгэлтнүүд шалгуур хэргээр дамжуулан шүүхэд зарга, нэхэмжлэл гаргах зэрэг стратегийн өмгөөллийн ажиллагаа хийж байсан бөгөөд мөн тэд Европын Хүний эрхийн шүүхээс гаргасан хүний эрхийн зөрчлийг арилгах тухай шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх, түүнийг дэмжих үүднээс АНУ–тай төстэй "нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах" тогтолцоог бий болгох, "нийтийн эрх ашгийг хамгаалах хуулийг" бий болгохыг дэмжих, түүнийг батлуулахад нөлөөлөх арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.

Европын Хүний эрхийн шүүх нь хүний эрхийн баялаг мэдээллийн сантай бөгөөд уг санд байгаа мэдээллийг ашиглан тодорхой хэргийг хэрхэн шийдвэрлэх, ямар хууль тогтоомж хэрэглэх, авч болох арга хэмжээ юу болох зэргийг тодорхойлох, энэ чиглэлээр зөвлөмж, дүгнэлт, чиглэлийн баримт бичиг боловсруулахад ихээхэн ач холбогдолтой. Европын Хүний эрхийн шүүхийг үр дүнтэй ашиглах зорилгоор шүүхийн бус арга хэрэгслийг нөлөөллийн үйл ажиллагаандаа өргөнөөр хэрэглэдэг байна. Учир нь үндэсний болон бус нутгийн шүүхийн шийдвэр тэр бүр нэхэмжлэлийн шаардлагыг хангадаггүй. Шүүхийн шийдвэр сөрөг гарвал хүний эрхийн зөрчлийг арилгах биш харин бүр илүү хохирол учруулах, буруу жишиг тогтох магадлалтай билээ.

Жишээ: Тус бүс нутгийн хүрээнд хүний эрхийн зөрчлийг арилгахад шүүхийн тогтолцоог хэрхэн үр дүнтэй ашиглах талаар АНУ–ын туршлагаас суралцсан.

Унгарын Иргэний Эрх Чөлөөний Холбоо нь өвчтөний эрх, ялангуяа, хувийн нууцыг хамгаалах эрх, мэдээлэл авах эрхийн чиглэлээр иргэдэд эрх зүйн үйлчилгээ үзүүлж байв. Энэ байгууллага нь стратегийн ач холбогдолтой хэргийг шүүхээр хянан шийдвэрлүүлэх, хувь хүмүүст хууль зүйн туслалцаа үзүүлэх, олон нийт болон бодлого боловсруулагчдыг сургах чиглэлээр ажилладаг. 1997 онд тус байгууллага сэтгэцийн эмгэгтэй өвчтөнийг цахилгаан гүйдлээр эмчлэн, гэр бүлийн гишүүдтэй нь уулзуулахгүй байсан эмнэлгийг шүүхэд өгчээ. Тэр үед сэтгэцийн өвчтэй өвчтөнийг эмчлэх талаар хуульчлан тогтоосон хэм хэмжээ байгаагүй. Тиймээс энэ эмнэлгийн эмчилгээг хүний эрхийг зөрчсөн хэмээн зарлаж, хохирлыг нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргасан байна. Шүүх Унгарын Иргэний Эрх Чөлөөний Холбооноос 1989 оны шинэ Үндсэн хуулийн хүний эрхийн заалт болон Иргэний хуулийн заалтыг үндэслэн гаргасан нэхэмжлэлийг хүлээн авчээ. Энэ хэрэг нь Унгарт хүний эрхийн шинэ хуулийг хэрэглэн шийдсэн анхны хэргүүдийн нэг байлаа. Түүгээр ч зогсохгүй энэ хэрэг хэвлэлийнхний анхаарлыг ихэд татсан тул олон

нийт болон шийдвэр гаргагчдын мэдлэг, ойлголтыг дээшлүүлэхэд ихээхэн ач холбогдолтой байжээ. Дараа нь энэ байгууллагаас гаргасан материалыг 1998 оны Эрүүл мэндийн шинэ хуулийг батлан гаргахын өмнө Парламентын гишүүд уншиж судалсан байна. Энэ шинэ хуулиар өвчтөний эрхийг баталгаажуулсан, эмийн болон сэтгэцийн эмчилгээ хийхдээ урьдчилан өвчтөнд мэдэгдэн зөвшөөрлийг авсан байх, өвчний тухай нууцыг хадгалах, "найдваргүй тохиолдолд сэхээн амьдруулах эмчилгээнээс татгалзах эрх"²⁴—тэй зэрэг заалтуудыг оруулжээ.²⁵

1.3.4 Австрали Улс дахь стратегийн өмгөөлөл

Нийтлэг эрх ашиг зөрчигдсөн тохиолдолд эрхийг сэргээх, хамгаалах практик ажиллагаа, эрх зүйн шинэтгэл 1980 оноос эхэлсэн юм. 1980—аад оны дунд үеэр байгууллага, хуульчид нийтийн эрх ашгийн төлөөх хэд хэдэн хэргийг шүүхэд хүргэж, мөн ТББ, бие даасан эрдэмтэд, судлаачдын энэ чиглэлээр туурвисан судалгаа, тайлан, бүтээлүүд олноор бий болжээ.

Австрали Улсад стратегийн өмгөөлөл нь нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах чиглэлээр түлхүү хөгжиж байна. Австрали Улсын Эрх зүйн шинэтгэлийн хороо²⁶ нь нийтлэг эрх ашгийг хөндсөн хэргүүд, түүнтэй холбогдох хууль тогтоомжийн талаарх судалгааны ажлыг системтэй хийж иржээ. Түүнчлэн, тухайн үеийн Хууль зүйн сайдын бүрэн эрх улс төрийн болон хууль сахиулах албаны аль алиных нь шинжийг хадгалдаг, өөр хоорондоо зөрчилдөх магадлалтай албан тушаал байсан ба өөрт олгогдсон "Нийтийн эрх ашгийг өөрийн нэрийн өмнөөс нэхэмжлэх" бүрэн эрх нь практикт ховорхон хэрэгждэгт Австрали Улсын Эрх зүйн шинэтгэлийн хороо ихээхэн шүүмжлэлтэй хандаж байжээ. Мөн МкЭвен хэмээх судлаач Австрали Улс нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах урт удаан хөгжлийн түүхтэй ч шүүхэд хандах ажиллагаан дээр бэрхшээл тулгарсаар байна гэж дүгнэжээ.

Австралийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд нийтийн эрх ашгийг хөндсөн хэргийг нээлттэй нэхэмжлэхээр зохицуулсан байна. Нийтийн эрх ашгийг шүүхэд нэхэмжлэн хамгаалах асуудал

²⁴ Википедиа цахим толь (2014 оны 2 сар) <http://en.wikipedia.org/wiki/Hungarian_Civil_Liberties_Union>

²⁵ Нээлттэй Нийгэм Форум, зүүлт 6, 34 дэх тал.

²⁶ Австрали Улсын Эрх зүйн шинэтгэлийн хороо нь шинээр батлагдан гарах болон хүчин төгөлдөр үйлчилж буй бүх хууль тогтоомжийг хянан судлах бүрэн эрхтэй холбооны байгууллага юм.

хуулийнхны анхаарлын төвд 1970—аад оноос эхлэн орсон. Австрали Улсын Эрх зүйн шинэтгэлийн хороо нийтийн эрх зүйд хамрагдах захиргааны хуулиудад дүн шинжилгээ, судалгаа хийсэн бөгөөд тэдгээрийн тайлан, мэдээлэл нь "Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах" эрх зүйн орчныг бий болгоход ач холбогдлоо өгсөн юм. Мөн эрх зүйн шинэчлэл эрхлэн явуулж буй эрх бүхий байгууллагаас нийтийн эрх ашгийг нэхэмжлэхэд илүү либерал байдлаар хандахыг уриалжээ. Тухайлбал, Виктория мужийн Хуулийг боловсронгуй болгох хороо²⁷ нь "Нийтийн эрх ашгийг нэхэмжлэх нээлттэй эрх"—ийн санал дэвшүүлсэн байна. Нийтийн эрх ашгийн төлөөх нэхэмжлэгч талын асуудлыг нээлттэй байдлаар орхисон нь хууль тогтоомжид янз бүрээр тусгалаа олжээ. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиудад "аливаа этгээд (any person)",²⁸ "сонирхогч этгээд (person interested)",²⁹ "хохилогч, эсхүл эрх ашиг нь хөндөгдсөн (person affected)"³⁰ зэргээр тодорхойлогдсон байна.

Австрали Улсын хууль тогтоомжоор зарим нэг салбарын хүрээнд, тухайлбал байгаль орчны асуудлаар шүүхэд нээлттэй нэхэмжлэх эрхтэй учир шүүхэд байгаль орчны хэргийг хянан хэлэлцэхэд эерэг нөлөө үзүүлж байна. Дараагийн нэг сайн зохицуулалт бол нийтийн эрх ашгийн хэргийн нэхэмжлэгч шүүхэд ялагдсан ч шүүхэд төлөх тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгддөг явдал юм.³¹ Ингэснээр нийтийн эрх ашиг, шүүхэд хандах эрх, шүүхийн зардал зэрэг асуудлыг тогтолцооны хүрээнд нааштай шийдэж чаджээ.

Нийтийн эрх ашгийг нэхэмжлэх эрх олгогдсон цөөн албан тушаалтны нэг болох Хууль зүйн сайд нь байгаль орчны мэргэжилтэн биш, мөн энэ чиглэлийн мэдээлэлгүйн улмаас тус улсад ихээхэн газар аваад байсан байгаль орчны асуудлаар нийтийн эрх ашгийг нэхэмжлэх хэрэгцээг хангаж чадахгүй

²⁷ Англи хэл дээр "Victorian Statute Law Revision Committee" гэдгийг Виктория мужийн Хуулийг боловсронгуй болгох хороо гэдгээр орчуулав.

²⁸ Байгаль орчныг хамгаалах болон үнэлгээний тухай хууль, Бүлэг 123(1), Нью Соут Вайлэс мужийн Парламентаас 1979 онд баталсан.

²⁹ Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Бүлэг 33(1)(2), Австрали Улсын Парламентаас 1981 онд баталсан.

³⁰ Ирээдүйн үйлдвэрлэлийн тухай хууль, Бүлэг 157, Нью Соут Вайлэс мужийн Парламентаас 1986 онд баталсан.

³¹ Ажилчдад нөхөн төлбөр олгох тухай хууль, Нью Соут Вайлэс мужийн Парламентаас 1978 онд баталсан, Ялгаварлан гадуурхалтын эсрэг хууль, Бүлэг Нью Соут Вайлэс мужийн Парламентаас 1977 онд баталсан.

байсан. Нийтийн эрх ашгийг нэхэмжлэх нээлттэй эрх хуулиар олгогдсон төрийн албан тушаалтан нь шүүхэд нэхэмжлэл гаргахгүй байснаар энэ төрлийн нэхэмжлэх эрхийг нээлттэй болгох асуудлыг эрчимтэй судлах, улмаар бусад субъектэд энэ эрхийг олгох зэрэгт түлхэц болж өгчээ.

Жишээ: Паддингтон хотын Зөвлөлийн эсрэг тус хотын иргэн Бойс³² нь өөрийн нэрээр нийтийн эрх ашгийг шүүхэд нэхэмжилсэн хэдий ч шүүх хэргийг хянан хэлэлцэхээс татгалзсан юм. Энэ хэргийн стратегийн өмгөөллийн шинж нь тухайн үед нийтийн эрх ашгийн хүрээн дэх Хууль зүйн сайдын бүрэн эрхээс гадуур өөр олон нэхэмжлэх эрхтэй талуудыг бий болгохыг зорьсон явдал юм. Энэ хэргээс хойш Австралийн шүүхүүд нийтийн эрх ашгийг нэхэмжлэх хязгаарлагдмал эрхийг халах оролдлогыг маш идэвхтэйгээр хэрэглэж эхэлсэн байна.

³² *Boyce v Paddington Borough Council* буюу Паддингтон хотын иргэн Бойс нь Хотын зөвлөлийн эсрэг нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах зорилгоор шүүхэд нэхэмжлэл гаргасан.

БҮЛЭГ 2.

СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛӨЛ ХИЙХ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨМЖ

2.1 СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛЛИЙН ХЭРЭГ СОНГОХ НЬ

2.1.1 Стратегийн өмгөөлөл хийх шийдвэр гаргах нь

Бүх хэрэг, маргаан, асуудал нь стратегийн өмгөөлөл хийхэд тохиромжтой биш, зарим тохиолдолд зорилгодоо хүрэхийн тулд хэлэлцээр хийх, зүй ёсны нөлөөлөл явуулах зэргээр заавал шүүхэд хандахгүйгээр асуудлыг шийдвэрлэх боломжтой. Нөгөө талаас, аль ч төрлийн өмгөөлөл, тэр дундаа стратегийн өмгөөлөл нь нэлээдгүй хөрөнгө, цаг хугацаа, олон талын хамтын ажиллагаа, хүчин чармайлт шаарддагийг мартаж болохгүй. Стратегийн өмгөөллийг өөрчлөлт, шинэчлэлтийг хүчтэй эсэргүүцдэг байгууллага, албан тушаалтны эсрэг ашиглах нь хамгийн тохиромжтой юм.³³ Иймд стратегийн өмгөөллийн арга хэрэгслийг сонгох эсэхээ шийдэхдээ доор дурдсан гол хүчин зүйлсийг анхаарч үзэх нь зүйтэй:

а) Хүний эрх, нийтийн эрх ашгийн зөрчилтэй холбоотой хууль зүйн асуудал байгаа эсэх. Үүнд:

- Хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг байнга, ноцтой зөрчсөн, эсхүл зүй бусаар хязгаарласан хууль тогтоомж. Жишээ нь: олон улсын гэрээ, конвенцийг зөрчсөн дотоодын хууль тогтоомжийн асуудлаар стратегийн өмгөөлөл явуулж болно.

³³ Хүүхдийн Эрхийн Мэдээллийн Сүлжээ, "Хүүхдийн эрх: Стратегийн өмгөөлөл хийх удирдамж", Лондон, 2009, 20 дахь тал.

– Хуулийн хэрэгжилт хангалтгүй.

Тухайлбал, хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй, эсхүл огт хэрэгжихгүй байгаагаас хүний эрх зөрчигдөх зэргээр сөрөг үр дагавар үүссэн байж болно.

– Хүний эрх, ялангуяа, зорилтот бүлгийнхний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах жишиг тогтоох боломжтой эсэх.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1–д заасны дагуу Улсын дээд шүүх “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх замаар гаргах” бүрэн эрхтэй бөгөөд өнөө үед стратегийн өмгөөллийг энэ зорилгоор сонгох нь асуудал шийдвэрлэх бусад арга хэрэгслээс илүү ач холбогдолтой байж болно. Тодруулбал, нийтлэг тохиолдож буй, эсхүл хууль зүйн хувьд маргаан бүхий хүний эрхийн асуудлаар стратегийн өмгөөлөл явуулан шүүхэд ялалт байгуулах замаар нааштай тайлбарыг Улсын дээд шүүхээс гаргуулж чадсанаар бусад ижил төрлийн асуудлыг шийдвэрлэхэд сайн жишиг болох юм.

б) Шүүхийн шийдвэрийн үр нөлөө нь өргөн далайцтай, бодитой байж чагах эсэх.

Энэ нь стратегийн өмгөөллийн зорилго, үр дүнтэй шууд холбогдоно. Стратегийн өмгөөллөөр дамжуулан нийгэмд өргөн далайцтай, эерэг өөрчлөлтийг бодитойгоор авчрах, ялангуяа, нийгэмд тогтсон сөрөг хандлагыг өөрчлөх, олон нийтийг чадавхжуулах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, нийгмийн тодорхой бүлгийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчигдөхөөс сэргийлэх нь энэ төрлийн өмгөөллийн гол зорилго байдаг.

в) Стратегийн өмгөөлөл нь тухайн асуудлыг шийдвэрлэх хамгийн тохиромжтой арга хэрэгсэл мөн эсэх.

Тухайн асуудлыг шийдвэрлэх бусад арга хэрэгслийг сайтар нягталж, өөр хооронд нь харьцуулж үзсэний дүнд стратегийн өмгөөлөл хийх эсэхээ шийдэх нь зүйтэй. Тодруулбал, өмнө дурдсанчлан асуудлын мөн чанар, тухайн асуудлаар ямар үр дүнд хүрэхийг зорьж буй, оролцогч талуудын онцлог зэргээс хамааран стратегийн өмгөөлөл нь хамгийн оновчтой арга хэрэгсэл мөн эсэхийг тодорхойлох боломжтой.

2.1.2 Стратегийн өмгөөллийн хэрэг сонгох шалгуур

Тодорхой асуудлаар стратегийн өмгөөлөл хийх нь тохиромжтой эсэхийг шийдэхийн өмнө өмгөөллийн үр дүнд нөлөөлж болох эерэг, сөрөг бүхий л хүчин зүйлийг сайтар харгалзан үзэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудал нийгэмд байгаа гэдэгт л үндэслэн стратегийн өмгөөлөл хийхээр шийдвэрлэх нь хэт өрөөсгөл болно.

Аль нэг асуудлаар стратегийн өмгөөлөл хийх нь зайлшгүй хэмээн шийдсэнээр дараагийн алхам буюу тодорхой нэг хэрэг сонгох шаардлагатай болно. Тодруулбал, гарын авлагын 2.1.1 дэх хэсэгт дурдсан гурван төрлийн шаардлагыг тухайн сонгон авсан асуудал хангаж байна гэж үзвэл уг асуудлаарх олон хэрэг дундаас тодорхой нэгийг сонгох хэрэгтэй болно гэсэн үг юм. Стратегийн өмгөөллийн тодорхой хэргийг сонгохын тулд процессын шинжтэй доор дурдсан шаардлага, шалгуурыг хангаж буй эсэхийг нягтлан үзэх хэрэгтэй. Үүнд:

Стратегийн өмгөөллийн тодорхой хэрэг сонгох шалгуур

- Хүний эрх, нийтийн эрх ашгийн зөрчилтэй холбоотой хууль зүйн асуудал байгаа эсэх
 - Шүүхийн шийдвэрийн үр нөлөө нь өргөн далайцтай, бодитой байж чадах эсэх
 - Стратегийн өмгөөлөл нь тухайн асуудлыг шийдвэрлэх хамгийн тохиромжтой арга хэрэгсэл мөн эсэх
-
- Асуудал нь хууль зүйн үндэслэлтэй эсэх
 - Боломжит нэхэмжлэгч байгаа эсэх
 - Гарах зардал, зарцуулагдах хугацаа хангалттай эсэх
 - Тодорхой асуудлаар зөвлөх, дүгнэлт гаргах шинжээчид, мэргэжилтнүүд байгаа эсэх
 - Шүүхээс дэвшилттэй шийдвэрийг, хараат бусаар гаргаж чадах эсэх
 - Олон нийт, хэвлэл мэдээллийн зүгээс тухайн асуудалд хандах хандлага
 - Хэргийн хариуцагчийн байдал

Эдгээр шалгуурыг тодруулан авч үзвэл:

✓ **Асуудал нь хууль зүйн үндэслэлтэй эсэх**

Хууль зүйн үндэслэлтэй хэргийг сонгох нь шүүхэд ялалт байгуулж, өмгөөллийн зорилгодоо хүрэх чухал алхам болно. Тодруулбал, тухайн стратегийн өмгөөллөөр дамжуулан жишиг тогтоохоор зорьж буй тохиолдолд шүүхэд ялах магадлал сайтай хэргийг сонгох нь зүйтэй. Цаашилбал, энэ нь “Ялагдсан тал нь шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамжийг нөхөн төлдөг” хуулийн дагуу³⁴, ихээхэн хэмжээний мөнгөн хөрөнгө нэхэмжилсэн хэрэгт ялагдсан тохиолдолд мөн тийм хэмжээний шүүхийн зардал, тэмдэгтийн хураамж нөхөн төлөх үүргээс чөлөөлөгдөх явдлыг хангах ач холбогдолтой. Шүүхэд ялалт байгуулахад нөлөөлөх дараагийн нэг хүчин зүйл нь гомдол, нэхэмжлэлийн шаардлагыг хангах нотлох баримттай байх явдал билээ. Аль ч төрлийн өмгөөлөлд баримт нотолгоотойгоор маргах нь хэрэг, маргаандаа ялалт байгуулах үндэс суурь болдог.

Хэдийгээр нийгэмд шийдвэрлэвэл зохих олон асуудал, хэрэг, маргаан байдаг ч тэр бүгдийг шүүхээр шийдвэрлүүлж, ялах баталгаа байдаггүй. Тодруулбал, тухайн асуудал нь хүний эрхийг зөрчиж байгаа хэдий ч, шүүхээр шийдвэрлүүлэхэд хууль зүйн үндэслэл муутай тохиолдолд маргаан шийдвэрлэх өөр арга хэрэгслийг ашиглах нь илүү тохиромжтой. Гэхдээ стратегийн өмгөөллийн туйлын зорилго нь гагцхүү шүүхэд ялалт байгуулахад бус, харин тухайн өмгөөллөөр дамжуулан хүний эрхийн зөрчил, нийгмийн тулгамдсан асуудалд төр засаг, олон нийтийн анхаарлыг хандуулах, шүүх, нийгмийн институцийн тогтсон сөрөг хандлагыг өөрчлөх, хууль шинээр батлуулах, боловсронгуй болгох зэрэгт чиглэсэн байж болно. Энэ тохиолдолд, стратегийн өмгөөллийн хэрэг сонгох энэхүү шалгуур нь төдийлөн ач холбогдолтой биш юм.

✓ **Боломжит нэхэмжлэгч байгаа эсэх**

Өмгөөллийн үйл ажиллагаанд цаг хугацаа нэлээдгүй шаардагддаг тул өмгөөллийн явцад эхнээс нь дуустал тууштай оролцоход бэлэн, хууль зүйн хувьд нэхэмжлэх эрхтэй субъект байгаа эсэх нь харгалзан үзвэл зохих нэгэн чухал хүчин зүйл юм. Стратегийн өмгөөлөл хийх асуудал, хэрэгцээ,

³⁴ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, УИХ-аас 2002 онд баталсан, 56 дугаар зүйлийн 56.1, 60 дугаар зүйл

шаардлага байгаа ч нэхэмжлэх эрхтэй буюу эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн нь хуулийн дагуу нотлогдох боломжтой нэхэмжлэгчийг олоход бэрхшээлтэй байж болно. Тодруулбал, шүүхийн урт удаан процесс, эрүүл мэнд болон ар гэрийн гачигдал, олон нийт, хэвлэл мэдээллийн хэрэгслийн хараанд өртөхөөс бэрхшээх зэргээр явцын дунд нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзах тохиолдол гардаг. Ялангуяа нийтийн эрх ашгийг шүүхэд нэхэмжлэх эрх хязгаарлагдмал манай улсын хувьд боломжит нэхэмжлэгчийг олох нь нэлээдгүй бэрхшээлтэй тулгардаг. Энэ талаар “Стратегийн өмгөөлөл хийхэд тулгарч болох бэрхшээл” хэсгээс дэлгэрүүлэн үзнэ үү.

✓ **Гарах зардал, зарцуулагдах цаг хугацаа боломжтой эсэх**

Стратегийн өмгөөлөл нь өмгөөлөл, нөлөөлөл, олон талын хамтын ажиллагаа, хүчин чармайлт шаардлагатай цогц үйл ажиллагаа байдаг тул үүнд хөрөнгө мөнгө, цаг хугацаа ихээр зарцуулагддаг. Ялангуяа байгаль орчны гэх мэт хэргийн хувьд хөдөө орон нутагт амьдарч буй нэхэмжлэгчидтэйгээ очиж уулзах, шүүх хуралдаанд бэлтгэх, сургах, төв рүү авчирч шүүх хуралдаанд оролцуулах, байгаль орчны мэргэжилтнүүдийг газар дээр нь аваачиж тусгай асуудлаар зөвлөгөө авах зэргээр хөрөнгө нөөц ихээр шаарддаг. Гарах зардал нь хэт өндөр, өмгөөллийн үйл ажиллагааг санхүүжүүлэх боломжгүй тохиолдолд стратегийн өмгөөллөөс татгалзаж, өөр арга хэрэгслийг сонгох нь илүү дээр шийдэл байж болох юм.

Стратегийн өмгөөллийн хэрэгт зарцуулах хугацаа хэт сунжрах нь хэргийн оролцогчид, ялангуяа, нэхэмжлэгчийг залхааж, идэвхтэй оролцоог нь бууруулах, нэхэмжлэлээс татгалзахад хүргэх, зардлыг үр ашиггүй нэмэгдүүлэх зэрэг сөрөг талтай байдаг. Тиймээс тухайн төрлийн хэрэг, маргааныг шүүхээр хянан шийдвэрлэх хуулийн хугацаа (давж заалдах, хяналтын шатны шүүхүүдээр хэргийг хянан шийдвэрлүүлэх хугацааг оруулж тооцох) болон шаардлагатай тохиолдолд олон улсын түвшинд асуудлаа шийдвэрлүүлэх (энэ нь дотоодын механизмуудыг гүйцээсний эцэст хэрэглэгдэнэ) хугацааг нарийн тооцоолж, тэрхүү хугацааг шаардсан өмгөөллийн эцэст гарах шүүхийн шийдвэр нь нэхэмжлэгчид, нийгэмд практик үр нөлөө хэр үзүүлэхийг харгалзаж үзсэний дүнд стратегийн өмгөөлөл хийх эсэхээ шийдэх нь зүйтэй.

✓ **Тодорхой асуудлаар зөвлөх, дүгнэлт гаргах шинжээчид, мэргэжилтнүүд байгаа эсэх**

Стратегийн өмгөөлөл нь ихэвчлэн шүүхээр урьд өмнө шийдвэрлэгдсэн практик байхгүй, нийгэмд шинэ тутам үүссэн асуудлаар жишиг тогтоох зорилгоор хийгддэг тул тухайн асуудлаар мэргэжилтнүүдийн зөвлөгөөг авах, дүгнэлт гаргуулах шаардлага нэлээдгүй тулгардаг. Тухайлбал, уул уурхайн олборлолтын дараа эвдэгдсэн газрыг нөхөн сэргээхгүй орхисноос ойролцоох гол, нуур, худгийн ус татарсан, ширгэсэн, бохирдсон хэрэгт мэргэжлийн зөвлөгөөг усны ерөнхий мэргэжилтэн биш, зөвхөн газрын гүний усны асуудлаар мэргэшсэн мэргэжилтэн л өгөх боломжтой байдаг. Иймд тухайн сонгон авах асуудлаар мэргэжлийн зөвлөгөө өгч чадах, салбарын мэргэжилтнүүд, шинжээчид байгаа эсэхийг анхаарч үзэх шаардлагатай юм.

✓ **Шүүхээс дэвшилтэй шийдвэрийг, хараат бусаар гаргаж чадах эсэх**

Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ хуулиас гадна олон улсын болон үндэсний хууль тогтоомжид тусгагдсан хүний эрхийн суурь зарчмуудыг харгалзан үзэж, дэвшилтэй, хүний эрхийн мэдрэмжтэй шийдвэрийг гаргаж чаддаг шударга, хараат бус шүүх тогтолцоо стратегийн өмгөөллийн үр дүнд чухал нөлөөтэй.

Шүүхээс гарах дэвшилтэт шийдвэрийн жишээг дурдвал, зөвхөн нэхэмжлэлийн шаардлагаар хязгаарлагдахгүйгээр, зөрчигдсэн эрхийг бүх талаар сэргээх шийдвэр гаргах, эсхүл тухайн төрлийн зөрчил дахин гарахаас урьдчилан сэргийлэхийн тулд буруутай байгууллага, албан тушаалтан, хувь хүмүүст тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгах, олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцуудад тусгагдсан зарчмыг шүүхийн шийдвэр гаргахдаа харгалзан үзэх зэргийг дурдаж болох юм.

✓ **Олон нийт, хэвлэл мэдээллийн зүгээс тухайн асуудалд хандах хандлага**

Стратегийн өмгөөлөл нь өмгөөлөл, нөлөөллийн цогц ажиллагаа учраас асуудлыг олон нийт, хэвлэл мэдээллийн анхаарлын төвд авчрах боломжтой эсэх, үүнээс гарах эерэг, сөрөг нөлөө юу байж болох, олон нийт, хэвлэлийнхний зүгээс тухайн асуудалд хандах хандлага зэргийг стратегийн өмгөөллийн хэрэг сонгохдоо анхаарах нь зүйтэй. Асуудлыг олон нийтэд мэдээлснээр

тухайн хэргийн нэхэмжлэгч, гэрч, хохирогчид аюул занал учрах, эсхүл улс төрийн зорилготой болон бусад шүүмжлэл, эсэргүүцэл, дарамт шахалт гарч болзошгүй. Тухайлбал, эмзэг хохирогчтой буюу хүн худалдаалах, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг бэлгийн мөлжлөг зэрэг хэрэг дээр стратегийн өмгөөлөл хийснээр хохирогч, түүний гэр бүлд сөрөг үр дагавар учруулахаар бол тухайн хэргийг сонгох нь тохиромжгүй.

✓ Хэргийн хариуцагчийн байдал

Өөрчлөлт, шинэчлэлтийг хүлээн зөвшөөрдөггүй, түүний эсрэг хандлагатай төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаанаас үүдсэн асуудлаар стратегийн өмгөөлөл хийх нь хамгийн тохиромжтой шийдэл байж болно. Нөгөөтэйгүүр, стратегийн өмгөөллийн үр дүнд шийдвэр, үйл ажиллагаа нь өөрчлөгдсөнөөр тухайн салбар, тогтолцоо, эсхүл нийгэмд тодорхой эерэг нөлөөтэй байж болох этгээдийг хариуцагчаар сонгох нь тохиромжтой. Тухайлбал, шийдвэр гаргахад оролцох нутгийн иргэдийн эрхийг хангах үүргийг хуулиар хүлээсэн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтны энэ талаарх ойлголт, хандлага, хүлээсэн үүргийнх нь хэрэгжилт зэргийг стратегийн өмгөөллийн тодорхой хэргээр дамжуулан өөрчлөх, сайжруулах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд тэднийг анхнаас нь хариуцагчаар тодорхойлон энэ чиглэлээр өмгөөлөл хийж болно.

2.2 СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛӨЛ ХИЙХ ПРАКТИК АЛХАМ, АНХААРАХ АСУУДАЛ

Стратегийн өмгөөлөл хийхээр шийдэж, тодорхой хэргийг дээрх шалгуурын дагуу сонгон авсны дараа тухайн хэрэг дээр хэрхэн ажиллах арга тактикаа боловсруулах шаардлагатай болно. Сонгосон хэрэг дээрээ амжилттай ажиллахын тулд урьдаас бодож төлөвлөсөн стратегитай байх нь хамгийн зөв алхам юм. Стратегийн өмгөөллийн хэрэг дээр ажиллахад анхаарвал зохих нийтлэг асуудал, арга тактикийг доор тайлбарлав.

2.2.1 Стратегийн өмгөөлөл хийхэд анхаарах хүчин зүйлс

1. Өмгөөллийн зорилгоо тодорхойлох

Стратегийн өмгөөлөл хийхэд анхаарах асуудал

1. Өмгөөллийн зорилгоо тодорхойлох
2. Нэхэмжлэгчийг сонгох тактикаа сонгох
3. Хариуцагчийг сонгох
4. Аль шүүхэд хандахаа шийдэх
5. Хуулийн заалтыг бүтээлчээр хэрэглэх
6. Нөлөөллийн цогц стратегитай байх
7. Шүүх, хууль хяналтын бусад байгууллагыг мэдээллээр хангах
8. Хамтран ажиллагсдаа тодорхойлох
 - Гадаад, дотоодын шинжээчид, мэргэжилтнүүдийн багтай хамтран ажиллах, зөвлөлдөх
 - Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах
 - Хууль зүйн мэргэшсэн фирмүүдтэй зөвлөлдөх
9. Жишиг хэрэг хэрэглэх
10. Нэг асуудлаар хэд хэдэн байгууллагад хандах
11. Олон улсын арга, журмыг ашиглах
12. Анхаарвал зохих бусад асуудал

Стратегийн өмгөөллийн нийтлэг зорилго нь тодорхой жишиг хэргээр дамжуулан хууль, тогтолцоог шинэчлэх, боловсронгуй болгох, хэрэгжилтийг сайжруулах, тогтсон практикийг халах, нийгмийг өөрчлөн, шинэчлэхэд чиглэгддэг. Харин стратегийн өмгөөллийн тодорхой нэг хэрэг сонгон авсны дараа дээрх нийтлэг зорилгод нийцсэн, тухайн стратегийн өмгөөллийн тусгай зорилгоо тодорхойлох шаардлагатай. Тухайлбал, стратегийн өмгөөллийн тодорхой нэг хэргээр дамжуулан салбарын хуулийг өөрчлөх, хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг ил тод болгох,

буруутай албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах замаар хариуцлагыг сайжруулах, цаашид тухайн төрлийн зөрчил давтагдахгүй байх орчин нөхцөлийг бүртгүүлэх зэрэг нь өмгөөллийн тусгай зорилго байж болно. Гэхдээ тухайн сонгосон хэрэгтээ шүүхэд ялалт байгуулах нь стратегийн өмгөөллийн үр нөлөөг дээшлүүлэх, сайн практик тогтоох чухал ач холбогдолтой ч, өмгөөллийн зорилго нь шүүх дээр ялахдаа бус, харин тодорхой хэргээр дамжуулан хууль тогтоомжийн боловсронгуй биш байдал, анхаарвал зохих бусад асуудал байгааг төр засаг, олон нийтийн сонорт хүргэх явдал байж болохыг ч анхаарах хэрэгтэй.

Жишээ: Шинэ төрлийн гэмт хэргийг хуульчлах, улмаар тусгай хууль батлуулах, холбогдох олон улсын гэрээнд нэгдэх тухай шийдвэр гаргуулах өмгөөллийн зорилгодоо хүрсэн нь

Хүний эрх хөгжил төвөөс 2001 оноос хийж эхэлсэн хүн худалдаалах гэмт хэргийн стратегийн өмгөөллийн зорилго нь хүн худалдаалахыг гэмт хэрэгт тооцуулах явдал байсан бөгөөд энэ зорилгодоо 2002 онд хүрч, Эрүүгийн хуульд хүн худалдаалах гэмт хэргийг тусгуулж чадсан. Үүгээр ч зогсохгүй Монгол Улс 2008 онд Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай Палермогийн протоколд нэгдэж, 2012 онд Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулиа баталсан юм. Эндээс Хүний эрх хөгжил төвийн уг стратегийн өмгөөлөл нь зорилгодоо амжилттай хүрсэн сайн жишээ болохыг харж болно.

2. Нэхэмжлэгчээ сонгох тактик

Сонгосон хэрэг дээрээ тохирох нэхэмжлэгч олж болох янз бүрийн эх сурвалж, арга зам байдгаас дурдвал:

- газар дээр нь очиж уулзалт, ярилцлага хийх;
- эрх зүйн туслалцааны төвүүд, төрийн бус байгууллагуудад хандах;
- түгээмэл тохиолддог хүний эрхийн зөрчлийн талаар гомдол, мэдээлэл хүлээн авдаг байгууллагууд тухайлбал, Үйлдвэрчний эвлэл, орон нутаг дахь нийгмийн халамжийн төвүүдэд хандах;
- зорилтот бүлэгт сургалт явуулах, хэлэлцүүлэг хийх;
- олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлах;
- ижил зорилготой бусад хуульчтай холбоо тогтоох, уулзалт, семинар хийх зэрэг болно.

Сонгон авсан хэрэгтээ нэхэмжлэгчийг оновчтой сонгож чадаагүйгээс өмгөөллийн явцыг удаашруулах эрсдэлтэй. Тиймээс нэхэмжлэгчийг сонгохдоо доорх шалгуурыг хангаж байгаа эсэхийг харгалзаж үзэх нь зүйтэй:

а. Хууль зүйн хувьд нэхэмжлэх эрхтэй этгээд байх

- ✓ Субъектив эрх нь зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй этгээд байх

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиудад заасны дагуу зөвхөн өөрийнх нь субъектив эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн этгээд өөрөө буюу бусдаар төлөөлүүлэн нэхэмжлэл гаргах эрхээр хангагдсан.³⁵ Иймд нэхэмжлэгчийг сонгохдоо анхаарах нэн тэргүүний асуудал бол тухайн хэргийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн, хуулийн дагуу нэхэмжлэх эрхтэй субъект мөн эсэх юм. Ялангуяа нийтийн эрх ашгийн өмгөөллийн хэрэгт эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн этгээд нь ихэнхдээ тухайлсан нэг этгээд биш, олон нийт байдаг бөгөөд хууль зүйн хувьд нэхэмжлэх эрхтэй гэж тооцогдох нэхэмжлэгчийг сонгож чадаагүйгээс хэрэг хэрэгсэхгүй болох тохиолдол бий.

Хууль ёсны нэхэмжлэх эрхтэй этгээдийг сонгоход анхаарах өөр нэг асуудал бол хэргийнхээ онцлогоос хамааран хоёр буюу түүнээс дээш тооны нэхэмжлэгчийг сонгох явдал. Ганцхан нэхэмжлэгчийг сонгосноос үүдэн учирсан бэрхшээлийг гарын авлагын энэ хэсэгт дурдагдсан "Сонгосон нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан тухай" жишээнээс харж болно.

- ✓ Нийтийн эрх ашгийн зарим асуудлаар нэхэмжлэх эрх хуулиар олгогдсон төрийн байгууллага, албан тушаалтан
 - Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1–д заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комисст "аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах" бүрэн эрх олгогдсон.

³⁵ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 26 зүйлийн 26.2 дахь хэсэг

- Прокурорын байгууллагын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу прокурор нь төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд итгэмжлэлгүйгээр, мөн хуульд заасан тохиолдолд бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрхтэй.
- Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.9 болон 57 дугаар зүйлийн 57.2–т заасны дагуу сум, дүүргийн Засаг дарга нь байгаль орчинд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.
- Гэр бүлийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5, 25.8–д заасны дагуу асран хамгаалах, харгалзандэмжих хүнгүй хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг сум, дүүргийн Засаг дарга хамгаалах үүргийг хүлээнэ.

Төрийн байгууллага, албан тушаалтан нь нийтийн эрх ашиг, хүний эрхийн асуудлаар тийнхүү нэхэмжлэгчээр оролцох нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрсдийн нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргах, улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөх³⁶ давуу талтай хэдий ч, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад төр засгийн удирдлага солигдсоноор өмнө нь тухайн албан тушаалыг эрхэлж байсан субъектээс олгогдсон итгэмжлэлийг дараагийн томилогдсон албан тушаалтан дуусгавар болгох, зарим тохиолдолд зөвхөн төрийн байгууллага хүсэлт гаргасан тохиолдолд л тухайн асуудлаар нийтийн эрх ашгийг хамгаалж нэхэмжлэл гаргах зэрэг сул тал бий. Нийтийн эрх ашгийн өмгөөллийн хэрэгт төрийн албан тушаалтнаас итгэмжлэл авч ажиллан, улмаар нэхэмжлэл хэрэгсэхгүй болгогдсон жишээг дор дурдав.

Жишээ: Засаг дарга итгэмжлэлээсээ татгалзсанаар нийтийн эрх ашгийн өмгөөллийн хэрэг хэрэгсэхгүй болсон нь

Дорнод аймгийн нэгэн сумын нутагт уул уурхайн компани алт олборлосны дараа 46.6 га газарт нөхөн сэргээлт хийгээгүй бөгөөд уг газрыг нөхөн сэргээхийг даалгах нэхэмжлэлийг Хүний эрх хөгжил төвийн хуульчдаас 2008 оны эхээр Баянгол дүүргийн шүүхэд гаргасан байна. Уг хэрэгт хуулийн дагуу нэхэмжлэх эрхтэй субъект нь зөвхөн

³⁶ Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, УИХ–аас 2010 онд батлагдсан, Зүйл 41(1(3))

сум, дүүргийн Засаг дарга байсан учраас сумын Засаг даргын зүгээс хуульчдад итгэмжлэл олгосон байдаг. Тийнхүү анхан болон давж заалдах шатны шүүхэд ялалт байгуулсны эцэст Улсын Их Хурлын Иргэний хэргийн танхимаас уг хэргийг дахин хянан хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаагаад байхад нь шинээр томилогдсон сумын Засаг дарга нь итгэмжлэлийг дуусгавар болгосон байна.³⁷

Дээрхтэй адил жишээ Монголын байгаль хамгаалах иргэний хөдөлгөөний эвслийн нэхэмжлэлтэй, Б компанид холбогдох “Байгаль орчны хохирол гаргуулах тухай” нэхэмжлэлтэй хэргийн явцад мөн тохиолдсон байдаг.³⁸

- ✓ Хуулиар эрх олгогдсон, зарим салбарын төрийн бус байгууллага, иргэн
 - Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6–д заасны дагуу Үйлдвэрчний эвлэл нь гишүүд, ажилтныхаа зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоолгохоор шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй.
 - Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтын дагуу иргэн болон байгаль орчин, түүний баялгийг хамгаалах дүрмийн зорилго бүхий олон нийтийн байгууллага нь ... гэм буруутай этгээдээс байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

б. *Нэхэмжлэгч нь хэргийг эхнээс нь дуустал тууштай, шантрахгүй оролцоход бэлэн, үнэнч шударга байх*

Аль ч төрлийн өмгөөлөл нь цаг хугацаа нэлээд шаарддаг, хэвлэл мэдээлэл, олон нийтийн хараанд өртөх, цаашилбал, хэргийн оролцогчийн сэтгэл санаа, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүсэх тохиолдол бий. Тиймээс нэхэмжлэгчид энэ бүхнийг анхнаас нь ойлгуулсны үндсэн дээр болзошгүй эрсдэлд шантрахгүй, тууштай байж чадах амлалтыг авсан байх нь чухал. Цаашилбал, нэхэмжлэгчийг сонгохдоо олон нийтийн дунд нэр хүнд сайтай, бусдын нөлөөнд амархан автахааргүй зан байдлыг нь мөн харгалзаж үзэх хэрэгтэй. Мөн нэхэмжлэгч нь өмгөөллийн

³⁷ Хүний эрх хөгжил төв, “Нийтийн эрх ашгийг нэхэмжлэх эрхийг нээлттэй болгох нь”, Судалгааны тайлан, УБ, 2010 он, 10 дахь тал.

³⁸ Холбогдох шүүхийн шийдвэрийг Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сангаас үзнэ үү. Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан <<http://shuukh.mn/irgenanhan/34029/view>>.

явцад шаардлагатай үйл ажиллагаанд өөрөөс үл хамаарах элдэв саад бэрхшээлгүйгээр (эрүүл мэндийн хувьд хэвийн, ар гэрийн зүгээс дэмжих дэмжлэг зэрэг) зохих түвшинд оролцож чадах бодит боломжтой эсэхийг тооцоолж үзэх нь зүйтэй юм. Нэхэмжлэгчээ оновчтой сонгож аваагүйгээс хэрэг явцын дунд хэрэгсэхгүй болох, нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзах зэрэг сөрөг үр дагаварт хүрч болохыг доорх жишээнээс харна уу.

Жишээ: Сонгосон нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан нь

2007 онд Хүний эрх хөгжил төвөөс эхлүүлсэн, Төв аймгийн нэгэн сумын нутагт тусгай хэрэгцээний газарт олгогдсон ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцлуулах тухай нийтийн эрх ашгийн өмгөөллийн хэргийн нэхэмжлэгчээр уг тусгай хэрэгцээний газарт амьдардаг малчин А-г сонгосон. Түүнийг сонгосон шалтгаан нь А нь уг тусгай зөвшөөрөл олгогдсон газрын орчимд амьдардаг, хаваржааны газартай нэгэн. Хуулийн дагуу эрх нь зөрчигдсөн тул хуульчид А-г нэхэмжлэгчээр сонгон хэрэг хянан шийвэрлэх ажиллагааг эхлүүлэн жил гаруйн хугацаа өнгөрсөн бөгөөд хэрэг шүүхийн шатанд байхад нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан юм. Татгалзсан шалтгаан нь нэхэмжлэгч шүүхэд хэд хэдэн удаа дуудагдан байцаалт өгсний дээр зарим хэвлэл мэдээллийн хэрэгслээр өөрийнх нь тухай мэдээлэл гарсан нь хууль, шүүхийн байгууллагад төдийлэн ханддаггүй, хөдөөний хүний хувьд бэрхшээлтэй санагдсаны зэрэгцээ эрүүл мэндийн байдал хэвийн биш байсан нь ч давхар нөлөөлсөн. Тийнхүү, хэргийн ганц нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсанаар уг хэргийг хэрэгсэхгүй болгосон юм.

3. Хариуцагч сонгох

Хариуцагч сонгох боломжтой тохиолдолд хамгийн түрүүнд өмгөөллийн зорилго буюу тухайн хэргээр дамжуулан ямар үр дүнд хүрэхээр зорьж буй нь нөлөөлнө. Гэхдээ энэ нь мэдээж тухайн этгээдийг хариуцагчаар татах хууль зүйн үндэслэлтэй эсэхээс ихээхэн хамаарна. Хариуцагчаа хууль зүйн үндэслэлтэй сонгосон эсэхээс хэргийн амжилт шалтгаалах нь тодорхой юм. Цаашилбал, олон боломжит хариуцагч байх тохиолдолд чухам хэнийх нь шийдвэр, үйл ажиллагаанаас болж илүү их хохирол учирсан, цаашид учрах эрсдэлтэйг тооцоолох нь зүйн хэрэг.³⁹

Монгол Улсад одоогийн байдлаар хийгдээд буй стратегийн өмгөөллийн хэргийн жишээнээс харахад төрийн байгууллага, албан тушаалтан, бизнесийн байгууллагуудыг хариуцагчаар хамгийн түгээмэл татсан байдаг. Төр болон хувийн хэвшлийн

³⁹ Хүүхдийн Эрхийн Мэдээллийн Сүлжээ, зүүлт 33, 19 дэх тал

байгууллагын аль алийг нь хариуцагчаар татах боломжтой тохиолдолд тухайн хэргийн өмгөөллийн зорилгоо харгалзах, эсхүл хоёуланг зэрэг хариуцагчаар татаж болно (гуравдагч этгээдээр оролцуулах, эсхүл өөр журмаар хэрэг үүсгүүлж болно). Стратегийн өмгөөллийн зорилго нь хуулийн хэрэгжилтийг хангуулах явдал бол компанийг бус төрийг хариуцагчаар татах нь илүү тохиромжтой байж болно. Цаашилбал, төрийг төлөөлүүлэн чухам ямар байгууллага, албан тушаалтныг тухайлбал, Засгийн газрыг уу, эсхүл түүний аль нэг агентлагийг уу, эсхүл тодорхой асуудлыг дагнан хариуцсан хэлтэс, орон нутгийн мэргэжилтэн үү гэх мэтээр оновчтой сонгох шаардлага тулгардаг.

Цаашид, хөдөлмөр хамгаалал, барилгын аюулгүй байдал, нийтийн хэрэгцээний зам талбайн ашиглалт, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх зэрэг тулгамдсан асуудлаар бизнесийн байгууллагыг хариуцагчаар татан хуулийг хэрэгжүүлэх, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах талаар тодорхой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэх боломжтой.

Жишээ: Засгийн газрыг хариуцагчаар татсан нь

Монголын гол нууруудын нэгдсэн хөдөлгөөний нэхэмжлэлтэй, Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ... зэрэг шаардлага бүхий иргэний хэрэгт Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтын дагуу Монгол Улсын Засгийн газрыг хариуцагчаар татжээ.⁴⁰

4. Аль шүүхэд хандахаа шийдэх

Аль шүүхээр хэргээ шийдвэрлүүлэх нь ихэнхдээ нэхэмжлэгчийн хүсэл зоригоос хамаарахгүй хэдий ч, хэргээ шийдвэрлүүлэх шүүхийн байр суурь, шийдвэрээ хараат бусаар гаргаж чадах байдал, хүний эрх, нийтийн эрх ашгийн асуудалд хүндэтгэлтэй ханддаг эсэх, төсөөтэй хэргийг хэрхэн шийдвэрлэсэн практик зэрэгт үндэслэн ямар журмаар, аль нутаг дэвсгэрийн шүүхэд хандахаа шийдэх хэрэгтэй. Тодруулбал, нийгмийн аль нэг ерөнхий асуудлаар стратегийн өмгөөлөл хийхээр шийдсэний дараа тодорхой нэг хэргийг сонгох хэрэгтэй болдог талаар "Стратегийн өмгөөллийн тодорхой хэрэг сонгох шалгуур" хэсэгт өгүүлсэн билээ. Ерөнхий асуудлын дундаас стратегийн

⁴⁰ Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан, <<http://www.shuukh.mn/irgenanhan/3652/view>>

өмгөөллийн тодорхой нэг хэргийг сонгохдоо хэргийн болон шүүхийн харьяаллын хувьд сонголт (эрүү, иргэн, захиргааны журмаар болон аль нутаг дэвсгэрийн шүүх) байвал дээрх шалгуурын дагуу судалж үзсэний дүнд сонголтоо хийх нь тухайн хэрэгт ялалт байгуулах нэг хүчин зүйл болно.

5. Хуулийн заалтыг бүтээлчээр хэрэглэх

Стратегийн өмгөөллийн нэг зорилго нь хуулийн хэрэгждэггүй заалтыг хэрэгжүүлэх, хуулийг өөрчлөн боловсронгуй болгоход чиглэдэг. Тиймээс энэ төрлийн өмгөөллийн явцад тэр бүр хэрэглэгддэггүй хуулийн зүйл, заалтыг тухайлбал, Үндсэн хууль болон олон улсын гэрээний заалтыг илүү бүтээлч, дэвшилттэй байдлаар хэрэглэх замаар өргөдөл, нэхэмжлэлийн үндэслэлээ дэмжиж болно. Үүнд, Монгол Улсын Үндсэн хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, НҮБ-ын хүний эрхтэй холбоотой бусад гэрээ, конвенцууд, олон улсын нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн заншлын болон ёс суртахууны хэм хэмжээ зэргийг дурдаж болно.

Жишээ: Үндсэн хуулийг бүтээлчээр хэрэглэсэн нь

Зориг сангаас 2010 онд хэрэгжүүлсэн “Шилжин суурьшигчдын эрхийг хамгаалах” стратегийн өмгөөллийн хэрэг нь үндсэндээ Монгол Улсын иргэний Үндсэн хуулиар баталгаажсан эрх зөрчигдсөн асуудлаар байсан бөгөөд энэ хэрэг дээр ажилласан хуульчид нь нэхэмжлэлийнхээ үндэслэлийг гаргахдаа захиргааны албан тушаалтнаас иргэний шилжилт хөдөлгөөнийг бүртгэхгүй байгаа эс үйлдэхүй нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлгийн Арванзургадугаар зүйлийн 18-д заасан эрхийг зөрчиж байна гэжээ. Энэхүү стратегийн өмгөөллийг хэрэгцээ, шаардлага, хууль зүйн үндэслэл аль аль талаас нь дүгнэхэд энэ өмгөөлөл нь цаг үеэ олсон, шинэлэг үндэслэл бүхий болжээ.⁴¹

Жишээ: Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхсан хэрэгт Үндсэн хууль болон олон улсын гэрээг хэрэглэсэн нь

1984 онд батлагдсан Ботсваны Харьяатын тухай хуулиар Ботсваны иргэн эмэгтэй гадаад хүнтэй гэрлэсэн тохиолдолд нөхөр, хүүхдэд нь тус улсын иргэний харьяалал олгохгүй, харин Ботсваны иргэн эрэгтэйн тохиолдолд энэ зарчим үйлчлэхгүй гэсэн заалт оржээ. Юнити Доу хэмээх хүний эрхийн идэвхтэн эл заалтыг эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхахын эсрэг олон улсын гэрээ, конвенц болон Үндсэн хуулийг зөрчсөн гэсэн үндэслэлээр шүүхэд нэхэмжлэл гарган амжилттай шийдүүлсэн байдаг.⁴²

⁴¹ Зориг сан, “Шилжин суурьшигчдын эрхийг хамгаалах асуудлаарх стратегийн өмгөөллийн төслийн тайлан 2010”, УБ, 2010 он, 4 дэх тал.

⁴² Нээлттэй Нийгэм Форум, зүүлт 6, 71 дэх тал.

6. Нөлөөллийн цогц стратегитай байх

Стратегийн өмгөөлөлд нөлөөлөл нь онцгой байр суурийг эзэлдэг. Нэг талаас нөлөөллийн үйл ажиллагаа нь хэргийг амжилттай шийдвэрлүүлэхэд эерэгээр нөлөөлөх төдийгүй, шүүхийн шийдвэрийг бодитойгоор хэрэгжүүлэхэд тодорхой хэмжээгээр хувь нэмэртэй. Олон нийтийн кампанит ажил, олон нийтэд мэдээлэл өгөх, сургах, хэвлэл мэдээлэлтэй харилцах төлөвлөгөөтэй байх нь нөлөөллийн ажлын үр нөлөөг нэмэгдүүлнэ. Гэхдээ нөлөөллийн үйл ажиллагааг төлөвлөхдөө ялангуяа, нэхэмжлэгч, хохирогч, гэрчийн аюулгүй байдал, тэдний сэтгэл санааны хэвийн байдлыг хангах, олон нийтийн дунд буруу ойлголт төрүүлэхээс сэргийлэх зэрэг асуудлыг сайтар анхаарах нь зүйтэй.

7. Шүүх, хууль хяналтын бусад байгууллагыг мэдээллээр хангах

Стратегийн өмгөөллийн хэрэг нь нийгэмд шинэ тутам үүссэн, эсхүл урьд өмнө шүүхээр шийдвэрлэгдэж байгаагүй асуудлаар хийгдэх нь түгээмэл. Тухайлбал, Монгол Улсад хүний эрх, байгаль орчны зарим төрлийн хэргүүд (уул уурхайн нөхөн сэргээлт хийгээгүйгээс газрын хэвлийд хохирол учрах зэрэг), хүн худалдаалах гэмт хэргийн асуудлаар цөөнгүй стратегийн өмгөөллийн хэргийг шүүхээр шийдвэрлүүлсэн. Дээрх шинэ асуудлаар тодруулбал, байгаль орчны нөхөн сэргээлтийг хийгээгүйгээс хүний ямар эрх зөрчигдсөн, байгаль орчны болон нутгийн уугуул иргэдийн эрх гэдэгт чухам ямар асуудлыг хамруулан ойлгох, хүн худалдаалах гэмт хэргийн гэрч, хохирогчийг байцаах онцлог, хамгаалалтад авах хэрэгцээ, шаардлага, уг асуудлаарх олон улсын гэрээ конвенц зэрэг хүний эрх, нийтийн эрх ашгийн асуудлаар шүүгч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокуроруудыг тодорхой ойлголттой болгосноор стратегийн өмгөөллийн хэргийг амжилттай шийдвэрлүүлэхэд дөхөм болно.

Жишээ: Шүүх, хууль сахиулах ажилтнуудад сургалт хийсэн нь

Хүний эрх хөгжил төвөөс байгаль орчин болон хүн худалдаалах гэмт хэргийн асуудлаар стратегийн өмгөөлөл хийхийн зэрэгцээ дээрх асуудлаар нийслэлийн болон хөдөө, орон нутгийн шүүгч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокуроруудад зориулан хэд хэдэн удаагийн сургалтыг зохион байгуулсан байдаг.

8. Хамтран ажиллагсдаа тодорхойлох

- Гадаад, дотоодын шинжээчдийн баг
- Төрийн бус байгууллагууд
- Хууль зүйн мэргэшсэн фирмүүд

Шинжлэх ухааны тусгай мэдлэг шаардсан, байгаль орчин, эрүүл мэнд зэрэг асуудлаар ажиллахад гадаад, дотоодын шинжээчдийн багтай хамтран ажиллах шаардлага тулгардаг. Салбарын мэргэжилтнээс зөвлөгөө авахгүйгээр ажиллах нь стратегийн өмгөөллийн хэргийн амжилтад сөргөөр нөлөөлж болох талтай.

Стратегийн өмгөөлөгчид нь ажиллаж буй чиглэлийнхээ төрийн бус байгууллагуудаас холбогдох асуудлаар мэдээлэл авах, сургалт зохион байгуулах, мэдээ, нийтлэл бэлтгэх, олон нийтийн кампанит ажил зохион байгуулахад туслалцаа авч болно. Төрийн бус байгууллага нь ажилладаг салбар, чиглэлээрээ мэдээллийн өргөн бааз суурьтай байдаг. Ялангуяа, нэхэмжлэгч сонгох, тэднийг идэвхжүүлэхэд төрийн бус байгууллагуудтай хамтрах нь хамгийн сайн шийдэл юм.

Түүнчлэн тодорхой эрх зүйн салбараар нарийн мэргэшсэн хуулийн фирм, Интеррайтс⁴³, Эмнести Интернэшнл⁴⁴, Байгаль орчны хуульчдын холбоо,⁴⁵ Нийтийн эрх ашгийн хуулийн Дэлхий нийтийн Сүлжээ⁴⁶ зэрэг олон улсын хэмжээний томоохон байгууллагуудын хуульчдаас мөн зөвлөгөө авч болно. Дэлхийн бусад олон оронд хуулийн фирмүүд про боно буюу хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээг нийтийн тусын тулд болон нийгмийн эмзэг хэсгийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор үнэ төлбөргүй, эсхүл маш бага хөлстэйгээр үзүүлдэг. Монгол Улсад ч энэ асуудал шинээр нэвтрэх эхлэл тавигдаж байна.

9. Жишиг хэрэг хэрэглэх

Эх газрын эрх зүйн тогтолцоотой улс орнуудын хувьд шүүхээс урьд өмнө нь нааштайгаар шийдвэрлэсэн жишиг хэргийг дараагийн шүүхэд хэрэглэх үндэслэл тааруу боловч, шүүхийн

⁴³ Интеррайтс<www.interights.org>.

⁴⁴ Эмнести Интернэшнл<www.amnesty.org>.

⁴⁵ Байгаль орчны хуульчдын холбоо <www.e-law.org>.

⁴⁶ Нийтийн эрх ашгийн хуулийн Дэлхий нийтийн Сүлжээ<www.pilnet.org>.

аргаар шийдвэр нь үлгэр дуурайлал байдлаар хэрэглэгдэж болохыг үгүйсгэхгүй. Ялангуяа өмнө нь шийдвэрлэгдэж байгаагүй нийтийн эрх ашгийн өмгөөллийн хэргүүд дээр шүүхээс сайн практик тогтоолгож чадвал, дараа дараагийн адил төстэй хэргүүдэд ихээхэн хувь нэмэртэй юм. Манай улсад байгаль орчны хохирлыг гэм буруутай этгээдээс гаргуулах, эсхүл нөхөн сэргээлт хийхийг даалгах тухай нийтийн эрх ашгийн өмгөөллийн хэргийг иргэний журмаар, Улаанбаатар хотын шүүхүүд (Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн шүүхүүд зэрэг) амжилттай шийдвэрлэсэн практик нэлээдгүй байна.

10. Нэг асуудлаар хэд хэдэн байгууллагад хандах

Зарим хэрэг дээр асуудлын ээдрээ төвөгтэй байдлаас шалтгаалан нэг үндсэн нэхэмжлэлээс гадна хэд хэдэн салаа хэргийг нэгэн зэрэг үүсгэн ажиллах нь тохиромжтой байдаг. Уул уурхайн хууль тогтоомж зөрчсөн зөрчлөөс үүдсэн, байгаль орчныг хохироосон хэрэгт хандаж болох олон арга замыг хэрхэн ашигласан жишээг доор дурдав.

Жишээ: Уул уурхайн олборлолтын асуудлаар цогц ажиллагаа үүсгэсэн нь

Хүний эрх хөгжил төвөөс 2008 онд хийсэн нэгэн өмгөөллийн хэргээс харвал, уул уурхайн компанид Ус ашиглуулах тухай захирамжийг холбогдох хууль тогтоомж зөрчин олгосон гэж үзэж сумын Засаг даргын шийдвэрийг хүчингүй болгуулахаар дээд шатных нь Засаг даргад хандсан. Мөн голын гольдролыг өөрчлөхдөө усны хууль тогтоомж зөрчсөн, голыг бохирдуулсан уг компанийн үйлдэлд арга хэмжээ авахгүй байгаа Засаг даргын эс үйлдэлд нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6–д заасны дагуу өөрт нь эхэлж хандсан, түүнчлэн уг төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хууль зөрчиж баталсан гэж үзэж Байгаль орчны яамны (хуучин нэрээр) холбогдох газрын даргын шийдвэрийг хүчингүй болгуулахаар Нийслэлийн захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гарган, олон чиглэлээр ажилласан нь үр дүнгээ өгсөн байдаг.

11. Олон улсын арга, журмыг ашиглах

Өмгөөлөгчид өмгөөллийн төлөвлөгөө, тактикаа гаргахдаа хүний эрхийг хамгаалах олон улсын болон бүс нутгийн тохирох арга, журмыг ашиглах боломжийг анхаарах нь зүйтэй. Гэхдээ олон улсын байгууллагад хандахаасаа өмнө дотоодын хүний эрхийн боломжит арга, журмыг бүгдийг гүйцээсэн байх шаардлага

тавигддаг.⁴⁷ Хүний эрхийн олон улсын арга, журмын талаарх мэдээллийг гарын авлагын 2.3 дахь хэсгээс дэлгэрүүлж харна уу.

12. Анхаарвал зохих бусад асуудал

Өмгөөллийн хэргийг шүүхийн өмнөх шатанд шийдвэрлүүлэх нь цаг хугацаа, хөрөнгө мөнгө хэмнэх ихээхэн ач холбогдолтой. Иймд өмгөөллийн зорилго, үр нөлөөг бууруулахгүй бол стратегийн өмгөөллийн хэрэгт энэхүү тактикийг хэрэглэж болох юм.

Жишээ: Шүүхээс өмнөх шатанд өмгөөллийн хэргээ амжилттай шийдвэрлүүлсэн туршлага⁴⁸

Зориг сангаас 2010 онд хэрэгжүүлсэн шилжин суурьшигчдын эрхийг хамгаалах стратегийн өмгөөллийн хэргүүдийн зарим нь шүүхээс өмнөх шатанд амжилттайгаар шийдвэрлэгдсэн байдаг. Уг өмгөөллийн зорилго нь захиргааны шатанд нэлээдгүй гараад байсан шилжин суурьшигчдын эрхийн зөрчлийг шуурхай шийдвэрлэх практик тогтоох, захиргааны байгууллагад тогтсон хүнд суртал, буруу жишиг, хандлагыг өөрчлөх, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгоход чиглэгдэж байсан. Нөгөө талаас нэхэмжлэгч (орон нутгаас шилжин ирээд иргэний үнэмлэхээ авч чадахгүйгээс төрийн үйлчилгээг хүртэх эрх нь зөрчигдсөн иргэд)—д аль болох богино хугацаанд бодит үр нөлөө үзүүлэх шаардлагын улмаас шүүхээс өмнөх шатанд хэргийг шийдвэрлүүлсэн байдаг.

Өмгөөллийн явцад шүүхийн шийдвэр нь эсрэг талд гарч болзошгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд, өмнө дурдсан нөлөөлөл—кампанит ажил нэмэр болж болохыг үгүйсгэхгүй. Нөлөөллийг олон улсын түвшинд хийж болохоос гадна шүүхэд мониторинг хийх, шүүх эрх мэдлийн салбарт шинэчлэл шаардлагатайг төр засгийн сонорт хүргэх зэрэг ажлыг санаачлан хэрэгжүүлж болно.

Амжилттай шийдвэрлүүлсэн шүүхийн шийдвэрийг олон нийтэд сурталчлах, хэрэгжилтийг нь хангах, хэрэгжилтэд нь мониторинг хийх нь стратегийн өмгөөллийн ач холбогдлыг олон нийтэд таниулах, үр нөлөөг нь бодитой болгох, бусад хуульчийг стратегийн өмгөөллийн үйл ажиллагаанд татан оролцуулахад тустай. Учир нь стратегийн өмгөөллөөр ялалт байгуулсан ч, шийдвэрийн хэрэгжилт нь хангалтгүй бол стратегийн өмгөөллийн үр нөлөө нь бодитой мэдрэгдэхгүй.

⁴⁷ Нээлтэй Нийгэм Форум, зүүлт 6, 72 дах тал.

⁴⁸ Зориг сан, зүүлт 41, 21–26 дах тал.

Жишээ 1: Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн шатанд нөлөөллийн ажил мөн шаардлагатай болох нь

2010–2011 онд Үндэсний “Соёмбо” хөдөлгөөнөөс нийтийн эдэлбэрийн талбайд хууль зөрчиж газар эзэмшүүлсэн нийслэлийн Засаг даргын нэлээд олон тооны захирамжийг хүчингүй болгуулж, уг газар дээр барьсан барилгыг нураах шийдвэр гаргуулж чадсан. Гэсэн хэдий ч шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш нэлээдгүй хугацаа өнгөрсөн байхад шийдвэр хэрэгжээгүй хэвээр байгаа нь уг стратегийн өмгөөлөлд нөлөөллийн ажлыг үргэлжлүүлэх зайлшгүй шаардлагатайг харуулж байна.⁴⁹

Жишээ 2: Монголын байгаль орчны хуульчдын холбооны нэхэмжлэлтэй, М компанид холбогдох “Байгаль орчны нөхөн сэргээлт хийхийг даалгах тухай” нэхэмжлэлтэй хэрэг 2010 онд Баянзүрх дүүргийн шүүхээр амжилттай шийдвэрлэгдсэн ч шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал болох 10 сая гаруй төгрөгийг сумаас төлж чадахгүйгээс шүүхийн шийдвэр мөн л хэрэгжихгүй байна.⁵⁰ Энэ нь шүүхээр хэргээ амжилттай шийдвэрлүүлсэн ч нөлөөллийн ажлаа үргэлжлүүлэх шаардлагатайг дээрх хэргийн адил нотлон харуулж байна.

2.2.2 Стратегийн өмгөөлөл хийхэд тулгарч болох бэрхшээл

Стратегийн өмгөөлөл нь хууль, шүүх, нийгэмд тогтсон зохисгүй хандлагыг өөрчлөх, сайн практик тогтоох зорилгоор шүүхээр урьд өмнө шийдвэрлэгдэж байгаагүй асуудлаар голдуу хийгддэг тул хууль хэрэглэхтэй холбоотой болон процессын шинжтэй бусад бэрхшээл нэлээдгүй учирдаг. Тэдгээрийг ач холбогдлоор нь эрэмбэлэн дурдвал:

✓ **Нэхэмжлэх эрхийн хязгаарлагдмал байдал**

Стратегийн өмгөөллийн зарим хэрэг дээр, ялангуяа нийтийн эрх ашгийн өмгөөллийн хэрэгт нэхэмжлэгчийг сонгох асуудал нэлээдгүй бэрхшээлтэй тулгардаг талаар өмнө дурдсан. Стратегийн өмгөөллийн арвин туршлагатай Австрали, Энэтхэг, Непал зэрэг улсад нэхэмжлэгчийн өөрийнх нь эрх зөрчигдсөн эсэхээс үл хамааран нийтийн эрх ашгийн зарим асуудлаар өөрийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэх эрх нээлттэй олгогдсон байдаг. Манай улсын хувьд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгчээр оролцох эрх нь зөвхөн тухайн

⁴⁹ Үндэсний “Соёмбо” хөдөлгөөн, “Төрийн нийтийн зориулалттай өмчийн тухай хууль батлахыг шаардав” (2011 оны 8–р сар) <<http://www.news.mn/content/76122.shtml>>.

⁵⁰ Байгаль орчны хуульчдын холбоо, “Стратегийн өмгөөллийн үйл ажиллагааны тайлан 2012”, УБ, 2013 он, 9 дэх тал.

этгээдийн өөрийнх нь эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн байх, эсхүл төлөөллөөр оролцсон тохиолдолд нээгддэг.⁵¹ Нийтийн эрх ашгийн өмгөөллийн хэргийн зарим нэхэмжлэгч нэхэмжлэлээ татаж авснаар хэрэг хэрэгсэхгүй болох бэрхшээл байдгийг өмнө дурдсан хэргийн жишээнээс тодорхой харж болно. Дээр өгүүлснээр төрийн зарим байгууллага, албан тушаалтан нийтийн эрх ашгийн тодорхой асуудлаар нэхэмжлэл гаргах бүрэн эрхтэй ч, энэхүү хуулийн заалт нь тэр бүр хангалттай хэрэгжихгүй байна.

Дээрх бэрхшээл нь байгаль орчин, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх, захиргааны хууль зөрчсөн шийдвэр, үйл ажиллагаатай холбоотой нийтийн эрх ашгийн хэргүүдэд голчлон тохиолддог. Нэхэмжлэх эрхтэй холбоотой энэхүү бэрхшээлийг зарим салбарын хэмжээнд шийдвэрлэх зорилгоор Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 болон 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтын дагуу иргэн, байгаль орчны дүрмийн зорилго бүхий олон нийтийн байгууллагад байгаль орчны хохирол арилгуулахаар шүүхэд хандах эрхийг 2010 онд олгосон. Гэхдээ энэ нь хязгаарлагдмал хүрээнд буюу зөвхөн байгаль орчны хохирол нэхэмжлэх хэрэгт л хамаарахаас бус, байгаль орчны бусад асуудал, тулгамдаад буй өөр төрлийн хэргийг шийдвэрлэхэд хангалттай арга хэрэгсэл болж чадахгүй байгаа юм.

Нийтийн эрх ашгийг шүүхэд нэхэмжлэх нээлттэй эрхийн хувьд хуулийн зарим гарц боломж байгаа болохыг иргэн С.Э–гийн нэхэмжлэлтэй, Баянзүрх дүүргийн Засаг даргын 2007 оны 130 дугаар захирамжийн “Т” ХХК–д холбогдох хэсгийг хүчингүй болгуулах тухай хэргийн жишээнээс харж болно.⁵² Асуудлын гол учир нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1–д заасны дагуу Захиргааны хэргийн шүүх нь “иргэн, хуулийн этгээдээс захиргааны актыг хууль бус гэж үзэж, зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар гаргасан гомдол, нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд энд дурдагдаж буй “эрх”, “хууль ёсны ашиг сонирхол”–ын асуудлыг ялгамжтай авч үзэх талаар шүүгч Ц.Цогт дурдсан

⁵¹ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Зүүлт 34, Зүйл 26 (26.2)

⁵² Ц.Цогт, “Байгаль орчныг хамгаалах асуудалд Захиргааны хэргийн шүүхийн гүйцэтгэх үүрэг, оролцоо” (2013 оны 5–р сар) <<http://tsogt.blogmn.net/98378/baigali-orchniig-hamgaalah-asuudald--zahirgaanii-hergiin-shuuhiiin-guitsetgeh-uureg,-oroltsoo.html>>

байдаг. Тиймээс шүүгчийн зүгээс эл хэргийн нэхэмжлэгчийн нэхэмжлэх эрхийг үгүйсгээгүй байна.

✓ **Шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамж, өмгөөллийн зардал**

Стратегийн өмгөөллийн цогц үйл ажиллагаанд, ялангуяа, өөр орон нутагт ажиллах, хэргийн оролцогчдоо сургах, чадавхжуулах, нөлөөллийн зэрэг үйл ажиллагаанд нэлээдгүй зардал шаардагддаг. Шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамж нь хамгийн эрсдэлтэй, анхаарууштай асуудал юм. Манай улсын хувьд, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиудад стратегийн өмгөөллийн хэргийн нэхэмжлэгчийг улсын тэмдэгтийн хураамж, шүүхийн зардлаас онцгойлон чөлөөлсөн, хөнгөлсөн зохицуулалт байдаггүй нь стратегийн өмгөөллийн хэргийг шүүхэд авчрах явдлыг бууруулах нэгэн саад тотгор байж мэдэхээр юм. Харин стратегийн өмгөөллийн арвин туршлагатай улс орнуудын холбогдох актаар тухайлбал, Австрали Улсын Квийнсланд мужийн Парламентаас 1991 онд баталсан Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай Актын 49 дүгээр зүйлийн дагуу "... тухайн асуудал нь нийтийн эрх ашигтай холбоотой бол ... шүүхийн шийдвэр аль талд гарснаас үл хамааран талууд өөр өөрсдийн зардлыг хариуцна" гэх зэргээр нийтийн эрх ашгийн өмгөөллийн хэргийг онцгойлон авч үзсэн байдаг.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 55, 58 дугаар зүйлд "зохигч нь төлбөрийн чадваргүй, эсхүл хуульд заасан бусад үндэслэл байвал шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх, зохигчийн эд хөрөнгийн болон бусад байдлыг харгалзан шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг багасгах буюу хугацааг хойшлуулах, эсхүл хэсэгчлэн төлүүлж болно" гэж заасан. Гэвч "хуульд заасан бусад үндэслэл", "бусад байдал" гэдгийг хэрхэн ойлгох нь тодорхой бус бөгөөд энэ талаар сайн жишиг тогтоосон стратегийн өмгөөллийн хэрэг одоогоор Монгол Улсад байхгүй байна.

Эд хөрөнгийн бус, үнэлж болохгүй нэхэмжлэлтэй стратегийн өмгөөллийн хэргүүдэд улсын тэмдэгтийн хураамж, шүүхийн зардал нь харьцангуй бага байдаг ч, үнэлж болохоор ялангуяа, байгаль орчны хохирол нэхэмжилсэн хэрэгт улсын тэмдэгтийн хураамж нь нэлээд их хэмжээтэй байдаг. Ийм тохиолдолд

улсын тэмдэгтийн хураамж төлөхөөс чөлөөлөгдөхийн тулд төрийн байгууллагаас итгэмжлэл аван тэдний нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргадаг туршлага байна.⁵³

Стратегийн өмгөөллийг тодорхой санхүүжүүлэгчгүйгээр хийхэд хэцүү бөгөөд манай улсын хувьд стратегийн өмгөөллийн төслийг санхүүжүүлдэг зарим төрийн бус байгууллага бий. Тухайлбал, Нээлттэй Нийгэм Форумыг нэрлэж болно. Түүнчлэн өмгөөлөгчид зардал бага шаардахуйц стратегийн өмгөөллийг өөрсдөө санхүүжүүлэн, эсхүл Монголын хуульчдын холбооны дэргэдэх Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны хороогоор дамжуулан Про боно хэлбэрээр хийж болохыг үгүйсгэхгүй. Мөн стратегийн өмгөөллийн үйлчилгээ, хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээндээ “Өмгөөллийн үр дүнд хариуцагчаас нөхөн төлбөрийг бодитойгоор гаргуулсан тохиолдолд тухайн өмгөөлөлд зарцуулсан зардлыг стратегийн өмгөөллийн үйлчилгээ үзүүлсэн талд өгөх, ингэхдээ уг хөрөнгийг дараагийн стратегийн өмгөөллийн санхүүжилтэд зарцуулах” талаарх заалт тусгах замаар өмгөөллийн санхүүжилт олж болно. АНУ–ын Форд сан⁵⁴, Нийтийн эрх ашгийн хуулийн Дэлхий нийтийн сүлжээ зэрэг энэ чиглэлийн төслийг идэвхтэй дэмждэг байгууллагууд олон улсын хэмжээнд нэлээдгүй бий. Мөн нийтэд тустай үйл ажиллагааг дэмжин салбарын шинжээч, мэргэжилтнүүдээр хангах, тэднийг үнэ хөлсгүйгээр ажиллуулах зэрэг тусгай мэргэжлийн туслалцаа үзүүлдэг олон улсын хэмжээний байгууллагууд ч байдаг.⁵⁵ Цаашид дэлхийн бусад олон орон тухайлбал, Шинэ Зеланд, Австралийн Шинэ Өмнөд Уэльс мужийн адилаар нийтийн эрх ашгийн өмгөөллийн зардлыг тусгай сан байгуулан төрөөс санхүүжүүлэх зохицуулалтыг бий болгох нь зүйтэй юм.

✓ Олон улсын гэрээг хэрэглэх

Өмнө дурдсанчлан, стратегийн өмгөөллийн хэргийн шаардлага, үндэслэлдээ Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ конвенцийг бүтээлчээр тайлбарлан хэрэглэх нь өмгөөллийн

⁵³ Байгаль хамгаалах иргэний хөдөлгөөний эвслийн нэхэмжлэлтэй, Б компанид холбогдох, байгаль орчны хохирол нэхэмжлэх тухай хэргийг харна уу. Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан <<http://www.shuukh.mn/irgenanhan/33602/view>>.

⁵⁴ АНУ–ын Форд сан <www.fordfoundation.org>

⁵⁵ Байгаль орчны хуульчдын холбоо <www.e-law.org>.

зорилгодоо хүрэх нэгэн үр дүнтэй тактик болдог. Гэхдээ олон улсын гэрээг дотоодын шүүхэд хэрэглэхэд процессын шинжтэй бэрхшээл тулгардаг. Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3–т заасны дагуу “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчлэх” ба олон улсын гэрээний заалт дотоодын хууль тогтоомжтой зөрчилдвөл олон улсын гэрээ давамгайлах хүчин чадалтай. Хэдий тийм ч Монгол Улсын олон улсын гэрээг шүүхээс хэрэглэх нөхцөл нь Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3–т заасны дагуу “хүчин төгөлдөр болсон, албан ёсоор нийтлэгдсэн” байх явдал юм.⁵⁶ НҮБ, түүний төрөлжсөн байгууллагаас баталсан олон улсын гол гэрээ конвенцууд дээрх шаардлагыг хангасан ч, стратегийн өмгөөлөлд хэрэглэгдэж болох, тусгай асуудлыг зохицуулсан салбарын гэрээнүүд монгол хэлээр орчуулагдан албан ёсоор нийтлэгдээгүй байх нь түгээмэл байна.

✓ **Олон нийт, төрийн байгууллага, албан тушаалтнуудын стратегийн өмгөөллийн талаарх ойлголт, хандлага**

Монгол Улсад хийгдсэн стратегийн өмгөөллийн анхны хэргээс хойш арав гаруй жил өнгөрсөн ч энэ төрлийн өмгөөллийн зорилго, ач холбогдлын талаар буруу ойлголт, хандлага олон нийт, төрийн албан тушаалтнууд, ялангуяа, хуулийн байгууллагынхны дунд байсаар байна. Стратегийн өмгөөллийг улс төрийн зорилгоор хийж буй зарим үйл ажиллагаатай андуурах, стратегийн өмгөөлөгчдийг үл ойшоох, нууцад үл хамаарах мэдээллийг нууцлах, бусад байдлаар хүнд суртал гаргах зэргээр өмгөөллийн явцад нэлээдгүй бэрхшээл учирдаг нь нууц биш. Энэ бэрхшээлийг даван туулахад стратегийн өмгөөллийн ач холбогдлыг тайлбарлан таниулах мэдээлэл, сургалт, сурталчилгааг зорилтот бүлэг, олон нийтэд хандан хийх нь чухал юм.

⁵⁶ Улсын дээд шүүх, 2008 оны 09 дүгээр тогтоол, “Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтгээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай”.

✓ Бусад

Шинэ тутам асуудлаар хийгдэх стратегийн өмгөөллийн явцад хууль тогтоомж боловсронгуй биш байх нь нэлээдгүй тохиолддог. Тухайлбал, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн сэтгэл санааны хохирол, байгаль орчны хохирлыг үнэлэх аргачлал Монгол Улсад байхгүй байсан зэрэг явдлыг нэрлэж болно. Энэ мэт хууль тогтоомжийн боловсронгуй бус байдал нь, нэг талаас стратегийн өмгөөллийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах саад тотгор мэт харагдаж байгаа ч, нөгөө талаас энэ нь стратегийн өмгөөллийн зорилго, үр нөлөө байж болно.

Стратегийн өмгөөлөлд олон талууд тухайлбал, хуульчид, нэхэмжлэгчдээс гадна салбарын мэргэжилтнүүд, төрийн бус байгууллагын төлөөлөл оролцдог нь зохион байгуулалтын хувьд хугацаа их шаарддаг төдийгүй олон янзын үзэл бодолтой хүмүүсийг нэгтгэн нэг зорилгын дор зангидахад түвэгтэй байж болно. Энэ бүхнийг стратегийн өмгөөлөгчид анхааралдаа авч эхнээс нь нэгдсэн удирдлагаар ханган ойлголцож ажиллах нь чухал юм.

2.3 СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛЛИЙГ ҮНДЭСНИЙ БОЛОН НҮБ-ЫН ТҮВШИНД ХИЙХ НЬ

2.3.1 Стратегийн өмгөөллийг үндэсний түвшинд хийх нь

Стратегийн өмгөөллийг аль түвшинд хийх, ямар журмаар асуудлаа шийдвэрлүүлэх талаар нэгдсэн удирдамж байхгүй. Тухайн өмгөөллөөр тавьсан зорилго, хэргийн онцлог, хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн зохицуулалт, төлөвлөсөн зардал, төсөв, хугацаа зэргийг харгалзан өмгөөллийн алхмаа тодорхойлдог. Стратегийн өмгөөлөгчдийн ашиглаж болох дотоодын эрх зүйн арга, журмыг доор тайлбарлав.

✓ Шүүх

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 болон 4.1.3–т заасны дагуу шүүх нь “хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох, хууль дээдлэх, шударга ёс, ардчилсан ёсыг бэхжүүлэх” эрхэм зорилготой ажиллах бөгөөд үүнийг стратегийн өмгөөллийн онцлог, зорилготой харьцуулан үзвэл шүүхийн механизмыг эн тэргүүнд ашиглах нь хамгийн оновчтой шийдэл болно.

Практикаас харахад, Монгол Улсад өнөөг хүртэл хийгдсэн стратегийн өмгөөллийн хэргийн нэлээдгүй хувь нь захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн байдаг ба энэ нь захиргааны хууль бус үйлдлээс иргэн, хуулийн этгээдийг хамгаалах үндсэн зорилготой нь холбоотой гэж үзэж болно.⁵⁷ Захиргааны хэргийн шүүхээр стратегийн өмгөөллийн хэргийг шийдвэрлүүлэхэд анхаарах зүйл нь “Нэхэмжлэх эрх”–ийн асуудал байдаг ч өмнө дурдсанаар “Нэхэмжлэх эрх”–ийг нээлттэй болгох зарим оролдлогыг хуульчид хийж болох юм. Тухайлбал, нэхэмжлэх эрхийг зохицуулсан хуулийн заалтыг бүтээлчээр хэрэглэн “эрх” болон “хууль ёсны ашиг сонирхол”–ыг өөрт ашигтайгаар тайлбарлан нотолж болно. Энэ талаарх дэлгэрэнгүйг гарын авлагын “Нэхэмжлэх эрхийн хязгаарлагдмал байдал” хэсгээс харна уу.

Бусад дагнасан шүүхээр иргэн, эрүүгийн журмаар стратегийн өмгөөллийн хэргийг шийдвэрлүүлэх практик ч мөн манай улсад байна. Бусад дагнасан шүүхээр хамгийн их шийдвэрлэгдсэн

⁵⁷ Д. Ганзориг, “Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх”, Хүний эрх сэтгүүл (ХЭҮК) 2005 он, дугаар 4, 25 дах тал.

стратегийн өмгөөллийн хэргүүд нь төрийн байгууллага, албан тушаалтанд тодорхой үйлдэл хийхийг даалгах, байгаль орчны хохирол нэхэмжлэх, байгаль орчны эсрэг гэмт хэрэг, хүн худалдаалах гэмт хэргийн асуудлаар байдаг байна. Ялангуяа стратегийн өмгөөллийн тодорхой хэргүүдийн хувьд Улсын дээд шүүхийн шийдвэр онцгой ач холбогдолтой. Учир нь Улсын дээд шүүхийн шийдвэр нь анхан болон давж заалдах шатны шүүхийн болон бусад хууль хэрэглэж шийдвэр гаргадаг бүхий л байгууллага, албан тушаалтнуудын хувьд эрх зүйн эх сурвалж болох боломжтой шийдэл, үндэслэл болдогт оршино.

✓ **Үндсэн хуулийн цэц**

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1—д заасны дагуу Үндсэн хуулийн цэц нь хууль, хуульчилсан акт, төрийн зарим өндөр албан тушаалтны үйл ажиллагаа болон тэднийг сонгох, огцруулах, эгүүлэн татахтай холбоотой асуудал нь Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу УИХ, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэж, дүгнэлт, шийдвэр гаргах бүрэн эрхтэй. Дээр дурдсан шийдвэр, үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэж үзвэл өмгөөлөгчид нь стратегийн өмгөөллийнхөө нэгэн тактик болгож, иргэний хувиар Үндсэн хуулийн цэцэд хандан зөрчилтэй гэж үзсэн хууль, актыг хүчингүй болгуулах буюу дүгнэлт гаргуулж болно. Ингэснээрээ хуулийг боловсронгуй болгох стратегийн өмгөөллийн зорилгодоо хүрч болох юм.

✓ **Хүний эрхийн Үндэсний Комисс**

Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1—д заасны дагуу ХЭҮК нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг сахин хамгаалах, хөхиүлэн дэмжих байгууллага юм. Мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтын дагуу ХЭҮК нь Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан эрх, эрх чөлөөг нь аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн зөрчсөн гэж үзэж, Монгол Улсын иргэн дангаар буюу хамтарч гаргасан гомдлыг хүлээн авч шалгах бүрэн эрхтэй. Түүнчлэн ХЭҮК нь өөрийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах болон бусад шаардлагатай арга хэмжээ авдаг ба ХЭҮК—ын гаргасан нэхэмжлэл нь улсын тэмдэгтийн хураамжаас

чөлөөлөгддөг. Энэхүү бүрэн эрхийнхээ хүрээнд ХЭҮК нь 2001–2012 оны хооронд нийт 15 төлөөлөн нэхэмжлэл гарган шийдвэрлүүлснээс хоёр нь стратегийн өмгөөллийн хэрэг байсан байна.⁵⁸ Түүнчлэн ХЭҮК нь жил бүр хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын талаар УИХ–д тайлагнадаг.

Энэ бүхнээс дүгнэхэд стратегийн өмгөөллийн чиглэлээр төрийн бус байгууллагууд, өмгөөлөгчдөд ХЭҮК–той хамтрах өргөн боломж харагдаж байна. Тухайлбал, хүний эрх, эрх чөлөөний зөрчлийн асуудлаар ХЭҮК–т гомдол гаргаснаар асуудлыг шалгуулан төр засгийн сонорт хүргэх, хүний эрх зөрчсөн албан тушаалтанд арга хэмжээ авахуулах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсэн нөхцөлийг таслан зогсоолгохоор зөвлөмж, шаардлага хүргүүлэх, УИХ–д илгээдэг тайланд хүний эрхийн тодорхой асуудлыг тусгуулах цаашилбал, шүүхэд нэхэмжлэл гаргахад ХЭҮК–той хамтрах зэрэг байж болно.

✓ Бусад

Стратегийн өмгөөллийн хэргийн онцлог, тавьсан зорилгоос шалтгаалан, түүнчлэн гарах үр нөлөөг хурдан шуурхай, бодитой байлгах үүднээс асуудлыг заавал шүүхэд хандахгүйгээр шүүхийн өмнөх шатанд буюу захиргааны журмаар шийдвэрлүүлэх, эсхүл хариуцагч хүлээн зөвшөөрсөн тохиолдолд эвлэрүүлэн зуучлах аргыг ашиглахыг үгүйсгэхгүй. Баянхонгор аймгийн Галуут суманд байгаль орчны нөхөн сэргээлтгүй орхигдсон газрын асуудлаар Хүний эрх хөгжил төвөөс 2010 онд Чингэлтэй дүүргийн шүүхэд үүсгүүлсэн иргэний хэрэгт эрх ашиг нь хөндөгдсөн малчдын хүсэлт, хариуцагч компанийн зүгээс гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн байдал, хэрэг сунжрах тохиолдолд малчдад учрах үр дагавар зэргийг харгалзан эвлэрүүлэн зуучлалын хүрээнд асуудлыг шийдвэрлэсэн байдаг.

2.3.2 Стратегийн өмгөөлөлд НҮБ–ын арга, журмыг ашиглах нь


Стратегийн өмгөөллийн арвин туршлагатай улс орнуудын жишээнээс харвал, дотоодын эрх зүйн механизмаас гадна олон улсын, бүсийн түвшинд хүртэл өмгөөллийн тактикаа

⁵⁸ П.Оюунчимэг, “Хүний эрхийн үндэсний байгууллагаас шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргаж байгаа өнөөгийн нөхцөл болон гарч буй хүндрэлүүд”, “Нийтийн эрх ашгийг шүүхээр нэхэмжлэн хамгаалах нь” Олон улсын хуралд тавигдсан илтгэл, УБ, Их тэнгэр, 2012 он, 2 дах тал.

боловсруулан ажилладаг. Өмгөөллийн хэрэгт олон улсын түвшинд хүртэл нөлөөлж болох олон янзын талбар байдгаас хамгийн түгээмэл хэрэглэгддэг, үр нөлөөтэй нь НҮБ-ын арга, журам юм.

НҮБ-ын дүрмийн 1 болон 3.1 дэх заалтын дагуу хүний эрхийг хамгаалах асуудал нь НҮБ-ын үндсэн гурван зорилгын нэг бөгөөд 1948 оноос өнөөг хүртэл нийт 80 гаруй хүний эрхийн олон улсын гэрээ, конвенц, тунхаглал батлагдсан, мөн тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагууд байгуулагдан ажиллаж байна.⁵⁹

НҮБ-ын хүний эрхийг хамгаалах тогтолцоог НҮБ-ын дүрмийн үндсэн дээр байгуулагдсан, хүний эрхийн гэрээнд үндэслэн байгуулагдсан гэж хоёр хуваадаг. Стратегийн өмгөөлөгчид нь энэхүү хоёр төрлийн механизмын чиг үүрэг, гарах шийдвэрийн үр нөлөөг харгалзан өөрсдийн өмгөөллийн хэрэгт тохирохоо сонгон хандах боломжтой.



⁵⁹ Б. Хишигсайхан, Д. Эрдэнэчимэг, "Хүний эрх, НҮБ, Сэтгүүлч" (Сэтгүүлчдэд зориулсан гарын авлага) УБ, 2010, 22 дах тал.

✓ НҮБ-ын дүрмийн механизм

1. Хүний эрхийн Зөвлөл

Хүний эрхийн Зөвлөл (ХЭЗ) нь 2006 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн шийдвэрээр байгуулагдсан ба хүний эрхийн ужиг болон ноцтой зөрчлүүдийг үүсгэж буй нөхцөл байдалд анхаарлаа хандуулах, энэ талаар зөвлөмж гаргах үндсэн зорилготой байгууллага юм. ХЭЗ-ийн эрх хэмжээнд багтах дор дурдсан механизмыг ашиглан хүний эрхийн зөрчлийн асуудлаар гомдол гаргах, нөлөөлөх боломжтой. Үүнд:

- Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг (UPR)

Энэ нь “НҮБ-ын гишүүн бүх улсын хүний эрхийн үүрэг амлалтынх нь биелэлт, хүний эрхийн төлөв байдлыг үнэн бодит мэдээлэлд үндэслэн дүгнэх хэлэлцүүлгийг 4 жил тутамд хийдэг” ХЭЗ-ийн тусгай, цоо шинэ механизм юм. Энэхүү дүгнэх хэлэлцүүлгийн үйл ажиллагаанд төрийн бус байгууллагууд нь хүний эрхийн асуудлаар тайлан мэдээлэл хүргүүлэх, уг асуудалд тодорхой бүлгүүдийн анхаарлыг хандуулах зорилго бүхий нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах, ХЭЗ-ийн ажлын хэсгийн хуралдаанд ажиглагчаар оролцох, нэгдсэн хуралдаанд тусгай статустай тохиолдолд оролцож, үг хэлэх боломжтой.

- ХЭЗ-д гомдол гаргах

ХЭЗ нь дэлхийн улс орнуудын аль ч цэгт гарсан, хүний эрхийн ноцтой болон ужиг зөрчлийн талаарх гомдлыг хүлээн авч шалгах эрхтэй. Гомдлыг тогтоосон журмын дагуу, тавигдах шаардлагыг ханган гаргах ба тэдгээрийн дундаас анхаарах асуудал нь “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь үр дүн муутай, эсхүл хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удааширснаас бусад тохиолдолд хүний эрхийг хамгаалах дотоодын механизмуудаар шийдвэрлэгдсэн байх” явдал юм. Гомдлыг хянан шийдвэрлэсний эцэст ХЭЗ-өөс заавал дагаж мөрдөх хууль зүйн хүчин чадал бүхий шийдвэр гарахгүй ч, энэ нь олон улсын хэмжээнд нөлөөлөх чухал хэрэгсэл гэдгийг анхаарах нь зүйтэй.

- ХЭЗ-ийн Тусгай хэрэгслүүд

Энэ нь тодорхой улс оронд үүссэн асуудлаар (country mandate), эсхүл тусгай сэдэвчилсэн асуудлаар (thematic mandate)

ХЭЗ—өөс томилогдон ажилладаг шинжээчид юм. Эдгээр шинжээчид нь хувь хүний гомдлыг шалгах, хариу өгөх, улс орнуудад албан айлчлал хийх болон хүний эрхийг хөхиүлэн дэмжих бусад чиг үүргийг хэрэгжүүлдэг ба энэхүү арга хэрэгслийг ашиглан гомдол илгээх, өөрийн улсад урьж ирүүлэн нөхцөл байдлыг бодитоор нь шалгуулан зөвлөмж гаргуулах боломжтой. Ялангуяа, тусгай асуудлаар мэргэшсэн шинжээчдийг⁶⁰ дотооддоо урьж ажиллуулах нь тухайн асуудлыг төр засгийн анхаарлын төвд авчрах, яаралтай арга хэмжээ авахуулах ач холбогдолтой юм. Монгол Улс нь эдгээр шинжээчдэд “Байнгын урилга” (Шинжээчдээс тухайн улсад ажиллахаар ирүүлсэн хүсэлтийг ямар ч тохиолдолд хүлээн авах нөхцөл) санал болгосон улс юм.

✓ НҮБ-ын Гэрээний механизм

НҮБ нь хүний эрхийн гэрээ, конвенцийн хэрэгжилтийг хянах чиг үүрэг бүхий “Гэрээний хороод”—ыг байгуулан ажиллуулдаг бөгөөд НҮБ-ын гишүүн улс бүр өөрсдийн нэгдэн орсон буюу соёрхон баталсан гэрээ, конвенцийг хэрэгжүүлэх, хэрхэн хэрэгжүүлж буй талаараа тогтсон хугацаанд тайлан илтгэл явуулах үүргийг хүлээдэг байна. Одоогийн байдлаар доор дурдсан, гэрээний хэрэгжилтийн асуудлаарх хороод ажиллаж байна:

1. Хүний эрхийн хороо (Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 1966, Пактын нэмэлт протокол 1, 2)
2. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо (Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт, 1966)
3. Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн хороо (Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Олон улсын Конвенц 1965)
4. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн хороо (ЭЯГБХУТК, 1979, Конвенцийн нэмэлт протокол)
5. Эрүүдэн шүүхийн эсрэг хороо (Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр харгис хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний

⁶⁰ Одоогийн байдлаар тусгай асуудлаар мэргэшсэн шинжээчид (Thematic mandate)³⁷ байна. Жаргсаалтыг <<http://www.ohchr.org/EN/HRBodies/SP/Pages/Themes.aspx>>харна уу.

- нэрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенц, 1984)
6. Хүүхдийн эрхийн хороо (Хүүхдийн эрхийн тухай Конвенц, 1989, Конвенцийн нэмэлт протокол 1, 2)
 7. Цагаач ажилчдын эрхийн хороо (Бүх цагаач ажилчид ба тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай Конвенц, 1990)
 8. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хороо (Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тухай Конвенц, 2008, Конвенцийн нэмэлт протокол)
 9. Хүнийг хүчээр сураггүй болгохын эсрэг Хороо (Хүнийг хүчээр сураггүй болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенц, 2006)

Гэрээний хороонд тухайн хүний эрхийн гэрээний зөрчлийн асуудлаар хувь хүн гомдлоо гаргаж болохоос гадна⁶¹ дээр дурдсанчлан гэрээнд нэгдэн орсон улсаас тодорхой хугацаа (ихэвчлэн 4 жил)—нд тогтмол илгээх гэрээний хэрэгжилтийн талаарх илтгэл тайлантай зэрэгцүүлэн төрийн бус байгууллагууд сүүдэр илтгэл бичиж оролцож болно.

НҮБ—ын дүрмийн болон гэрээний дээр дурдсан механизмын уялдаа холбоог хангах, зохион байгуулалт, арга зүйн туслалцаа үзүүлэх зорилготой Хүний эрхийн дээд комиссарын газар ажилладаг бөгөөд энэ нь улс орнуудын Засгийн газраас гадна иргэний нийгмийн байгууллагуудтай нягт хамтын ажиллагаатай.⁶²

Стратегийн өмгөөллийн арвин туршлагатай зарим улс орон стратегийн өмгөөллийн хэргээ НҮБ—ын түвшинд хүргэн амжилтад хүрсэн жишээг гарын авлагын 3—р бүлгээс харж болно. Монгол Улсын тухайд хүний эрхийн төрийн бус байгууллагуудын зүгээс хүний эрхийн зөрчлийн асуудлаар НҮБ—ын дүрмийн механизм болон гэрээний хороод руу хандаж байсан туршлага нэлээдгүй байдаг ч стратегийн өмгөөллийн хэргийн асуудлаар хандсан жишээ байхгүй байна.

⁶¹ Хувь хүний гомдлыг хүлээн авч шийдвэрлэх Хорооны эрх хэмжээг тухайн улс хүлээн зөвшөөрсөн байхыг шаардана.

⁶² Б.Хишигсайхан нар, зүүлт 59, 33 дахь тал.

Эндээс дүгнэхэд, стратегийн өмгөөллийн зорилгодоо хүрэхийн тулд өмгөөлөгчид нь энэ чиглэлээр туршлагатай хүний эрхийн төрийн бус байгууллагуудтай хамтрах нь илүү үр дүнтэй. Хэдийгээр НҮБ-ын дээрх механизмд хандсанаар заавал дагаж биелүүлэх, хууль зүйн хүчин чадалтай шийдвэр гаргуулж чадахгүй ч гэлээ, асуудлыг олон улсын хэмжээнд гарган НҮБ-ын байгууллага, шинжээчдээс дүгнэлт, зөвлөмж, шаардлага гаргуулж чадвал тэр нь стратегийн өмгөөллийн нэгэн том нөлөөлөл, ялалт болно.

БҮЛЭГ 3.

СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛЛИЙН ХЭРЭГ СУДЛАЛ

3.1 БУСАД УЛС ОРНЫ СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛЛИЙН ХЭРЭГ

3.1.1 Штукатуров: Шүүхэд хандах эрх

1. Нэхэмжлэгч:

- Штукатуров (Shtukaturov) 1982 онд төрсөн, ОХУ-ын иргэн, түүний өмгөөлөгч
- Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөх байгууллага (ОУХБИТБ)⁶³

2. Хариуцагч: ОХУ-ын Засгийн газар

3. Шийдвэрлэсэн шүүх, шүүхийн шийдвэрийн огноо:

- ОХУ-ын Санкт Петербург хотын Василеостровский дүүргийн шүүх (Дүүргийн шүүх), 2005 оны 12-р сарын 22⁶⁴
- Европын хүний эрхийн шүүх: Штукатуров ОХУ, Хэргийн дугаар 44009/05, 2008 оны 3-р сарын 27, Эцсийн шийдвэр 2008 оны 6-р сарын 27

⁶³ ОУХБИТБ нь АНУ-д төвтэй олон улсын хүний эрхийн байгууллага. Оюуны хомсдолтой иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр стратегийн өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэн явуулдаг.

⁶⁴ 2005 оны 11-р сарын 20-ны өдөр “2004 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн дүүргийн шүүхийн шийдвэр”-ийг (Иргэний эрх зүйн чадамжгүйд тооцох тухай) эсэргүүцэн дүүргийн шүүхэд давах өргөдөл гаргасан. Дүүргийн шүүх 2005 оны 12-р сарын 22-ны өдөр гомдол гаргагч нь иргэний эрх зүйн чадамжгүй гэж шүүхээр тогтоогдсон учир зөвхөн түүний хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрлөөр өргөдөл, гомдол, нэхэмжлэлийг шүүхэд гаргах эрхтэй гэж үзэн өргөдлийг буцаасан.

4. Нэхэмжлэлийн шаардлага

Энэ хэргийн нэхэмжлэлийн утга нь доорх асуудлыг хөндсөн байна:

- Иргэний эрх зүйн чадамжийг хязгаарласан шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох зорилгоор шүүхэд хандсан ч дүүргийн шүүх нь өргөдөл гаргагчийн хүсэлтийг хангах боломжгүй гэж үзсэн тул нөхөн төлбөр гаргуулах.
- Эрх зүйн чадамжгүй гэсэн шийдвэрийг хүчингүйд тооцуулж, иргэний эрх зүйн чадамжийг сэргээх.
- Гомдол гаргагч нь иргэний эрх, эрх чөлөө хязгаарлагдсан хүнд нөхцөлд амьдарч байсан, мөн эрх зүйн чадамжгүй гэх шийдвэр нь сул дорой мэдрэмжийг төрүүлдэг гэсэн үндэслэлээр сэтгэл санааны хохиролд 25,000 еврогийн нөхөн төлбөр гаргуулах.
- Гомдол гаргагчийг “Эмнэлэг дугаар 6”⁶⁵–д хэд хэдэн удаа удаан хугацаатайгаар албадан хэвтүүлсэн нь түүний эрх чөлөөг хууль бусаар удаан хугацаанд хязгаарласан гэж үзсэн.
- Гомдол гаргагч нь Европын хүний эрхийн шүүхийг өөрийн нөхцөл байдалтай төсөөтэй хэрэг болох, Унгарын “Гажси (Gajcsi)” дугаар 34503/03, Словакийн “Эйч Эф (H.F.)” дугаар 54797/00 шийдвэрийг харж удирдлага болгохыг зөвлөсөн.

5. Өмгөөллийн зорилго

Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй иргэд зарим тохиолдолд бие даан амьдрах чадваргүй учир эрх зүйн чадамжийг шүүхийн тогтоолоор хязгаарлаж, асран хамгаалагч тогтоодог. Тэд ойр дотны хүмүүсийн асран хамгаалалтад, эсхүл тусгайлсан эмнэлэгт хүнд, хөнгөнөөсөө хамааран тусгай эмчилгээ, сувилгаа, хяналтанд байдаг бөгөөд хүний эрхийн зөрчилд өртөх магадлал өндөр байдаг. Энэ утгаараа тэдгээр хүмүүст шүүхийн шийдвэрээр эрхийг нь хязгаарлаж болох хэдий ч, мөн шийдвэрийг нь хүчингүй болгох боломж байдаг гэдгээр жишиг тогтоох явдал байсан юм. Хэдийгээр энэ хэргээр үндэснийхээ шүүхэд хандсан ч иргэний эрх зүйн чадамжгүй

⁶⁵ “Эмнэлэг дугаар 6” нь Санкт Петербург хот дахь сэтгэцийн өвчтэй иргэдэд зориулсан тусгай эмнэлэг.

учир бүх шатны шүүх түүний нэхэмжлэлээр хэрэг үүсгэхээс татгалзсан юм.⁶⁶ Өөрөөр хэлбэл, түүний өмгөөлөгч авах, шударга шүүхээр шүүлгэх эрх нь зөрчигдсэн. Ийнхүү иргэний эрх зүйн чадамжгүйн улмаас дотоодын шүүх нь гомдлыг хүлээн авахаас татгалзсан тул түүнд зөвхөн бүсийн шүүхэд хандах гарц үлдсэн бөгөөд мэргэшсэн өмгөөлөгчийн туслалцаатайгаар Европын хүний эрхийн шүүхэд хандсан байна. Энэ хэрэг нь бүс нутгийн шүүхэд хандах жишгийг тогтоосон юм.⁶⁷

6. Хэргийн танилцуулга

Штукатуров 1982 онд төрсөн, ОХУ-ын иргэн, эрэгтэй. 2003 онд оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй гэсэн эмнэлгийн онош тавигдсан. Сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, зөв удирдаж чадахгүй гэсэн үндэслэлээр “Иргэний эрх зүйн чадамжгүйд тооцох тухай, түүнд асран хамгаалагч тогтоох тухай” дүүргийн шүүхийн шийдвэр 2004 оны 12-р сарын 28-ны өдөр гарсан. Дүүргийн шүүх асран хамгаалалт тогтоох асуудлыг өөрт нь ч мэдэгдэлгүй 10 минутын дотор шийдвэрлэжээ. Шүүхийн энэ шийдвэр нь түүнийг бие даан амьдрах, хувийн амьдралтай байх зэрэг бүхий л үйлдэлд хязгаарлалт хийсэн гэсэн үг юм. Тухайлбал, худалдаа наймаа хийх, хөдөлмөр эрхлэх, гэр бүлтэй болох, өмгөөлүүлэх, шүүхэд хандах эрх нь хязгаарлагдсан. Штукатуров Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөх байгууллага (ОУХБИТБ)-д хууль зүйн туслалцаа авах хүсэлт илгээсэн бөгөөд тухайн байгууллагын туслалцаатайгаар үндэсний болон олон улсын шүүхийг ашиглан нөлөөллийн үйл ажиллагаа хийсэн байна.

7. Хийгдсэн ажиллагаа

✓ Хэрэг үүсгүүлэх бэлтгэл ажлын хүрээнд

Штукатуров нь дүүргийн шүүхэд асран хамгаалагчийн асуудлыг хөндөхийн зэрэгцээ, өмгөөлөгч авах эрх нь зөрчигдөж байгаа талаар анхан шатны шүүхэд эрхээ сэргээлгэх оролдлогууд хийсэн хэдий ч амжилтад хүрээгүй тул түүнд хууль зүйн

⁶⁶ Штукатуров нь өмгөөлөгчийн хамт 2004 оны 12-р сарын 28-ны өдрийн дүүргийн шүүхийн шийдвэрийг эсэргүүцэж, шат шатны шүүхэд хандсан ч амжилтад хүрээгүй.

⁶⁷ ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхээс 2010 оны 2-р сарын 26-ны өдөр “Европын хүний эрхийн шүүхийн шийдвэр, Европын хүний эрхийн конвенц нь ОХУ-ын үндэсний хууль эрх зүйн тогтолцооны нэгэн хэсэг” хэмээн тунхагласан.

туслалцаа үзүүлсэн байгууллага нь Европын хүний эрхийн шүүхэд хандахыг зөвлөжээ. Тэд хамтдаа шүүхэд хандан, хэрэг үүсгүүлэх бэлтгэл ажлын хүрээнд доорх ажлыг хийсэн байна. Үүнд:

- Гомдол гаргагчийн шүүхэд хандах эрх нь зөрчигдсөн хэргээр дамжуулан ОХУ–д сэтгэцийн өвчтэй иргэдтэй холбоотой асран хамгаалалт тогтоох үйл ажиллагааг нарийвчлан судалж, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд судалгаа, мониторинг хийсэн.
- Энэ хэрэг дээр үндэслэн тус байгууллага нь иргэний эрх зүйн чадамжийн асуудлыг хөндсөн холбогдох хууль тогтоомж, шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг тусгасан сүүдэр илтгэлийг Хүний эрхийн хороонд илгээжээ.
- Европын хүний эрхийн шүүхээс ижил төстэй хэргүүдийг хэрхэн шийдвэрлэсэн талаар мэдээлэл цуглуулсан байна.
- Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөх байгууллага (ОУХБИТБ), түүний хамтрагч байгууллагууд ОХУ–ын Засгийн газрыг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенц (ХБХЭТОУК)–ийг соёрхон батлах ажлын хэсэг байгуулахад нөлөөлөх нөлөөллийн ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан явуулсан.

✓ Шүүхийн шатанд

- Штукатуров “Эмнэлэг дугаар 6”–аас түр гарсны дараа Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөх байгууллага (ОУХБИТБ)–ын өмгөөлөгчийн тусламжтайгаар Европын хүний эрхийн шүүхэд 2005 оны 12–р сарын 10–ны өдөр өргөдөл гаргасан.
- Европын хүний эрхийн шүүх нь гомдол хүлээн авсан өдрөө Штукатуровын хэргийн ажиллагаатай холбогдуулж хэрэгт ач холбогдол бүхий материалтай танилцах болон гомдол гаргагчтай өмгөөлөгчийг уулзах боломжоор хангах хүсэлтийг ОХУ–ын эрх бүхий албан тушаалтанд илгээсэн.
- Европын хүний эрхийн шүүхэд ОХУ–ыг төлөөлж байсан П.Лаптев дүүргийн Ерөнхий шүүгчид “түр зуурын арга

хэмжээ"⁶⁸ авах тухай хүсэлтийг 2006 оны 3-р сарын 30-ны өдөр илгээсэн. Үүний үр дүнд Штукатуровыг "Эмнэлэг дугаар 6"-аас гаргасан бөгөөд өмгөөлөгчтэй уулзах боломжтой болсон юм.

- 2008 оны 3-р сард Европын хүний эрхийн шүүхээс Штукатуровын өмгөөлүүлэх эрхийг сэргээх тухай ОХУ-ын Засгийн газарт даалгасан.
- 2008 оны 3 болон 6-р саруудад хэргийг Европын хүний эрхийн шүүх хэлэлцэж, шийдвэр гаргасан. Үүнд:
 - Сэтгэцийн өвчтэй гэсэн эмнэлгийн онош нь иргэний эрх зүйн чадамжийг бүхэлд нь хязгаарлах үндэслэл болохгүй бөгөөд энэ нь ОХУ-аас соёрхон баталж үүрэг хүлээсэн олон улсын гэрээ, конвенцийг зөрчиж байгаад санаа зовниж байгаагаа илэрхийлсэн.
 - Иргэний эрх зүйн чадамжтай холбоотой баримт бичгүүдээ дахин хянаж, дүн шинжилгээ хийхийг ОХУ-ын Засгийн газарт даалгасан.
 - ОХУ-ын Засгийн газарт эрүүл мэндийн салбарын хууль тогтоомжоо шинэчлэх, холбогдох олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орох талаар зөвлөмж өгсөн.

8. Шүүхийн шийдвэрийн хэрэгжилт

- Европын хүний эрхийн шүүхийн шийдвэр гарсны дараа орон нутгийн шүүхээс өргөдөл гаргагчийн иргэний эрх зүйн чадамжийг сэргээн тогтоосон.
- ОХУ-ын Үндсэн хууль, Иргэний хууль болон эрүүл мэндийн хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсэг байгуулагдсан.
- Асран хамгаалагч тогтоох шийдвэр гаргах журам, асран хамгаалагчийн эсрэг гомдол гаргах эрхийг хуульчилсан.

9. Өмгөөллийн үр дүн

- Европын хүний эрхийн шүүхийн шийдвэр нь ОХУ-ын

⁶⁸ Европын хүний эрхийн шүүхийн дүрмийн 39-р зүйлд зааснаар шүүх ажиллагаа эхэлсэн хэргийн аль нэг тал, эсхүл энэ асуудалд санаа зовниж буй этгээдийн хүсэлтээр "түр арга хэмжээ" авах тухай хүсэлтийг холбогдох газруудад хүргэдэг. Штукатуровын хэргийн хувьд "өмгөөлөгч өргөдөл гаргагчтай уулзах, холбогдох баримт бичигтэй танилцах ажиллагаанд саад учруулахгүй байх" түр арга хэмжээ авах хүсэлтийг илгээжээ.

эрүүл мэндийн салбарын хууль тогтоомжийг шинэчлэх эрх зүйн үндсийг бий болгосон.

- Стратегийн өмгөөллийн дүнд тухайн иргэний эрх зүйн чадамжийг сэргээхийн зэрэгцээ эрүүл мэндийн хууль тогтоомжид зохих нэмэлт, өөрчлөлт оруулах талаар зөвлөмж, дүгнэлтийг ОХУ–ын Засгийн газарт өгсөн.
- Энэ хэргээр дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгарч байгаа эрх зүйн орчны бэрхшээлийг хэрхэн даван туулж, холбогдох салбарт шинэчлэл, өөрчлөлт хийж болох суурийг тавьж өгсөн.
- ОХУ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцийг соёрхон баталсан тохиолдолд уг конвенцийн 12–р зүйлд иргэний эрх зүйн чадамжтай холбоотой хууль тогтоомжийг нийцүүлсэн нэмэлт, өөрчлөлт оруулна гэсэн хүлээлт бий.
- Энэ хэрэг дээр оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөөх үйл ажиллагаа явуулдаг хүний эрхийн байгууллага ажилласны дүнд Европын хүний эрхийн шүүхэд хандах боломжийг нээж өгсөн.
- Хэрэв Европын хүний эрхийн шүүхийн шийдвэрийг бүхэлд нь хэрэгжүүлэх юм бол ОХУ–д оюуны бэрхшээлтэй иргэдийн амьдралд эрс өөрчлөлт гарах бөгөөд хүний эрхийг хамгаалах үйлсэд томоохон ахиц дэвшил болох юм. Ингэснээр хууль тогтоомж, асран хамгаалалтын тогтолцоо, тусгай эмнэлэг болон хүмүүсийн хандлагад томоохон өөрчлөлтийг авчирна.

10. Эх сурвалж

- Оюуны бэрхшээлтэй иргэдийн төлөөх байгууллага, “ОХУ–ын Засгийн газрын эсрэг Штукатуровын нэхэмжлэлтэй хэргийн Европын хүний эрхийн шүүхийн шийдвэр” <www.mdac.info/en/content/shtukaturov-v-russia-judgment>
- Европын хүний эрхийн шүүх <[http://hudoc.echr.coe.int/sites/fra/pages/search.aspx?i=001-85611#{"itemid":\["001-85611"\]}](http://hudoc.echr.coe.int/sites/fra/pages/search.aspx?i=001-85611#{)>

3.1.2 Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, түүний нэмэлт протокол: Эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрх

1. **Нэхэмжлэгч:** эмэгтэй, эрэгтэй 20 хүний бүрэлдэхүүнтэй бүлэг (бүлэг нэхэмжлэгч)
2. **Хариуцагч:** Филиппин Улсын Засгийн газар, Манила хотын захиргаа
3. **Шийдвэрлэсэн шүүх, шүүхийн шийдвэрийн огноо:**
 - 2008 оны 5–р сар, Манила хотын давж заалдах шатны шүүх
 - 2008 оны 9–р сар, Улсын дээд шүүх
 - 2009 оны 9–р сар, Бүсийн шүүх
 - 2010 онд Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн хороо
4. **Нэхэмжлэлийн шаардлага**
 - *Үндэсний шүүхэд:* Манила хотын даргын 2000 оны 2 дугаар сард баталсан Гэр бүл төлөвлөлтийг дэмжих 003 дугаар захирамж Филиппин Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрхийг зөрчсөн тул уг захирамжийг хүчингүй болгуулах.
 - *Бүсийн шүүхэд:* Эмэгтэйчүүдийг жирэмслэлтээс хамгаалах арга хэрэгсэл, гэр бүл төлөвлөлтийн талаар мэдээлэлтэй байх эрх нь зөрчигдсөний улмаас тэдний амьд явах эрх ноцтой зөрчигдөж, эрүүл мэндэд нь хохирол учирсан тул нөхөн олговор гаргуулах тухай үндэсний шүүхэд даалгуулах хүсэлт.
 - *НҮБ:* Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн 1, 2, 3, 5, 10, 11, 12 болон 16–р зүйл, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактын 2, 3, 10, 12–р зүйл болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 2, 3, 17, 23, 26–р зүйл, түүнчлэн Хүний эрхийг хамгаалагчдын Тунхаглалын 14–р зүйлийг тус тус зөрчсөн гэж үзэж Филиппин Улсын иргэний нийгмийн байгууллагаас Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн хороонд тайлан илгээсэн юм.

Түүнчлэн олон улсын хяналт шалгалт хийдэг байгууллагын өмнө тэдгээр зөрчил байгааг хүлээн зөвшөөрүүлэх, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах талаар Филиппин Улсын Засгийн газарт үүрэг болгуулахыг зорьсон.

5. Өмгөөллийн зорилго

- Манила хотын 003 дугаар захирамж буюу эмэгтэйчүүдийг илт ялгаварлан гадуурхсан бодлогын баримт бичгийг шүүхийн тогтолцоог ашиглан хүчингүй болгох.
- Хэдийгээр үндэсний болон бүс нутгийн шүүхэд хандаж амжилтад хүрээгүй ч НҮБ-ын механизм болох Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн хороонд өргөдөл гомдол илгээж, үүгээр жишиг тогтоох.

6. Хэргийн танилцуулга

2000 онд Манила хотын дарга асан Жосэ нь Гэр бүл төлөвлөлтийг дэмжих буюу хариуцлагатай эцэг эхийн төлөөх бодлогын баримт бичиг 003 дугаар захирамжийг баталжээ. Энэ захирамжаар жам ёсны гэр бүл төлөвлөлтийг дэмжиж, харин зохиомол жирэмслэлт болон үр хөндөлтийг хориглосон. Захирамж нь 2000–2007 оны хооронд хүчин төгөлдөр үйлчилсэн бөгөөд энэ хугацаанд маш олон тооны эмэгтэйчүүд, ялангуяа орлого багатай эмэгтэйчүүд олон улсын хуулиар баталгаажсан гэр бүл төлөвлөлтийн үйлчилгээ хүртэх эрх нь ноцтой зөрчигдсэн. Захирамж хүчингүй болсон хэдий ч Манила хотын улсын эмнэлэг даган мөрдсөөр байсан юм. Энэхүү шийдвэр нь эмэгтэйчүүдийг хүсээгүй жирэмслэлт болсон тохиолдолд хууль бусаар үр хөндөлт хийлгэхэд хүргэж, улмаар эхийн эндэгдлийг ихэсгэх сөрөг үр дагавар дагуулсан. Мөн хувийн болон хөдөө орон нутгийн эмнэлгүүд гэр бүл төлөвлөлтийн орчин үеийн арга хэлбэрийн тухай мэдээллийг үйлчлүүлэгчиддээ өгөхөөс эмээж байв.

7. Хийгдсэн ажиллагаа

✓ Хэрэг үүсгүүлэх бэлтгэл ажлын хүрээнд

003 дугаар захирамжийг хүчингүй болгох, гэр бүл төлөвлөлтийн тухай мэдээлэл, үйлчилгээ хүртэх эрхийг баталгаажуулах зорилгоор эмэгтэйчүүдийн эрхийн төлөөх үндэсний болон олон улсын төрийн бус байгууллагууд маш олон төрлийн нөлөөллийн үйл ажиллагаа явуулсан. Үүнд:

- *Баримтжуулах ажиллагаа*: 003 дугаар захирамжийн үр нөлөө эмэгтэйчүүдэд хэрхэн туссан талаарх факт баримт цуглуулан, түүний үр дүнд “Хүсээгүй жирэмслэлт буюу 003 дугаар захирамжийн үр нөлөө” гэсэн судалгааны тайланг хэвлэн холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн.
- *Хохирогч олох ажиллагаа*: Үүнд ялангуяа жам ёсны жирэмслэлтийг дэмжсэн бодлого нь бага, дунд орлоготой эмэгтэйчүүдэд хүндээр тусч, хүсээгүй жирэмслэлтийн улмаас хууль бусаар үр хөндөлт хийлгэх, улмаар амь нас нь хохирох явдал ихэссэн, түүнчлэн эмэгтэйчүүдийг ядууралд оруулах нэг нөхцөл болж байв. Ийм нөхцөлд орсон маш олон эмэгтэйчүүд, мөн амь насаа алдсан эмэгтэйчүүдийн нөхөр, эцэг эхчүүд байсан ба тэднээс 20 хохирогчийг сонгон авч стратегийн өмгөөллийн үйл ажиллагааг эхлүүлэхээр болсон.

✓ **Шүүхийн шатанд**

- 2008 оны 1–р сард 20 хүний бүрэлдэхүүнтэй нэхэмжлэлийг Манила хотын давж заалдах шатны шүүхэд гаргасан. Уг нэхэмжлэлд орчин үеийн гэр бүл төлөвлөлтийн талаар мэдээлэлтэй байх иргэдийн эрх нь зөрчигдсөний улмаас тэдний эрүүл мэнд, амь насанд аюул учирч байгаа болохыг дурдаж, холбогдох тайлбарыг өгсөн боловч 2008 оны 5 сард нэхэмжлэлийн шаардлага үндэслэл муутай гэдгээр хэрэгсэхгүй болгосон.
- 2008 оны 9–р сард Манила хотын давж заалдах шатны шүүхээс гарсан шийдвэрийг эсэргүүцсэн 20 хүний бүрэлдэхүүнтэй бүлэг (гэхдээ 19 хүн гарын үсэг зурсан) нэхэмжлэлийг Улсын дээд шүүхэд гаргасан боловч шүүх хүлээж аваагүй. Учир нь нэг нэхэмжлэгч нь гарын үсэг зурахаас татгалзсан ба энэ үндэслэлээр шүүх хэрэг үүсгэхээс түдгэлзсэн юм. Өөрөөр хэлбэл, Улсын дээд шүүхэд гаргасан нэхэмжлэлд нэхэмжлэгчдийн гарын үсэг бүрэн биш тохиолдолд гомдол хүлээн авахаас татгалздаг жишиг дээр үндэслэн шүүх хэрэг үүсгэхээс татгалзсан.
- 2009 оны 9–р сард бүлэг нэхэмжлэгчид Бүсийн шүүхэд Филиппин Улсын шүүхийн тогтолцоог ашиглан шударга ёсыг тогтоолгох, нөхөн төлбөр гаргуулах зорилгоор дахин хүсэлт гаргасан. Хариуд нь Манила хотын захиргаа Бүсийн

шүүхэд бүлэг нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгуулах зорилгоор сөрөг нэхэмжлэл гаргасан. Бүсийн шүүх эмэгтэйчүүдийн жирэмслэлтийн асуудал шүүхийн харьяалан шийдэх хэрэгт хамаардаггүй гэсэн үндэслэлээр филиппин эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, нөхөн үржихүйн асуудлыг хэлэлцэхээс татгалзсан юм.

8. Шүүхийн шийдвэрийн хэрэгжилт

Захирамжийг хүчингүй болгох заргыг Филиппин Улсын Дээд шүүх, Бүсийн шүүхээр хэлэлцүүлсэн боловч амжилтад хүрээгүй юм. Ийнхүү эмэгтэйчүүдийн төлөөх төрийн бус байгууллага НҮБ-ын механизмыг ашиглан олон улсын анхаарлын төвд уг асуудлыг авчрахыг зорьсон. Энэ нь дараах шалтгаантай:

- 003 дугаар захирамж эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрхийг ноцтой зөрчсөн болохыг үндэсний болон олон улсын эмэгтэйчүүдийн эрхийн төлөөх төрийн бус байгууллагууд хүлээн зөвшөөрсөн.
- 003 дугаар захирамжаар Филиппин Улсын Засгийн газар, Үндсэн хууль болон олон улсын хүний эрхийн гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчиж байгаад үндэсний болон олон улсын төрийн бус байгууллагууд санаа зовниж, энэ асуудлыг Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн хорооны хүрээнд авч хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.
- Энэ хэрэг нь бусад улс орны засгийн газарт эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалахад олон улсын хүний эрхийн стандартыг үндэсний хууль тогтоомж, бодлогодоо нийцүүлж байх тухай анхааруулга болно.

9. НҮБ-ын механизмыг ашигласан байдал

- Филиппин Улс нь Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийг 1981 онд, түүний нэмэлт протоколыг 2004 онд тус тус соёрхон баталсан⁶⁹.
- 2008 онд үндэсний төрийн бус байгууллага болох Нөхөн үржихүйн төв, Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн хорооны Ажлын хэсэг (Эмэгтэйчүүдийн хороо) болоод Эмэгтэйчүүдийн эрхийн

⁶⁹ Захирамж гарах үед Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн Нэмэлт протоколыг соёрхон батлаагүй байсан.

хэрэгжилтийг хянах Ази Номхон Далайн бүс нутгийн байгууллага (АНДБНБ, англиар IWRAP), Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн хороо нь⁷⁰ Манила хотын эмэгтэйчүүдийн эрхийг ноцтой зөрчиж байгааг анхааралдаа авах талаар тайлан илгээсэн байна. Үүнээс гадна дөрвөн удаа хяналт шалгалт хийх хүсэлтийг илгээсэн. Үүнд:

- Хяналт шалгалт хийх тухай анхны хүсэлтийг 2008 оны 6-р сарын 4-ний өдөр
 - Хяналт шалгалт хийх тухай хоёр дахь хүсэлтийг 2008 оны 10-р сарын 27-ны өдөр
 - Хяналт шалгалт хийх тухай гурав дахь хүсэлтийг 2009 оны 4-р сарын 23-ны өдөр
 - Хяналт шалгалт хийх дөрөв дэх хүсэлтийг 2013 оны 6-р сарын 13-ны өдөр илгээсэн байна.
- 2010 оны 1-р сард өргөдөл, гомдлыг Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн хороонд илгээсэн.
- 2009 оны байдлаар төрийн бус байгууллагууд тодорхой арга хэмжээ авах талаар доорх НҮБ-ын тусгай илтгэгч нарт өргөдөл гомдол илгээсэн. Үүнд:
- Хүн бүрийн бие махбодийн болон сэтгэл зүйн эрүүл мэндийн наад захын боломжит стандартыг эдлэх асуудлыг хариуцсан тусгай илтгэгч
 - Эмэгтэйчүүдийн хүчирхийллийн шалтгаан нөхцөл, түүний үр дагаврын асуудлыг хариуцсан тусгай илтгэгч
 - Хүний эрхийн хамгаалагчдын хүний эрхийн асуудлыг хариуцсан тусгай илтгэгч
 - Шашин шүтлэг, итгэл үнэмшлийн асуудлыг хариуцсан тусгай илтгэгч
 - Нэн ядуурал болон хүний эрхийн асуудлыг хариуцсан тусгай илтгэгч

⁷⁰ Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн Нэмэлт протокол, НҮБ-ын Ерөнхий Асамблейгаар 1999 оны 10-р сарын 6-нд батлагдсан, A/RES/54/4, Зүйл 8

10. Хорооны шийдвэр

Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн Хороо нь Филиппиний Засгийн газар болон Филиппин Улс дахь НҮБ-ын суурин төлөөлөгчийн газарт хандан уг асуудалд 2009 оны 2-р сар гэхэд хариу өгөхийг шаардсан.

11. Дүгнэлт зөвлөмжийн хэрэгжилт

Филиппин Улс дахь НҮБ-ын суурин төлөөлөгчийн газар Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн Хороонд өөрийн нууц тайланг, Гадаад хэргийн яамнаас тус Хороонд хоёр төрлийн илтгэл тус тус илгээсэн. Үүнд:

- 1) Хорооны хүсэлтийг хүлээн авч, тусгай илтгэгч урих асуудлыг баталгаажуулах
- 2) Манила хотын 003 дугаар захирамжийг хүчингүйд тооцсон тухай мэдэгдэл

2013 оны 12-р сарын байдлаар Филиппин Улсад тусгай илтгэгчийг урих асуудал Засгийн газрын түвшинд яригдаж байгаа.

12. Өмгөөллийн үр нөлөө

Ийнхүү энэ хэрэг нь бүх шатны шүүхэд амжилт олоогүй ч олон улсын эрх зүйг ашигласан төрийн бус байгууллагын нөлөөллийн үйл ажиллагааны үр дүнд хотын захиргаа уг захирамжийг хүчингүй болгосон байна. Гэхдээ захирамжийн үр нөлөө нь олон эмэгтэйчүүдийн эрхийг зөрчсөн тул НҮБ-ын механизмыг үргэлжлүүлэн ашигласан юм. Энэ утгаараа Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн Хороо болон бусад улс орны засгийн газрын өмнө Филиппин Улсын Засгийн газар эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, олон улсын стандартад нийцүүлэх, зөрчлөө арилгах үүргийг хүлээж байна гэсэн үг юм.

13. Эх сурвалж

Эмэгтэйчүүдийн эрхийн хэрэгжилтийг хянах Ази Номхон Далайн бүс нутгийн байгууллага, "Эмэгтэйчүүд эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ нэхэмжлэх нь", Куала Лумпур, 2013 он, 41–50 тал болон 113–116-р тал.

3.1.3 Америкийн Нью-Йорк муж дахь боловсролын эрхийн хэрэг

1. **Нэхэмжлэгч:** Боловсролын хуулийн төв, оюутнууд, оюутнуудын эцэг эхийн төлөөлөл
2. **Хариуцагч:** АНУ-ын Нью-Йорк мужийн захиргаа
3. **Шийдвэрлэсэн шүүх, шүүхийн шийдвэрийн огноо:** АНУ-ын Нью-Йорк мужийн Анхан шатны шүүх, 2001 оны 1-р сар, Индекс: 719 N.Y.S.2d 475
4. **Нэхэмжлэлийн шаардлага:**

Мужийн Үндсэн хуулиар тунхагласан "Наад захын суурь боловсрол"-ыг сурагчдад эзэмшүүлэхэд шаардлагатай боловсролын санхүүжилт хийхийг Мужийн захиргаанд даалгах.

5. **Өмгөөллийн зорилго:**

Үндсэн хуулиар баталгаажсан суурь боловсрол эзэмших талаарх иргэдийн эрхийг зөрчиж буй төрийн байгууллагын эс үйлдэхүйд олон нийтийн анхаарлыг хандуулах, эл зөрчлийг дахин гаргуулахгүй байх, иргэдийн эрхийг зохих түвшинд эдлүүлэх талаар шүүхийн жишиг тогтоох.

6. **Хэргийн танилцуулга**

Нью-Йорк мужийн захиргаанаас Нью-Йорк хотын дунд сургуулиудад хуваарилж буй санхүүжилтийн асуудлаар "Боловсролын хуулийн төв" ТББ, сургуулийн сурагчид, эцэг эхийн төлөөлөл хамтран стратегийн өмгөөлөл хийсэн байна. Нэхэмжлэлийн үндэслэл нь: 1-д, Нью-Йорк мужийн Үндсэн хууль дахь Боловсролын талаарх заалтаар баталгаажсан, "наад захын суурь боловсрол"-ыг сурагчдад олгоход хүрэлцэхүйц хэмжээний санхүүжилтийг мужийн сургуулиудад олгох үүргээ мужийн захиргаа биелүүлээгүй; 2-т, мужийн санхүүжилтийн механизм нь Нью-Йорк хотын дунд сургуулийн үндэстний цөөнх сурагчдад (Эдгээр оюутнууд нь Нью-Йорк мужийн үндэстний цөөнх оюутнуудын 73%, Нью-Йорк хот дахь төрийн өмчит сургуулиудад шинээр элсэгчдийн 84%-ийг эзэлдэг.) ихээхэн сөрөг нөлөөтэй хэмээн маргасан байна. Энэ нь 1964 онд батлагдсан АНУ-ын Иргэний эрхийн Акт⁷¹-ын VI дахь хэсгийг зөрчсөн гэж нэхэмжлэгчид үзжээ.

⁷¹ Энэхүү Актаар Холбооноос санхүүгийн туслалцаа авсан аливаа хөтөлбөр, үйл ажиллагаанд арьс, үндэс, гарал угсаагаар нь ялгаварлан гадуурхахыг хориглосон байна.

7. Хийгдсэн ажиллагаа

✓ Шүүхийн шатанд

- 2001 оны 1–р сард Нью–Йорк мужийн Анхан шатны шүүхийн шүүгч Лиланд Дэ Грасс хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэсэн.
- Шүүхээс Нью–Йорк мужийн захиргаанаас баримталж буй боловсролын санхүүжилтийн аргачлал нь Нью–Йорк мужийн Үндсэн хууль дахь боловсролын талаарх заалтыг зөрчсөнийг тогтоосон байна. Учир нь тус хотын сурагчдад олгож буй боловсрол нь Боловсролын талаарх хуулийн заалтын “суурь босго”–оос хамаагүй доогуур байна гэж шүүхээс үзжээ. Мужийн төсвөөс санхүүждэг сургуулиудын санхүүжилтийн тогтолцоог сайжруулахад шаардлагатай шинэчлэлийг авч хэрэгжүүлэхийг Мужийн хууль тогтоогчид болон Амбан захирагчид анхан шатны шүүхээс даалгасан байна.
- Хариуцагч шийдвэрийг давж заалдсан ба хэргийг тус мужийн давж заалдах шатны шүүхээс хянан хэлэлцээд, анхан шатны шүүхийн шийдвэрийн үндэслэлийг дараах байдлаар өөрчилсөн байна. Үүнд:
 - “Үндсэн хууль дахь боловсролын талаарх заалтаар дунд сургуулиар олгогдох “Наад захын суурь боловсрол” нь сурагчдыг дээд боловсрол эзэмшихэд бэлтгэх, эсхүл дунд сургууль төгсөгчдийг хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөхүйц хэмжээний байхыг шаарддаг, цаашилбал тэднийг иргэнийхээ хувиар үр дүнтэй ажиллах, нийгмийн харилцаанд оролцох явдлыг хөхиүлэн дэмждэг” хэмээн дүгнээд,
 - “Дунд сургуулиудын санхүүжилтийн тогтолцоог шинэчлэхэд хариуцагчийн биелүүлбэл зохих наад захын үүрэг нь, Мужийн хэмжээнд “Наад захын суурь боловсрол”–ыг сурагчдад эзэмшүүлэхүйц бодит зардлыг хамгийн боломжит байдлаар баталгаажуулах явдал болно” гэсэн анхан шатны шүүхийн шийдвэрийг “Мужийн хэмжээнд бус, зөвхөн Нью–Йорк хотод л эл үүргийг хүлээлгэх нь зүйтэй” хэмээн өөрчилсөн байна.

8. Шүүхийн шийдвэрийн хэрэгжилт

- Хариуцагч шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй тул нэхэмжлэгч болон шүүхийн тусгай ажилтнуудын багаас⁷² ирүүлсэн мэдээллийн дагуу шүүгч Лиланд Дэ Грасс гаргасан шүүхийн шийдвэрийнхээ биелэлтийг хянаад 2005 оны 2–р сарын 14–нд хариуцагчид дахин үүрэг хүлээлгэсэн байна. Үүнд: “Наад захын суурь боловсрол”–ыг сурагчдад эзэмшүүлэхийн тулд ойрын 4 жилийн хугацаанд жил тутмын урсгал зардалдаа 5.6 сая ам.долларыг нэмж тусгах, мөн 5 жилийн хугацаанд 9.2 сая ам.долларыг хөрөнгийн зардалд нэмж зарцуулахыг үүрэг болгосон байна.
- Хариуцагч шийдвэрийг давж заалдсан ч анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр нь баталсан.
- Дээрх шийдвэрийг хэрэгжүүлэх үүднээс хариуцагчаас “Нью–Йорк мужийн төсвийн гэрээ 2006”–г батлан дунд сургуулиудын хөрөнгийн зардлын хэмжээг нэлээдгүй нэмэгдүүлсэн. Харин урсгал зардлын хэмжээг дөнгөж аравны нэг хувиар л өсгөсөн байна.

9. Өмгөөллийн үр дүн

Хэдийгээр энэхүү хэргийн шүүхийн шийдвэр нь зөвхөн Нью–Йорк хотын хэмжээнд гарсан ч Нью–Йорк мужийн хууль тогтоогчид болон амбан захирагчийн зүгээс шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч, мужийн дунд сургуулиудын санхүүжилтийн шинэчлэлийг санаачлан нийт мужийн хэмжээнд үйлчлэх “Боловсролын төсөв, шинэчлэлийн Акт”–ыг 2007 онд батлан хэрэгжүүлж эхлэхэд нөлөөлсөн байна.

10. Эх сурвалж

- Орон байрын эрхийн төв, “Эдийн засаг, нийгэм, соёлын эрх: Шилдэг хэргүүдийн эмхтгэл”, Баримт бичгийн цуврал 7, 2009 он <http://www.cohre.org/sites/default/files/leading_esc_rights_cases_24_april_2009.pdf>, 74–75 дахь тал.
- Боловсролын хуулийн төв, “Нью–Йорк мужийн захиргааны эсрэг Боловсролын хуулийн төвийн нэхэмжлэлтэй хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр” <<http://www.edlawcenter.org/assets/files/pdfs/cfe/CFE%202001%20Decision.pdf>>

⁷² Англиар “Referee” гэх бөгөөд шүүхээс томилогдсон шүүхийн ажилтан юм.

3.2 МОНГОЛ УЛСЫН СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛЛИЙН ХЭРЭГ

3.2.1 Хууль сахиулах байгууллагын ажилтны буруутай үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг шүүхээр барагдуулах

- 1. Нэхэмжлэгч:** Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч ХЭҮК (С.Эрдэнэ—Очир, Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын харьяат).
- 2. Хариуцагч:** Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 389 дүгээр зүйлийн 389.1, 390 дүгээр зүйлийн 390.2—т заасныг үндэслэл болгон Санхүү, эдийн засгийн яамны (хуучин нэрээр) Төрийн сангийн газар.
- 3. Шийдвэрлэсэн шүүх, шүүхийн шийдвэрийн огноо:**
 - 2002 оны 9—р сарын 25—ны өдөр Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн хяналтын шатны шүүх хуралдааны магадлалаар холбогдох эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон шийдвэр.
 - Нийслэлийн Баянзүрх дүүргийн шүүх, 2004 он.

4. Нэхэмжлэлийн шаардлага

ХЭҮК нь 2004 онд хохирогчийн хүсэлтийг үндэслэн түүний нэрийн өмнөөс Баянзүрх дүүргийн шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргажээ. Учирсан хохирол болох 53,699,225 төгрөгийг дараах байдлаар тооцож, шүүхэд нэхэмжлэл гаргасан. Үүнд:

- Нэхэмжлэгч ажил хөдөлмөр эрхэлж олох байсан орлогыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр бодон 1,610,625 төгрөг;
- Нэхэмжлэгч хоригдохын өмнө 185 толгой малтай байсан. Иймээс нэхэмжлэгч малаа өсгөж үржүүлсэн бол тоо толгой нь хэд хүрэх байсныг мэргэжлийн хүмүүсийн оролцоотойгоор тооцоолж нийт 20,988,600 төгрөг;
- Өмгөөлөгчийн хөлсөнд 500,000 төгрөг (Хэдийгээр олон өмгөөлөгч авч хөлс төлсөн ч нэг л төлбөрийн баримт байсан.);
- Нэхэмжлэгч хилс хэрэгт холбогдсоноос хойш эцэг эх, ах дүүс нь Завхан — Улаанбаатарын хооронд нийт 30 удаа онгоц, машинаар явсныг тооцож 600,000 төгрөг;

- Гурван удаа цаазаар авах ял сонссоноос үүссэн сэтгэл санаа, эрүүл мэндийн хохирлыг 29,000,000 сая төгрөг;
- Сонин хэвлэлээр “алуурчин” хэмээгдэж, энэ нь орон даяар цацагдаж байсан тул нэр төрөө сэргээлгэхэд 1,000,000 төгрөг гэж тус тус тооцоолжээ.

5. Өмгөөллийн зорилго

- Хангалттай бус нотлох баримтад тулгуурлан шүүхээр шийтгэж буй ажиллагааг таслан зогсоох, хууль сахиулах байгууллагын ажилтнуудын хүний эрхийн зөрчлийг ил болгох.
- Албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас болж хохирсон иргэдэд нөхөн төлбөр олгодог жишгийг тогтоох.

6. Хэргийн танилцуулга

Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын нутагт 1995 оны 12–р сарын 31–ний өдөр хүн амины хэрэг гарчээ. Цагдаагийн албан хаагч Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчиж хуульд заасан хугацааг хэтрүүлэн хорьсон, нотлох баримт цуглуулсан, эрүүдэн шүүсэн, шүүх нотлох баримтыг бодитой үнэлж чадаагүй зэрэг зөрчил гаргасан гэж үзсэн. Үүний улмаас гомдол гаргагчийг 3 удаа цаазаар авах ялаар, 3 удаа 25 жилийн хорих ялаар шийтгэсэн тогтоол гарч, энэ хугацаанд гянданд уг ялыг эдэлсэн байна.

7. Хийгдсэн ажиллагаа

✓ Хэрэг үүсгүүлэх бэлтгэл ажлын хүрээнд

- Энэ хэргийн хохирогч, түүний ар гэрийнхний хүсэлтээр өмгөөлөгч н.Лхамжав хавтаст хэргийн материалтай танилцсан.
- Цагаатгасан шүүхийн шийдвэрийн дараа хохирогч, түүний ар гэрийнхний сэтгэл санааны болон эд материалын хохирлыг нөхөн барагдуулах нэхэмжлэлийг шүүхэд гаргасан.

✓ Шүүхийн шатанд

- Завхан аймгийн шүүхийн шийтгэх тогтоолыг хүчингүй болгох, яллагдагчийг цагаатгах зорилгоор шүүхэд хандсан. Стратегийн өмгөөллийн хэргийн зорилго нь:

- Шүүхээс гэм буруутгүй хүнийг шийтгэхгүй байх;
 - Нотлох баримтыг цуглуулахдаа Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн шаардлагыг чанд сахих;
 - Албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас болж хохирсон иргэнд нөхөн төлбөр олгодог жишиг тогтоох.
- Нийслэлийн Баянзүрх дүүргийн шүүх Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1–д зааснаар Санхүү, эдийн засгийн яамны Төрийн сангийн газраас 18,010,625 төгрөг гаргаж нэхэмжлэгчид олгох шийдвэрийг гаргасан байна.
- Хэвлэл мэдээллийн хэрэгслийг өргөн ашигласнаар хууль зөрчсөн үйл ажиллагаа явуулсан албан тушаалтнууд хариуцлага хүлээдэг, хохирогч хохирлоо барагдуулах боломжтой болохыг олон нийтэд таниулж чадсан.

8. Шүүхийн шийдвэрийн хэрэгжилт

- Өмгөөлөгчийн зүтгэлийн үр дүнд 2002 оны 9–р сарын 25–ны өдөр Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх хуралдааны магадлалаар холбогдох эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож шоронгоос сулласан байна.
- Санхүү, эдийн засгийн яамны Төрийн сангийн газраас 18,010,625 төгрөгийг нэхэмжлэгчийн дансанд шилжүүлсэн.

9. Өмгөөллийн үр дүн

- Хохирогчдыг төлөөлж ХЭҮК–оос нэхэмжлэл гаргах эрхийг баталгаажуулж өгсөн.
- Энэ хэргийн үр дүнд хууль сахиулах байгууллагын ажилтны хариуцлагагүй, хайхрамжгүй үйл ажиллагаа нь хүний эрхийг ноцтой зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох хуулийн заалт байдаг боловч, хэрэгждэггүй практикийг илрүүлж гаргасан ач холбогдолтой.
- Хуулийн байгууллагын ажилтнуудын буруутай үйл ажиллагаанаас болж хохирсон иргэдийн хохирлыг төлүүлэх хуулийн заалтыг анх удаа хэрэглэсэн.
- Тухайн стратегийн өмгөөллийн хэрэг нь хохирлыг төлүүлдэг жишиг тогтоох, улмаар хүний эрхийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхэд ач холбогдлоо өгсөөр байна.

10. Эх сурвалж

Нээлтэй Нийгэм Форум, “Стратегийн өмгөөлөл: Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах нь” (Өмгөөлөгчдөд зориулсан гарын авлага), УБ, 2006 он, 47–50 тал.

3.2.2 Хүн худалдаалах гэмт хэргийн⁷³ хохирогчийн нэр төр, алдар хүндийг хүндэтгэх

1. **Нэхэмжлэгч:** Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч
2. **Хариуцагч:** “Монголын үнэн”, “Шар мэдээ” сонины газар
3. **Шийдвэрлэсэн шүүх, шүүхийн шийдвэрийн огноо:**
 - Сүхбаатар дүүргийн шүүхийн 2011 оны “...”⁷⁴сарын “...”-ны өдрийн “...” дугаар шийдвэр
 - Сүхбаатар дүүргийн шүүхийн 2011 оны “...” сарын “...”-ны өдрийн “...” дугаар шийдвэр
 - Нийслэлийн шүүхийн 2011 оны “...” сарын “...”-ны өдрийн “...” дугаар шийдвэр
4. **Нэхэмжлэлийн шаардлага**
 - Хаалттай шүүх хурлаар шийдвэрлэсэн хэргийн хохирогчийн нэрийг бүтнээр нь бичиж нэр төрд нь халдан, гутаан доромжилсон учир нэр төрөө сэргээлгэх;
 - “Үнэн” болон “Шар мэдээ” сонины газраас нэр төр сэргээлгэх, эрүүл мэндэд учирсан сэтгэл заслын эмчилгээний төлбөрт 3,260,000 төгрөгийг гаргуулах;
 - Уг хоёр сонины хэвлэгдсэн хувь хэмжээ, сэтгэл санааны хохирол зэрэг байдлыг харгалзан үзэж сонины газар тус бүрээс гэм хорын хохиролд 30,0 сая төгрөгийг гаргуулах;

⁷³ Хүн худалдаалах гэмт хэргийн харьяаллыг Улсын мөрдөн байцаах газрын Онц хүнд, зохион байгуулалттай гэмт хэргийг шалгах хэлтэст хамааруулж байснаа 2010 оноос хүн худалдаалах гэмт хэргийг шалгах тусгай тасгийг үүсгэн байгуулж, хяналт тавих бүрэн эрхийг Нийслэлийн прокурорын газарт үүрэг болгосон нь энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах, хянах үйл ажиллагааны арга тактикийг боловсронгуй болгох, мэргэшсэн хуульчдын багийг үүсгэхэд чухал түлхэц болсон юм. Энэхүү шийдвэр гарахад Хүний эрх хөгжил төвөөс хэрэгжүүлсэн сургалт, сурталчилгаа, стратегийн өмгөөллийн хэргүүд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн.

⁷⁴ Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчтой холбоотой эрүүгийн хэргийн үргэлжлэл тул хохирогчийн аюулгүй байдал, нэр төрийг хамгаалах үүднээс “...” гэсэн тэмдэгтээр оруулаа.

- Хохирогч нь сэтгэл санаанд учирсан хохирлоо нөхөн төлүүлэх, нэр төрөө сэргээлгэхээр иргэний журмаар хэргийг үргэлжлүүлэх сонирхолтой байсан.

5. Өмгөөллийн зорилго

Энэ хэргийн хувьд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа дуусгавар болсон бөгөөд бүх шатны шүүх нь гэмт этгээдийг буруутайд тооцон зохих ялыг оноосон юм. Гэтэл өдөр тутмын сонинуудаар хохирогчийн нэр, хаяг, бусад хувийн мэдээллийг нийтэлж Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг зөрчсөн явдал юм. Сэтгүүлчийн ёс зүйн алдаанаас болж хохирогч шууд бусаар бие махбодийн болон сэтгэл санааны хохирол амссан. Энэ хэргээр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа дуусгавар болоогүй байхад олон нийтэд мэдээлдэг асуудлыг таслан зогсоох, хэвлэл мэдээллийнхэн хаалттай явагддаг шүүх хуралдааны мэдээллийг холбогдох ёс зүйн дүрмийн дагуу олон нийтэд мэдээлж байх, сэтгүүлчийн ёс зүй, хариуцлагыг нэмэгдүүлэх, цаашид хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой хэргийн хохирогчийн хувийн мэдээллийг ил болгох асуудлыг таслан зогсоох, мэдээллийн улмаас үүссэн бие махбодийн болон сэтгэл санааны хохирлыг барагдуулдаг жишиг тогтоох зорилго тавьснаараа энэхүү хэрэг нь стратегийн өмгөөллийн шинжийг агуулсан.

Шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн шүүх хурлын дараах хамгаалалтын асуудлыг анхааралдаа авах нь чухал байгааг энэ хэрэг нотлон харуулсан. Түүнчлэн энэ гэмт хэргийн хохирогчдод хамаарах онцлог байдлын талаар бусад салбарын мэргэжилтнүүдэд сургалт явуулах, мэдээлэл өгөх зайлшгүй хэрэгцээ, шаардлага гарч байгаа нь харагдаж байна. Энэ хэргийн хувьд хэвлэл мэдээллийн оролцоо хохирогчдод сөрөг нөлөө үзүүлсэн юм. Стратегийн өмгөөлөлд хэвлэл мэдээллийн хэрэгсэл хүчтэй нөлөөлөл үзүүлдэг хэдий ч зарим нэг онцлог хэрэгт хэвлэл мэдээллийн хэрэслийн оролцоог хязгаарлаж, олон нийтэд хандсан мэдээллээ эрх зүйн орчин, анхааруулга, урьдчилан сэргийлэхэд хандуулах нь зүйтэй юм. Энэ хэргийн хувьд сэтгүүлчийн ёс зүйн алдааны улмаас хохирогчид гэм хор учирсан. Сэтгүүлчийн ёс зүйн алдаа дараах байдлаар илэрхийлэгдэнэ. Үүнд:

- Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын үзэл баримтлалыг сэтгүүлч хүндэтгэх бөгөөд хувь хүний нэр төрийг гутаан

доромжлох, алдар хүндэд нь дураар халдахыг цээрлэвэл зохино гэсэн заалтыг сэтгүүлч бүдүүлгээр зөрчсөн юм.

- “Гэмт хэргийн мэдээллийг түгээхдээ холбогдогчийн ар гэр, хамаатан садан, найз нөхөд, хэргийн хохирогч насанд хүрээгүй хүүхдийн овог, нэртэй нь дэлгэхээс зайлсхийнэ” гэсэн Монгол Улсын Үндсэн хууль, Хувь хүний нууцын тухай хуулийн зүйл, заалтыг зөрчсөн.
- Мэргэжлийн ёс зүйн зарчим, хэм хэмжээнд харш зүйлийн 11–д Бие хүний хувийн ахуй амьдралтай холбоотой мэдээллийг түүний зөвшөөрөлгүй нийтэлж нэвтрүүлэх, 12–т Бодит үнэнд нийцэж байгаа ч нийгэмд ач холбогдолгүй мэдээг нийтэлж, нэвтрүүлэх замаар бие хүний нэр төрд хохирол учруулах гэсэн зүйлийг зөрчсөн. Сэтгүүлчийн ёс зүйн дүрмийн 12–т зөвтгөх хангалттай шалтгаан байхгүй бол ямар ч тохиолдолд хүчингийн хэргийн хохирогчдын овог, нэр болон хохирогч чухам хэн болох, мөн олон нийтэд танигдахуйц содон шинж тэмдгийг дэлгэхийг хориглосон.

6. Хэргийн танилцуулга

Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн гэмт хэрэгтэн Б.Ерөө – Янжин, Б.Цэрэн – Янжин нар бүлэглэн 2008 оны 11 – р сарын 25 – ны өдөр иргэн Э, Б, А нарын биеийг үнэлүүлэн мөлжих зорилгоор “Малайз Улсад гэрийн үйлчлэгч хийх, хүүхэд асрах, нохой салхилуулах зэрэг өндөр цалинтай ажилд зуучлан оруулж өгнө” гэж хуурч мэхлэн, тэдний эмзэг байдлыг ашиглан Замын – Үүд боомтоор хил давуулан Малайз Улсад аваачин худалдсан. Мөн хоёр сарын дараа иргэн С, Са болон Г нарын биеийг үнэлүүлэн мөлжих зорилгоор “Малайз Улсад караокед өндөр цалинтай массажист ажилд оруулж өгнө” гэж хуурч мэхлэн Замын Үүд боомтоор хил давуулан нийт зургаан эмэгтэйт Малайз Уулсын иргэнд худалдсан гэмт хэрэгт холбогджээ. Хэрэгтнүүд нийт найман охиныг элсүүлсэн бөгөөд тэднийг Куала Лумпурт буух үед нэрийг нь бичсэн самбар барьсан үл таних хүн онгоцны буудал дээр тосож авсан ба тэр хотод өөр нэгэн газар аваачаад тэднийг цоожтой өрөөнд хорихдоо “Энд ирсэн тээврийн зардлаа төлж байж буцна” хэмээн хэлсэн байна. Тэдний санал болгосноор тэд биеэ үнэлэх ажил хийж, өрөө төлөх ёстой байв. Уг хэргийн нэг хохирогч нь нүүрээ зүсч байж тэндээс зугтаж гарч ирсэн. Хэргийн бусад хохирогч нь Монгол Улсын Элчин сайдын яамтай

холбоо барьж, улмаар Монголын талаас тусламж авч байж ирсэн. Нүүрээ зүссэн хохирогч Монголд буцаж ирээд Монгол дахь зуучлагчдын эсрэг эрүүгийн хэрэг үүсгэн шийдвэрлүүлсэн юм. Б.Ерөө—Янжин, Б.Цэрэн—Янжин нарыг өмгөөлөгчдийнх нь гомдлоор 3 шатны шүүхээр хянаж, 2010 оны 9—р сарын 29—ний өдөр Улсын дээд шүүхийн Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны тогтоолоор Б.Ерөө—Янжинг Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн 113.3—т зааснаар 11 жил хорих, Б.Цэрэн—Янжинг 10 жил 1 сарын хорих ялаар шийтгэсэн давж заалдах шатны магадлалыг хэвээр баталсан.

Энэ хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах чиглэлээр мэргэшин ажиллаж байгаа өмгөөлөгч ажилласан явдал. Тэрээр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд идэвхтэй оролцож, хохирогчийг гадаад улсад байх үеэс эхлэн холбоо тогтоон эрүүгийн хэрэг үүсгүүлж чадсан бөгөөд гэмт этгээдэд зохих хариуцлагыг ноогдуулсан юм. Энэ хэрэг нь Монгол Улсад хүн худалдаалах гэмт хэргийг шуурхай шийдвэрлэж болохыг батлан харуулж чадсан. Гэвч энэ эрүүгийн хэрэгт гэмт хэргийг шийдвэрлэхэд тогтсон муу жишгүүд сөрөг нөлөөлөл үзүүлсэн. Үүнд:

- Хохирогч хохирлоо нэхэмжилсэн хэдий ч шүүгдэгч эрүүгийн хариуцлага хүлээсэн гэдгээр хохирлыг нь барагдуулаагүй.
- Сэтгэл санааны хохиролд нөхөн төлбөр олгоогүй.
- Эрүүгийн хэргийг шийдвэрлэсний дараа иргэний журмаар хохирол барагдуулаагүй.

Өөр нэгэн ноцтой асуудал бол эрүүгийн шүүх хуралдааны дараа “Үнэн” болон “Шар мэдээ” гэх өдөр тутмын сонинуудаар хохирогчийн нэр, хаяг, бусад хувийн мэдээллийг нийтэлж Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг зөрчсөн явдал байсан. Энэ хэрэг нь хохирогч хүнд нөхцөл байдлыг даван туулж, онц хүнд гэмт хэргийг илрүүлэхэд иргэний үүргээ ухамсартайгаар биелүүлсэн хэдий ч гэмт хэргийн хохирогчдын хамгаалалт сул байгаагаас давхар хохирч байгааг батлан харуулсан хэрэг юм.

7. Хийгдсэн ажиллагаа

- 2010 оны 9—р сард эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа дуусч гэмт хэрэгтэнд ял оногдуулсан хэдий ч хохирогчдын

сэтгэл санааны хохиролд нөхөн төлбөр олгоогүй. Хохирогчид иргэний журмаар нэхэмжлэл гаргах хүсэлтэй байсан хэдий ч өдөр тутмын сонинд хохирогчийн нэр, хаяг зэрэг хувийн мэдээлэл цацагдсан тул стратегийн өмгөөлөгчид хуулийн тактикаа солих шаардлага гарсан юм.

- Энэ хэрэг нь хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудын ёс зүйн алдаанаас болж хохирогч давхар хохирол амссан тохиолдол бөгөөд уг хохирлыг буруутай байгууллагаас нэхэмжлэх нь хуульд нийцсэн арга хэмжээ гэж үзээд Хүний эрх хөгжил төв 2011 оны 1–р сард хохирогчийн хүсэлтийг үндэслэн иргэний журмаар нэхэмжлэл гаргахад нь нэхэмжлэл бичиж холбогдох нотлох баримтуудын хамт хүргүүлсэн.

✓ Шүүхийн шатанд

Шүүх ажиллагааны үйл явц хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод ихээхэн сэтгэл зүйн дарамт учруулдаг тул Хүний эрх хөгжил төвийн нийгмийн ажилтан, хуульч нь үйлчлүүлэгчтэйгээ байнгын холбоотой ажиллаж байсан бөгөөд шүүх хуралдаан болохын өмнө өдөр бүр уулзалт хийж, тухайн шүүх процессын ажиллагааны явцыг тайлбарлаж өгөх, эсхүл шүүх хуралдааны шүүгчийн зөвшөөрлөөр шүүх хуралд оролцож байсан. Мөн хэрэгт ач холбогдол бүхий мэдээллийг өгүүлэх зорилгоор гэрчээр байцаалгахаар хохирогчийн өмгөөлөгч хүсэлт гаргаж байв. Энэ хэргээр дамжуулан олон нийтэд чиглэсэн мэдлэг дээшлүүлэх ажиллагаа хийхэд хягзаарлагдмал байсан. Харин хувь хүний хэргээр дамжуулан хохирогчийг хамгаалах механизмыг сайжруулахад жишиг хэрэг болж өгснөөрөө ач холбогдолтой. Түүнчлэн энэ хэргийг шийдвэрлэх хугацаанд хүмүүнлэгийн байгууллага санхүүгийн болон эд материалын тусламжийг нэхэмжлэгч, түүний ар гэрт үзүүлж байсан бөгөөд энэхүү дэмжлэг нь шүүх ажиллагааг даван туулахад ихээхэн нэмэртэй байсныг дурдах нь зүйтэй.

Иргэний журмаар нэхэмжлэл гаргахад шүүхийн зардал буюу улсын тэмдэгтийн хураамж чухал үүрэгтэй. Энэ утгаараа Хүний эрх хөгжил төв шүүхийн бүх шатанд шүүхэд төлөх улсын тэмдэгтийн хураамжийг нэхэмжлэгчийн өмнөөс төлж байсан бөгөөд Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимд хяналтын журмаар гомдол гаргахад улсын тэмдэгтийн

хураамжаас чөлөөлүүлэх тухай хүсэлтийг шүүхэд гаргаж, холбогдох материалыг бүртгүүлж өгсөн.

Анхан шатны шүүх нь нэхэмжлэгч Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн 113.3–т заасан хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон байх ба түүний хувийн нууцыг хамгаалах үүднээс тухайн гэмт хэргийг үйлдсэн этгээдүүдэд холбогдох хэргийн шүүх хуралдааныг хуульд зааснаар хаалттай явуулсан хэдий ч Хувь хүний нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтын "хувь хүний нэр төр, алдар хүнд, ашиг сонирхолд харшлах мэдээлэл нь хувь хүний нууцад хамаарах"–аар заасныг зөрчсөн гэж үзэн хохирогчийн зөвшөөрөлгүйгээр мэдээлэл тарааснаас учирсан хохиролд "Монголын үнэн" сонины газраас 30.0 сая төгрөг, "Шар мэдээ" сонины газраас 30.0 сая төгрөгийг тус тус гаргуулах шийдвэр гаргуулж чадсан юм. Энэ үүднээсээ Хувь хүний нууцын тухай хуулийг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн асуудалд хамаатуулж хэрэглэсэн жишиг хэрэг болсон. Гэхдээ давж заалдах шатны шүүхийн магадлал анхан шатны шүүхийн шийдвэрийн гэм хорын хэмжээг бууруулан тогтоосон. Тухайлбал, эмчилгээний зардал болох 3,260,000 төгрөгийн 1,940,000 төгрөгийг "Монголын үнэн" сонины газраас, 1,320,000 төгрөгийг "Шар мэдээ" сонины газраас, сэтгэл санааны хохирол болох 1,500,000 төгрөгийн 1,000,000 төгрөгийг "Монголын үнэн" сонины газраас, 500,000 төгрөгийг "Шар мэдээ" сонины газраас гаргуулахаар тогтоож, үлдсэн 61,760,000 төгрөгийн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн юм. Энэ хэргийн үр дүнд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын сэтгэл санааны хохирлыг барагдуулах асуудлыг анхан шатны шүүх нааштайгаар шийдсэн ч давж заалдах шатны шүүх дээрх хүсэлтийг хангаагүй. Энэ байдал бусад жишиг хэргүүд дээр ч мөн ажиглагдсан юм.

8. Шүүхийн шийдвэрийн хэрэгжилт

2012 оны 6–р сарын байдлаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байсан ба хариуцагчид төлбөрийг нэхэмжлэгчийн дансанд хийхээр болсон.

9. Өмгөөллийн үр дүн

Энэ хэргийн анхны үйл явц нь хаалттай явагддаг шүүх хуралд шинэ журам бий болгох асуудал байсан. Шүүх хуралдаанд оролцогчдоос "шүүхийн хэлэлцүүлгийн явцад олж мэдсэн

мэдээллийг бусдад задруулахгүй байх" тухай сануулж, гарын үсэг зуруулах зэрэг асуудлыг багтаасан юм.

Хохирогч нь мэргэжлийн байгууллага, өмгөөлөгчийн тусламжтайгаар хуулиар баталгаажсан эрхээ бүрэн дүүрэн эдлэх боломжийг баталгаажуулсан.

Үүнээс гадна сэтгүүлчийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх, ялангуяа, жендерт суурилсан гэмт хэргийн хохирогчийн онцлогийг тусгасан тусгайлсан сургалтууд явуулах хэрэгцээ байгаа нь энэ хэргээс харагдаж байсан.

Стратегийн өмгөөлөлд хэвлэл мэдээллийн хэрэгсэл чухал нөлөө үзүүлдэг ч зарим нэг стратегийн өмгөөллийн хэрэгт хэвлэл мэдээллийн хэрэгслээс илүүтэй холбогдох албан тушаалтан шийдвэр гаргагчидтай биечлэн уулзах, хуулийн байгууллагатай тулж ажиллах нь ач холбогдолтой юм.

Ийнхүү шинэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаа нь тухайн байгууллага, хуульчаас мэргэжлийн өндөр ур чадвар, шинэлэг хандлага, олон улсын хэм хэмжээтэй харьцуулан дүгнэлт хийх чадварыг зайлшгүй шаарддаг нь дээрх хэргээс харагдаж байлаа.

10. Эх сурвалж

Хүний эрх хөгжил төв, "Хүн худалдаалах гэмт хэргийн гэрч/хохирогчийг хамгаалах стратегийн өмгөөллийн төслийн тайлан 2012", УБ, 2013 он.

3.2.3 Байгаль орчны хохирлыг гэм буруутай этгээдээс гаргуулах

1. **Нэхэмжлэгч:** "Байгаль хамгаалах иргэний хөдөлгөөнүүдийн эвсэл" ТББ (Эвсэл) болон Дорнод аймгийн Матад сумын 5 иргэн
2. **Хариуцагч:** Газрын тосны олборлолт, хайгуулын "Б" ХХК
3. **Шийдвэрлэсэн шүүх, шүүхийн шийдвэрийн огноо, дугаар:**
 - Баянзүрх дүүргийн шүүхийн 2012 оны 4-р сарын 17-ны өдрийн 854 дүгээр шийдвэр
 - Нийслэлийн шүүхийн 2012 оны 7-р сарын 2-ны өдрийн 519 дүгээр магадлал
 - Улсын дээд шүүхийн 2012 оны 10-р сарын 4-ний өдрийн тогтоол.

4. Нэхэмжлэлийн шаардлага

- Хариуцагч нь Дорнод аймгийн Матад сумын нутагт газрын тосны хайгуул, олборлолт хийхдээ байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажиллагааг хангалтгүй явуулсан болохыг тогтоолгох;
- Байгаль хамгаалах төлөвлөгөөний дагуу байгаль орчныг хамгаалах ажиллагаа явуулах, байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэхийг хариуцагчид даалгах;
- Байгаль орчинд учруулсан хохирол, нөхөн төлбөр болох 1,356,622,460 төгрөгийг хариуцагчаас гаргуулан Дорнод аймгийн Матад сумын төсөвт оруулах.

5. Өмгөөллийн зорилго

Олборлох салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдээс байгаль орчинд учруулсан хохирлыг шүүхээр гаргуулах, иргэдийн зөрчигдсөн “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх” –ийг шүүхээр сэргээн тогтоолгох талаар жишиг тогтоох.

6. Хэргийн танилцуулга

Б компани нь Монгол Улсын Засгийн газартай байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу Дорнод аймгийн Матад сумын Тамсагийн сав газар дахь XIX талбайд 2005 оноос эхлэн газрын тосны хайгуул, олборлолт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагааг эрхэлж ирсэн байна. Ингэхдээ тус компани нь Газрын тосны тухай хууль болон Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан “байгалийн нөөц баялаг, газар, хэвлий болон түүний хүрээлэн байгаа орчинд хохирол учруулахгүй байх, ашигласан талбайг сэргээх” үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс байгаль орчинд үнэлж баршгүй хохирол учруулсан. Тухайлбал, уурхайн кэмийн орчимд газрын хөрс талхлагдан олон салаа зам үүсч, салхи шуургатай үед агаар дахь тоосонцрын агууламж эрс нэмэгдэн агаарын чанарын стандартаас олон дахин давсан. Бохирдсон, газрын тосны хайгуулын өрмийн шингэн хаягдлын 368, үйлдвэрлэлийн шингэн хаягдлын 20 гаруй санг саармагжуулж, хоргүйжүүлэхгүйгээр шууд шороогоор булж газрын хөрсийг химийн хорт бодисоор бохирдуулсан байна. Цаашилбал, дээрх хууль зөрчсөн үйлдлийн улмаас нутгийн иргэдэд сэтгэл санаа, эрүүл мэнд, эдийн засгийн үнэлж баршгүй хохирол (тээвэрлэлтээс үүдсэн тоосжилт хэрээс

хэтэрч, малчид идээшиж дассан нутгаа орхин нүүх, ямааны ноолуурт нарийн ширхэгтэй тоос сууснаас зах зээлд борлогдохоо больсон зэрэг) учирсан хэмээн нэхэмжлэгчид маргасан байна.

7. Хийгдсэн ажиллагаа

✓ Өмгөөллийн үйл ажиллагааны талаар

- 2010 оны 1–р сараас хэргийг эхлүүлсэн.
- Нэхэмжлэгчээр сумын Засаг дарга болон сумын нэр бүхий 5 иргэнийг сонгосон.
- Нотлох баримт цуглуулах ажлын хүрээнд малчидтай газар дээр нь очиж уулзан ярилцлага, ажиглалт, баримтжуулалт хийсэн (зарим тохиолдолд сэтгүүлчдийн багтай хамт)
- Компанийн газрын тосны үйл ажиллагаа, тус компанитай байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой баримт, мэдээлэл цуглуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын дарга, гишүүд, газрын тос, байгаль орчин, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн байгууллагуудад хандаж нийт 27 удаа албан бичиг илгээсэн.
- Мөн Эвслээс гаргасан өргөдөл, хүсэлтийн хариуг хуулийн хугацаанд гаргаж өгөөгүй байгууллага, албан тушаалтны харьяалах дээд шатны байгууллага, албан тушаалтанд 9 удаа гомдол гаргасан.

✓ Нөлөөллийн үйл ажиллагааны талаар

- Стратегийн өмгөөллийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилсэн хоёр жил гаруйн хугацаанд нөлөөллийн үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр төлөвлөгөөтэйгээр, тасралтгүй явуулсан. Үүнд, телевизийн мэдээ, нэвтрүүлэг 19, телевизийн хэлэлцүүлэг 1, сонины мэдээ, нийтлэлийг 43 удаа нийтэлж, нэвтрүүлэхийн зэрэгцээ 4 удаа хэвлэлийн бага хурал, 1 удаа нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.
- Мөн Б компанийн үйл ажиллагааг хууль, журмын дагуу явуулах, Матад сумын иргэдийн эрх ашгийг хамгаалах, газрын тосыг монголчуудад үр өгөөжтэйгээр ашиглахыг төр засгийн эрх баригчдаас шаардаж хэд хэдэн удаа Сүхбаатарын талбай дээр лоозон барьж, цуглаанд оролцсон.

- Орон нутагт мөн нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулсан. Үүнд, Дорнод аймгийн иргэдээс төр засгийн удирдлагуудад гурвантаа шаардлага тавьж, түүнийг дэмжсэн 300 хүний гарын үсэг цуглуулсан. Сэтгүүлчдийг газар дээр нь аваачиж сурвалжлага хийлгүүлсэн.

✓ Шүүхийн шатанд

- 2010 оны 5–р сарын 5–нд Баянзүрх дүүргийн шүүхэд сумын Засаг дарга болон Матад сумын 5 иргэний зүгээс Б компанид холбогдуулан “Байгаль орчны нөхөн сэргээлт хийхийг даалгах, байгаль орчны хохирол гаргуулах шаардлага бүхий” нэхэмжлэл гаргасан.
- Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгчийн 2010 оны 7–р сарын 30–ны өдрийн 4484 дүгээр захирамжийн дагуу тус компанийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учирсан хохирлын хэмжээг тогтоохоор томилогдсон шинжээчид дүгнэлтээ гаргасан. Дүгнэлтээр газрын хөрс, бэлчээрт учирсан нийт хохирлын хэмжээ 1,356,622,460 төгрөг болохыг тогтоосон байна.
- Баянзүрх дүүргийн шүүхийн 2011 оны 7–р сарын 8–ны өдрийн шүүх хуралдаанаар сумын Засаг дарга хариуцагчтай эвлэрч, нэхэмжлэлээс татгалзсан.
- 2011 оны 9–р сарын 5–ны өдөр Эвсэл өөрийн нэрийн өмнөөс Баянзүрх дүүргийн шүүхэд дахин нэхэмжлэл гаргасан.
- Хэргийн товлогдсон шүүх хуралдаан 3 удаа хойшлогдсон.
- 2012 оны 4–р сарын 17–ны өдөр 4 дэх удаагаа товлогдсон шүүх хуралдаан болж, 854 дүгээр шийдвэр гарсан. Уг шийдвэрээр Б компани нь Дорнод аймгийн Матад сумын Буян–Өндөр багийн нутагт газрын тосны үйл ажиллагаа явуулахдаа байгаль хамгаалах, нөхөн сэргээх үүргээ бүрэн биелүүлээгүй болохыг тогтоож байгаль орчинд учирсан хохирол болох 1,356,622,460 төгрөгийг тус компаниас гаргуулж Матад сумын төсөвт олгохыг даалгасан.
- Хариуцагч анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдсан ба давж заалдах шатны шүүхийн 2012 оны 7–р сарын 2–ны өдрийн 519 дүгээр магадлалаар шийдвэрийг хэвээр нь баталсан.

- Хариуцагч Улсын дээд шүүхэд хяналтын журмаар гомдол гаргасан ба Улсын дээд шүүх 2012 оны 10–р сарын 4–ний өдөр гомдлыг хянан хэлэлцээд шийдвэр, магадлалыг хэвээр нь баталсан байна.
- Хариуцагч 2012 оны 12–р сарын 6–ны өдөр Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид хандсан ч Ерөнхий шүүгч гомдлыг хүлээн авах боломжгүй гэсэн хариу өгсөн.
- 2013 оны 2–р сарын 28–нд хариуцагчаас “Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах тухай” хүсэлтийг Улсын дээд шүүхэд гаргасныг 2013 оны 4–р сарын 4–ний өдөр хянан хэлэлцээд хариуцагчийн хүсэлтийг хангахаас татгалзсан.
- 2013 оны 5–р сарын 23–нд хариуцагчаас 2 дахь удаагаа “Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах тухай” хүсэлтийг Улсын дээд шүүхэд гаргасныг 2013 оны 6–р сарын 25–ны өдөр хэлэлцээд хариуцагчийн хүсэлтийг хангахаас мөн татгалзсан байна.

8. Шүүхийн шийдвэрийн хэрэгжилт

Шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөр 1,356,622,460 төгрөгийг хариуцагч Б компани нь Дорнод аймгийн Матад сумын төсөвт найман сарын хугацаанд бүрэн төлж барагдуулсан байна.

9. Өмгөөллийн үр дүн

Байгаль орчинд учруулсан хохирлыг гэм буруутай этгээдээс нэхэмжлэн бодитойгоор гаргуулж болох тухай сайн жишиг тогтоосон стратегийн өмгөөллийн анхны хэрэг гэж үзэж болно. Тодруулбал, байгаль орчны хохирлыг байгаль орчны дүрмийн зорилго бүхий төрийн бус байгууллага нэхэмжилж болохыг батлан харуулсан, байгаль орчны хохирол тооцох тухай Байгаль орчны яам (хуучин нэрээр)—аас 2010 онд баталсан аргачлалыг шүүхэд анх удаа хэрэглэсэн, шүүхийн шийдвэрийн дагуу байгаль орчны хохирлыг гэм буруутай этгээдээс бодитойгоор гаргуулж чадсан, байгалийн нөөц баялаг олборлогч компаниуд байгаль орчны хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх ёстойг хатуу сануулж чадсан зэрэг байгаль орчны стратегийн өмгөөллийн салбарт олон сайн жишгийг тогтоож чадсан юм.

Мөн Тамсагийн сав газарт хийгдэж буй газрын тосны хайгуул, олборлолтын ажилд хяналт тавих, газрын тосны эрх зүйн орчныг боловсронгуй болгох, Бүтээгдэхүүн хуваах гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг төр засгийн анхаарлын төвд авчран Засгийн газрын 2011 онд баталсан газрын тос, уул уурхайн салбарт баримтлах үндсэн чиглэлд тусгуулж чадсан юм.

10. Эх сурвалж

- Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан <<http://shuukh.mn/irgenanhan/34029/view>>
- Байгаль хамгаалах иргэний хөдөлгөөнүүдийн эвсэл, “Байгаль орчны хохирол гаргуулах асуудлаарх стратегийн өмгөөллийн төслийн тайлан 2012”, УБ, 2013 он

3.2.4 Оршин суух газраа чөлөөтэй сонгох, ялгаварлан гадуурхалтаас ангид байх

1. **Нэхэмжлэгч:** ХЭҮК
2. **Хариуцагч:** Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
3. **Шийдвэрлэсэн шүүх, шүүхийн шийдвэрийн дугаар:** Чингэлтэй дүүргийн шүүхийн 344 дүгээр шийдвэр
4. **Нэхэмжлэлийн шаардлага**

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2000 оны 46 дугаар тогтоолыг хүчингүй болгуулах тухай.

5. Өмгөөллийн зорилго

Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 18 дахь заалтын “улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох”, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “ялгаварлан гадуурхагдахгүй байх” гэсэн заалтуудыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дээрх шийдвэр тус тус зөрчсөн тул зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, энэхүү эрх цаашид зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх.

6. Хэргийн танилцуулга

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2000 онд 46 дугаар тогтоол гаргаж, Улаанбаатар хотод шилжин ирж буй насанд хүрсэн иргэн тус бүрээс 50,000 төгрөг, 18 хүртэлх насны хүүхдээс

25,000 төгрөгийн хураамж авахаар шийдвэрлэжээ. ХЭҮК—оос 2002 онд явуулсан судалгаагаар, хэдийгээр нийслэлийн хүн амын хэт төвлөрлийг бууруулах, төрийн үйлчилгээний ачааллыг оновчтой хуваарилахад эерэгээр нөлөөлөх зорилготой гарсан ч НИТХ—ын уг шийдвэр нь хүний эрхийг зөрчсөн гэсэн дүгнэлтэд хүрчээ. Тодруулбал, НИТХ—ын дээрх тогтоол нь зорилгодоо хүрч чадаагүйн улмаас хөдөө орон нутгаас олон арван мянган хүн шилжин ирсээр байсан, дээрээс нь тэдгээр хотод шилжин ирж буй иргэдэд шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгэхэд хүндрэл учруулж, улмаар эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн үйлчилгээ авах зэрэг Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдлэх боломжийг хаасан байна. Энэ нь иргэдээ хөрөнгийн байдлаар нь ялгаварлан гадуурхаж буй хэрэг хэмээн ХЭҮК—ын 2002 онд явуулсан судалгаагаар тогтоожээ. Учир нь уг судалгаанд хотод шилжин ирсэн 18,000 иргэн хамрагдсаны 60 хувь нь хотод бүртгэл хийлгэж чадаагүй бөгөөд шалтгаан нь дээрх хураамж байв.

Улаанбаатар хотод шилжин ирснийхээ төлөө нэмэлт хураамж төлж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг буюу "... хөрөнгө чинээ ... ялгаварлан гадуурхаж үл болно ...", Арван зургадугаар зүйлийн 18 дахь заалт буюу "Монгол Улсын иргэн улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй", мөн Татварын ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1—д заасан "Татварыг зөвхөн Улсын Их Хурал хуулиар бий болгох ..." гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн хэмээн ХЭҮК үзжээ.

7. Хийгдсэн ажиллагаа

✓ Өмгөөллийн үйл ажиллагааны талаар

- ХЭҮК—оос НИТХ—ын дээрх тогтоолоос үүдэн Монгол Улсын иргэнд Үндсэн хуулиар олгогдсон "Эх орондоо чөлөөтэй зорчих, оршин суух газраа сонгох" эрх хэрхэн зөрчигдөж буйд томоохон судалгаа явуулан уг тогтоол нь хүний оршин суух газраа чөлөөтэй сонгох, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг зөрчсөн тухай дүгнэлт хийсэн.
- ХЭҮК нь Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1—д заасны дагуу "аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн

хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах" бүрэн эрхтэй тул өөрийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргасан.

✓ Шүүхийн шатанд

- ХЭҮК–оос 2003 оны 3–р сарын 5–ны өдөр Чингэлтэй дүүргийн шүүхэд хандан гомдол гаргаж, НИТХ–ыг хариуцагчаар татуулжээ.
- Анхан шатны шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангаж, НИТХ–ын шийдвэрийг хүчингүй болгосон.
- Хариуцагч давж заалдах гомдол гаргасан ба 2003 оны 5–р сарын 19–ний өдөр давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон.
- Нэхэмжлэгч хяналтын шатны шүүхэд гомдол гаргасан ба анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр нь баталсан.
- Хариуцагч Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гомдол гаргасан боловч гомдлыг хүлээн авах боломжгүй гэсэн хариуг өгсөн байна.

8. Өмгөөллийн үр дүн

Энэхүү өмгөөллийн үр дүнд Улаанбаатар хотод шилжин ирэгсэд Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдлэн, нэмэгдэл хураамжгүйгээр иргэний бүртгэл хийлгэх, улмаар төрийн үйлчилгээг авах эрх нь нээгдсэн. Түүнчлэн Дархан–Уул, Төв, Орхон аймгуудын удирдлагууд шилжин ирэгсдээс төлбөр авах тухай шийдвэрээ хүчингүй болгосон нь энэхүү стратегийн өмгөөллийн үр нөлөөний өргөн далайцтай байдлыг илтгэж байна. Хамгийн гол нь энэхүү өмгөөллийн үр дүнд төрийн байгууллага, албан тушаалтан хэн ч байсан иргэдийн Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон эрхийг зөрчиж үл болохыг шүүхийн шийдвэрийн үндсэн дээр тодорхой харуулж чадсан хэрэг болсон юм.

9. Эх сурвалж

Нээлттэй Нийгэм Форум, "Стратегийн өмгөөлөл: Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах нь" (Өмгөөлөгчдөд зориулсан гарын авлага), УБ, 2006 он.

3.2.5 Эрүүл, аюулгүй орчинд амьдрах

1. **Нэхэмжлэгч:** Хан–Уул дүүргийн 1–р хорооны иргэн Ц, Т нар

Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч: Үндэсний “Соёмбо” хөдөлгөөний хуульчид

2. **Хариуцагч:** Нийслэлийн Засаг дарга

3. **Шийдвэрлэсэн шүүх, шүүхийн шийдвэрийн огноо, дугаар:**

- Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн 2009 оны 1–р сарын 23–ны өдрийн 49 дүгээр шийдвэр
- Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын 2009 оны 4–р сарын 1–ний өдрийн 105 дугаар магадлал
- Улсын дээд шүүхийн 2009 оны 6–р сарын 22–ны өдрийн тогтоол.

4. **Нэхэмжлэлийн шаардлага**

Нийслэлийн Засаг даргын 2004 оны 10–р сарын 6–ны өдрийн 455 дугаар захирамжийн А, Ч нарт холбогдох хэсгийг хүчингүй болгуулах тухай.

5. **Өмгөөллийн зорилго**

Нийтийн эзэмшлийн газарт холбогдох хууль, дүрэм, журам, норм, стандартыг зөрчин нийтийн зориулалттай орон сууцны цонхыг хаан барилга барьснаас байгалийн гэрлийг нь хааж, оршин суугчдынх нь эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх ноцтой зөрчигдөж байгаа явдал төв, суурин газруудад түгээмэл тохиолдож байна. Нийтийн зориулалттай орон сууцны оршин суугчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилтийг хангах үүднээс газар, барилга гэх мэт салбарын хууль, дүрэм, журам, норм, стандарт нэлээдгүй байгаа ч тэдгээрийн хэрэгжилт хангалтгүй байна. Иймд Улаанбаатар хотын оршин суугчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчин газар эзэмшүүлэх эрх олгож буй төрийн байгууллага, албан тушаалтнуудын хууль зөрчсөн үйлдэл, түүнээс үүдсэн хүний эрхийн зөрчлийг төр засаг, олон нийтийн сонорт хүргэх, эл зөрчлийг дахин гаргуулахгүй байх, энэ чиглэлийн өмгөөллийн жишиг тогтоох үүднээс энэ хэрэг дээр Үндэсний “Соёмбо” хөдөлгөөн ажилласан байна.

6. Хэргийн танилцуулга

Иргэн Б нь анх нийслэлийн Засаг даргын 2002 оны 12–р сарын 27–ны өдрийн 558 дугаар захирамжаар Хан–Уул дүүргийн 1–р хорооны нутагт орших 490 м.кв газрыг контор, зочид буудлын зориулалтаар авсан бөгөөд иргэн А болон Ч нар нь нийслэлийн Засаг даргын 2004 оны 10–р сарын 6–ны өдрийн 455 дугаар захирамжийн дагуу уг газрыг шилжүүлэн авсан байна. Ийнхүү шилжүүлэн авахдаа анх олгосон 490 м.кв газрын хэмжээг нэмэгдүүлэн 1320 м.кв болгон авчээ.

Тийнхүү нэмэгдүүлэн авсан газар нь орон сууцны 14, 15–р байруудын дунд байрладаг бөгөөд А компани нь эдгээр байрны дунд 13 давхар зочид буудлын барилга барьсан нь хоёр байрны хананаас 75 см, урд талаас нь 6.9м зайд байрлажээ. Ингэснээр 1, 2–р давхрын дөрвөн айлын цонхоор нарны гэрэл орох боломжийг бүрэн хааж, 3, 4–р давхрын айлуудын цонхоор нарны гэрэл орох боломжийг хагас хаасан байна.

Тийнхүү барилга барьж эхэлснээр орчны тоос шороо, дуу чимээнээс болж оршин суугчид цонхоо байнга хаалттай байлгах болсноор агаарын солилцоо муудаж, хүйтэн чийгнээс үүдэн хананд нь мөөгөнцөр үүсч эхэлсэн байна. Улмаар ийм эрүүл бус орчинд амьдарснаас оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж эхэлжээ. Мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр байгалийн гэрэлтүүлгийн коэффициентийн эрүүл ахуйн норм 1.25–аас багагүй байх ёстой атал энэ байрын үзүүлэлт нь 0.03–0.175 хувь байгаа нь тогтоогджээ.

Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 2–т заасан “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх”, Арван есдүгээр зүйлийн 3–т заасан “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож болохгүй” гэсэн хүний суурь эрхүүдийг ноцтойгоор зөрчиж байна гэж үзэж оршин суугчдын төлөөлөл нийслэлийн Засаг даргын дээрх захирамжийг хүчингүй болгуулахаар Нийслэлийн захиргааны хэргийн шүүхэд хандсан байна.

7. Хийгдсэн ажиллагаа

✓ Хэрэг үүсгүүлэх бэлтгэл ажиллагаа

- Холбогдох хууль тогтоомжийг нарийвчлан судлах ажиллагаа хийгдсэн.

- Хэргийн нэхэмжлэгчийг сонгохдоо эрх нь зөрчигдсөн гэж үзэж буй арав гаруй оршин суугчтай уулзаж ярилцан эрх нь хамгийн ноцтой зөрчигдсөн буюу тухайн орон сууцны 1–р давхарт амьдардаг хоёр иргэнийг сонгосон.
- Нотлох баримтаа нэхэмжлэгчидтэйгээ хамтран цуглуулсан. Нэхэмжлэгчдийн “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх”-ийн зөрчлийг нотлохын тулд Улсын мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн дүгнэлт, Онцгой байдлын ерөнхий газрын гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн дүгнэлт, орон сууцуудын хоорондын зайг хэмжсэн шинжээчийн хэмжилтийн зураглал зэрэг гол гол баримт материалуудыг холбогдох байгууллагаар гаргуулсан.
- Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу захиргааны хэрэг урьдчилан хянан шийдвэрлэх ажиллагаа хангагдсан.

✓ **Нөлөөллийн ажил**

Шүүхэд хэрэг үүсгүүлэн ажиллаж буй явц болон шүүхийн шийдвэр, түүний хэрэгжилтийн асуудлаар олон нийт, төр засгийн сонорт хүргэх зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол мэдээлсэн.

✓ **Шүүхийн шатанд**

- Нийслэлийн захиргааны хэргийн шүүх 2009 оны 1–р сарын 23–ны өдөр хуралдаж, 49 дүгээр шийдвэрээрээ нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн.

Шүүхээс “Нийслэлийн Засаг дарга газар эзэмшүүлэх эрхийг шилжүүлсэн шийдвэр гаргахдаа өмнө нь иргэн Б–д олгосон газрын хэмжээг үндэслэлгүйгээр нэмэгдүүлэн 1320 м.кв болгон олгосон нь Газрын тухай хуулийн 33.1.2–т заасан “хуульд заасан хэмжээнээс илүү газар эзэмшүүлэх хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх асуудлыг тухайн шатны Засаг дарга дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ” гэсэн заалтыг зөрчсөн, түүнчлэн нэхэмжлэгчдийн “эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх нь зөрчигдөж буй нь нотлогдсон” гэжээ. Тодруулбал, “Баригдсан 13 давхар барилга ба оршин суугчдын 14, 15–р байрын хоорондох

зай нэхэмжлэлд дурдсанчлан ойрхон байгаа нь Барилгын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.1.4 дэх заалт, Дэд бүтцийн сайдын 2004 оны 6–р сарын 30–ны өдрийн 130 дугаар тушаалаар батлагдсан Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрмийн 2.1 дэх заалт (4 давхраас дээш барилгын тууш талуудын хоорондох зай 20 м–ээс багагүй байх), мөн дүрмийн 9.1.9 дэх заалт (Орон сууц, иргэний барилга байгууламжийн цонхоор хавар, зун, намрын улирлын нэг өдөрт тусах нарны тусгалын үргэлжлэх хамгийн бага хугацааны нийлбэр нь уур амьсгалын 1, 2–р бүсэд 3 цаг, уур амьсгалын 3, 4–р бүсэд 2,5 цаг байхаар тооцож төлөвлөнө)–ыг зөрчсөн нь нотлогдож байна" гэжээ.

- Хариуцагч А нь анхан шатны шүүхийн шийдвэрийг үл зөвшөөрч, давж заалдах гомдол гаргасныг Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимаас 2009 оны 4–р сарын 1–ний өдөр хянан хэлэлцээд анхан шатны шүүхийн шийдвэрийг 105 дугаар магадлалаар хэвээр нь баталсан байна.
- Мөн гуравдагч этгээдээс хяналтын журмаар гомдол гаргасныг Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар 2009 оны 6–р сарын 22–ны өдөр хянан хэлэлцээд өмнөх шийдвэр, магадлалыг хэвээр нь баталжээ.

8. Шүүхийн шийдвэрийн хэрэгжилт

- Шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор нэхэмжлэгч, түүний өмгөөлөгч нь нийслэлийн Засаг дарга, Нийслэлийн газрын алба, Нийслэлийн барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газар, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газарт удаа дараа хандсаны үр дүнд нийслэлийн Засаг дарга 2009 оны 3–р сарын 1–ний өдөр 80 дугаар захирамж гарган үүгээрээ шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авахыг дээрх газруудад даалгасан ч шийдвэр хэрэгжээгүй.
- 2010 оны 3–р сард нэхэмжлэгч Т нь нийслэлийн Засаг даргад холбогдуулан “Газар чөлөөлөх мэдэгдэл гаргахгүй байгаа явдал нь хууль бус болохыг тогтоож, шаардагдах захиргааны акт гаргахыг даалгахыг хүссэн” нэхэмжлэлийг Нийслэлийн захиргааны хэргийн шүүхэд гаргасан.

- 2010 оны 4–р сарын 16–ны өдөр Нийслэлийн захиргааны хэргийн шүүх хуралдаж 180 дугаар шийдвэрээрээ “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 дахь заалтын ж/, 29.1.6 дахь заалтын а/–д заасны дагуу 80 дугаар захирамжийнхаа биелэлтийг хангах арга хэмжээг зохион байгуулж, хяналт тавих үүргээ биелүүлээгүй орхигдуулсан эс үйлдэхүйг хууль бус болохыг тогтоож, дээрх шийдвэрийг биелүүлэх арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавих”–ыг даалгасан байна.
- Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн 2010 оны 4–р сарын 16–ны өдрийн 180 дугаар шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор мөн шүүхийн шүүгчээс “Шийдвэр албадан гүйцэтгүүлэх тухай” 1003 дугаар захирамж, 42 тоот Гүйцэтгэх хуудсыг 2010 оны 8–р сарын 2–ны өдөр тус тус гаргасан.
- Ийнхүү нийслэлийн Засаг дарга “Газрыг албадан чөлөөлөх тухай” 2011 оны 1–р сарын 17–ны өдрийн 33 дугаар захирамж гарган уг захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг нийслэлийн Засаг даргын орлогч, Нийслэлийн цагдаагийн газар, Нийслэлийн газрын алба, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газарт тус тус даалгасан ч өнөөг хүртэл газар албадан чөлөөлөгдөөгүй байна.
- Газар албадан чөлөөлөх үйл явцыг удаашруулж буй, төрийн байгууллага хоорондын ажлын уялдаа холбоо сул, хоорондоо харилцахад хугацаа ихээр шаарддаг зэрэг олон сөрөг хүчин зүйлс байгаагаас хамгийн ноцтой нь 13 давхар барилгыг нураах стандарт Монгол Улсад байхгүй талаар хариуцсан албан тушаалтнууд онцолж байгаа юм.

9. Өмгөөллийн үр дүн

Хүн ам олноор суурьшсан төв суурин газарт нийтийн зориулалттай орон сууцанд оршин суугч иргэдийн “эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх”–ийн зөрчилтэй хэрэгт стратегийн өмгөөллийн сайн жишиг тогтоож өгсөн.

Оршин суугчдын “эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх”–ийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилт маш хангалтгүй байгааг батлан, хууль хэрэгжүүлэгч байгууллага, албан тушаалтнуудын сонорт хүргэж чадсан.

Хэдийгээр нэхэмжлэгчид шүүхэд ялалт байгуулсан ч, шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх шатанд процессын болон бусад холбогдох хууль тогтоомж (тухайлбал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, барилгын зарим хууль, стандартын доголдолтой сул талыг илрүүлэн гаргаж ирсэн) –ийг боловсронгуй болгох бодит шаардлага байгааг харуулсан. Түүнчлэн, “эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх” –ийг зөрчигдсөний дараа биш, харин зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх нь юу юунаас чухал болохыг оршин суугчид, хууль хэрэгжүүлэгчид, хуульчдад ойлгуулж өгснөөрөө ач холбогдолтой хэрэг болсон.

Энэхүү стратегийн өмгөөлөлд анхаарвал зохих байсан асуудал нь хэргийн нааштай сайн шийдвэр, жишгийг олон нийтэд таниулах, сурталчлах ажлыг илүү өргөн хүрээнд хийж, бусад адил төстэй тохиолдлуудад сайн практик болох явдал байсан. Өөрөөр хэлбэл, стратегийн өмгөөллийн үр дүн буюу шүүхийн шийдвэр, түүний хэрэгжилтийг цогцоор нь төлөвлөн ажилласан бол тус хэргээс нийгэмд хүртэх үр өгөөж нь илүү бодитой байх байсныг энэ хэрэг харуулж байна.

10. Эх сурвалж

Үндэсний “Соёмбо” хөдөлгөөн, “Улаанбаатар хот дахь нийтийн зориулалттай орон сууцанд оршин суугчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн асуудлаарх стратегийн өмгөөллийн төслийн үйл ажиллагааны тайлан 2011”, УБ, 2012 он

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол хэлээр

Байгаль орчны хуульчдын холбоо, "Стратегийн өмгөөллийн үйл ажиллагааны тайлан 2012", УБ, 2013 он

Байгаль хамгаалах иргэний хөдөлгөөнүүдийн эвсэл, "Байгаль орчны хохирол гаргуулах асуудлаарх стратегийн өмгөөллийн төслийн тайлан 2012", УБ, 2013 он

Б.Баярмаа, "Нийтийн эрх ашгийг хамгаалахад ТББ-уудад учирч буй бэрхшээл" (2012 оны 4 сар) <<http://forum.mn/Events/StrategyLitigation/Bayarmaagiin%20iltgel.pdf>>;

Д.Ганзориг, "Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх", Хүний эрх сэтгүүл (ХЭҮК) 2005 он, дугаар 4

Даггин, Жилиан, "Нийтийн эрх ашгийн өмгөөлөлд санхүүжилт олох боломж", Өмгөөлөгч сэтгүүл (Монголын Өмгөөлөгчдийн Холбоо) 2010 он, дугаар 1

Зориг сан, "Шилжин суурьшигчдын эрхийг хамгаалах асуудлаарх стратегийн өмгөөллийн төслийн тайлан 2010, УБ, 2010 он

Монголын төрийн бус байгууллагуудын форум, "Хүний эрхийн ээлжит дүгнэлт хэлэлцүүлгийн нэгдсэн тайлан" (2010 оны 4 сар) <<http://www.upr-mongolia.mn/images/xupld/Negdsen%20iltgel.pdf>>

НҮБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар дахь хүний эрхийн баг болон ХЭХТ, "Үндэсний хэмжээн дэх уул уурхай болон хүний эрхийн хэлэлцүүлэг", УБ, 2006 он

Нээлттэй Нийгэм Форум, "Стратегийн өмгөөлөл: Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах нь" (Өмгөөлөгчдөд зориулсан гарын авлага), УБ, 2006 он

П.Оюунчимэг, "Хүний эрхийн үндэсний байгууллагаас шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргаж байгаа өнөөгийн нөхцөл болон гарч буй хүндрэлүүд", "Нийтийн эрх ашгийг шүүхээр нэхэмжлэн хамгаалах нь" Олон улсын хуралд тавигдсан илтгэл, УБ, Их тэнгэр, 2012 он

Б.Хишигсайхан, Д.Эрдэнэчимэг, "Хүний эрх, НҮБ, Сэтгүүлч" (Сэтгүүлчдэд зориулсан гарын авлага) УБ, 2010

Хүний эрхийн Үндэсний Комисс, "Хүрээлэн буй орчин ба нийтийн эрх", Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний 2007 оны байдлын талаарх илтгэл, 2008 он, дугаар 7

Хүний эрх хөгжил төв, "Хүн худалдаалах гэмт хэрэг: Асуудал ба арга зам", УБ, 2003 он

Хүний эрх хөгжил төв, "Байгаль орчны өмгөөлөл", Мэдээллийн хуудас, 2008 он, дугаар 1

Хүний эрх хөгжил төв, "Байгаль орчны өмгөөлөл", Мэдээллийн хуудас, 2010 он, дугаар 8

Хүний эрх хөгжил төв, "Байгаль орчны асуудлаар шийдвэр гаргахад олон нийтийн оролцоо", Судалгааны тайлан, УБ, 2010 он

Хүний эрх хөгжил төв, "Нийтийн эрх ашгийг нэхэмжлэх эрхийг нээлтэй болгох нь", Судалгааны тайлан, УБ, 2010 он

Хүний эрх хөгжил төв, Америкийн хуульчдын холбоо болон Н.Туяа, "Хэрэг судлал: Хүн худалдаалах гэмт хэрэг ба өмгөөлөл" (Хуульчдад зориулсан гарын авлага), УБ, 2012 он

Хүний эрх хөгжил төв, "Хүний эрхийн нөлөөллийн хөтөлбөрийн тайлан 2009" (2010 оны 2 сар) <www.chrd.org.mn>.

Хүний эрх хөгжил төв, "Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хөтөлбөрийн тайлан 2012" (2013 оны 12 сар) <www.chrd.org.mn>.

Хүний эрх хөгжил төв, "Хүн худалдаалах гэмт хэргийн гэрч/хохирогчийг хамгаалах стратегийн өмгөөллийн төслийн тайлан 2012", УБ, 2013 он.

Үндэсний "Соёмбо" хөдөлгөөн, "Улаанбаатар хот дахь нийтийн зориулалттай орон сууцанд оршин суугчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн асуудлаарх стратегийн өмгөөллийн төслийн үйл ажиллагааны тайлан 2011", УБ, 2012 он

Ц.Цогт, "Байгаль орчныг хамгаалах асуудалд Захиргааны хэргийн шүүхийн гүйцэтгэх үүрэг, оролцоо" (2013 оны 5 сар) <<http://tsogt.blogmn.net/98378/baigali-orchniig-hamgaalah-asuudald-zahirgaanii-hergiin-shuuhiin-guitsetgeh-uureg-oroltsoo.html>>

Ц.Цогт, "Захиргааны хэргийн шүүх-хүний эрх", Хүний эрх сэтгүүл (ХЭҮК) 2005 он, дугаар 4.

Гадаад хэлээр

Айч Вильсон, Стивен, "Улаан арьстнууд цагаан арьстнаас олон болох нь: Мексик гаралтай Америкчууд, Хууль зүйн маргаан буюу өмгөөлөл хийх стратеги", Бостон, 2003 он

А.Голдстон, Жэймс, "Төв болон Зүүн Европын улс орнууд дахь нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах нь: Асуудал ба арга замууд", Хүний эрх сэтгүүл, 2006 он, боть 28, дугаар 2

Австрали Улсын Эрх зүйн шинэтгэлийн хороо, "Нийтийн эрх ашгийг нэхэмжлэх эрх", Канберра, 1996 он

Б.Батхишиг, Монгол Улс дахь нийтийн эрх ашгийн өмгөөлөлд тулгамдаж буй асуудлууд: Австрали Улсын туршлагаас судлах нь, Судалгааны ажил, Брисбэйн, 2013 он

Бензинг–Балзер, Сабина "Стратегийн өмгөөллийн тухай танилцуулга: Нийтийн сан", 2013 он

Боловсролын хуулийн төв, "Нью–Йорк мужийн захиргааны эсрэг Боловсролын хуулийн төвийн нэхэмжлэлтэй хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр" <<http://www.edlawcenter.org/assets/files/pdfs/cfe/CFE%202001%20Decision.pdf>>

Д.И.Фишер, "Австрали Улсын Байгаль орчны хууль: Хэм хэмжээ, зарчим ба зохицуулалт", Сидней, 2010 он.

Меллор, Тим "Нийтийн эрх ашгийг нэхэмжлэх нээлттэй эрх", Австрали дахь Хуулийн хүрээлэнгийн сэтгүүл, 2011 он, дугаар 33 (9).

Нийтийн эрх ашгийг хамгаалах хуулийн санаачилга болон Будапештийн Колумбын Их сургуулийн дэргэдэх Хуулийн төв, "Нийтийн төлөөх бодлого нөлөөлөл: Стратегийн өмгөөлөл ба олон улс дахь нөлөөллийн тухай" (2003 оны 8 сар) <http://www.essex.ac.uk/armedcon/story_id/000698.pdf>.

Нийтийн эрх ашгийн хуулийн холбоо, "Нийтийн эрх ашгийн өмгөөллийн үндсэн асуудлууд" (2013 оны 12 сар) <<http://www.pila.ie/key-issues/public-interest-litigation/>>.

Орон байрын эрхийн төв, "Эдийн засаг, нийгэм, соёлын эрх: Шилдэг хэргүүдийн эмхтгэл", Баримт бичгийн цуврал 7, 2009 он <http://www.cohre.org/sites/default/files/leading_esc_rights_cases_24_april_2009.pdf>

Оюуны бэрхшээлтэй иргэдийн төлөөх байгууллага, "ОХУ–ын Засгийн газрын эсрэг Штукатуровын нэхэмжлэлтэй хэргийн ЕХЭШ–ийн шийдвэр" <www.mdac.info/en/content/shtukaturov-v-russia-judgment>

Рекош, Эдвин, "Бодлогын нөлөөлөл: Стратегийн өмгөөлөл, олон улсын хэмжээнд нөлөөлөх нь", Колумбын Их сургуульд тавьсан илтгэл, Нью–Йорк, 2003 он

Рекош, Эдвин, Кайра А.Бучко болон Вессела Терзева, "Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах нь" (Хуульчид, идэвхтнүүдэд зориулсан гарын авлага), Нью-Йорк, 2001 он

Рийдинг, Петер, "Стратегийн өмгөөлөл ба түүний ач холбогдол: Их Британи Улсын туршлага" (2010 оны 7 сар) <http://www.equineteurope.org/the_importance_of_strategic_litigation_010710final_1.ppt>

Хершков, Хелэн "Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах нь: Сонгогдсон асуудал болон туршлага" (2013 оны 12 сар) <<http://siteresources.worldbank.org/intlawjustinst/resources/publicinterestlitigation%5b1%5d.pdf>>

Хүүхдийн Эрхийн Мэдээллийн Сүлжээ, "Хүүхдийн эрх: Стратегийн өмгөөлөл хийх удирдамж", Лондон, 2009 он

Чаяес, Абрам, "Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах ажиллагаан дахь шүүгчийн байр суурь", Хууль зүйн сэтгүүл (Харвардын Их сургууль) 1976 он, дугаар 89.

Эмэгтэйчүүдийн эрхийн хэрэгжилтийг хянах Ази, Номхон Далайн бүс нутгийн байгууллага, "Эмэгтэйчүүд эдийн засаг, нийгэм соёлын эрхээ нэхэмжлэх нь", Куала Лумпур, 2013 он

Вэб хуудас

Австрали Улсын Хууль зүйн сайд <http://www.ag.gov.au> .

Америкийн хуульчдын холбоо <www.americanbar.org>.

Байгаль орчны хуульчдын холбоо <www.e-law.org>.

Википедиа цахим толь <<http://en.wikipedia.org/wiki/Strategy>>

Интеррайтс<www.interights.org>.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

<<http://www.mn-nhrc.org>>

Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан

<<http://shuukh.mn>>

Нийтийн эрх ашгийн хуулийн Дэлхий нийтийн Сүлжээ

<www.pilnet.org>

Нээлттэй Нийгэм Форум <www.forum.mn>

Нээлттэй Нийгэм Хүрээлэн<www.opensocietyfoundations.org>

Эмнести Интернэшнл<www.amnesty.org>

Хүний эрхийн дээд комиссарын газар <www.ohchr.org>

Хүний эрх хөгжил төв <www.chrd.org.mn>

